ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ • 2020 ОНЫ 12-Р САР

Лиахона

Яагаад Есүс Христ бидэнд хэрэгтэй вэ,

12-р хуудас

Томилогдсон тохинуулал тань таны сэтгэлийг хөндөх үед,
18-р хуудас

Өөрсдийгөө орхигдсон мэт мэдэрдэг хүмүүст Христ хайраа хэрхэн үзүүлсэн талаар,
24-р хуудас

Бурханы хайрын бэлгийг хүлээн авах 4 арга зам,
28-р хуудас



СҮМ
ЭНД
БИЙ

Бразил

Рио Де Жанейро



Рио Де Жанейро бол Бразил дахь Сүмийн хүч чадлын олон төвийн нэг юм. Удахгүй Риод ариун сүмийг онцгойлон адислах болно. Бразил дахь Сүмийн тухай зарим мэдээ баримтыг доор харуулав.

1.4 сая гишүүн (151 бразил хүн тутмын нэг нь буюу нийт хүн амын 0.67 хувь нь хожмын үеийн гэгээнтэн)

273 гадас

2111 цуглаан

355 гэр бүлийн түүхийн төв

6 ариун сүм

35 номлол

A IGREJA DE JESUS CRISTO DOS SANTOS DOS ÚLTIMOS DIAS

1929 Бразилын анхны хөрвөгчид

1966 Анхны гадас Сао Паулод байгуулагдсан

1978 Өмнөд Америкт баригдсан анхны ариун сүм болох Бразилын Сао Пауло ариун сүмийг онцгойлон адисалсан

2001 Халамжийн нийгэмлэгийг улсын засгийн газраас хүндэтгэн өргөмжилсөн



Христийн мэндэлсний баяраар Аврагчийн гэрлийг хуваалцах нь
8

Бүх хүнд тохинуулах нь
Ричард Нийтээл Холзапфэл
18

Бэлэг хүлээн ав
Иакоб Р.Жөүнс
28

Яагаад Есүс Христ бидэнд хэрэгтэй вэ?
Ахлагч Д.Тодд Кристоффэрсон
12

Сайн мэдээ: Өөрчлөлтийн үеийн зангуу

2020 онд бид байгалийн гамшиг, дэлхий дахиныг хамарсан цар тахалтай нүүр тулсан. Бид *Ирээд, Намайг дага* суралцах материалаар дамжуулан хол ойрын ах эгч нартайгаа хамт Мормоны Номыг судаллаа. Бид дэлхий даяар мацаг барьж, итгэл үнэмшлээрээ нэгдсэн.

Хувьсан өөрчлөгдөж буй дэлхий ертөнцөд бид өөрсдийн Аврагч, Есүс Христэд болон Түүний сэргээгдсэн сайн мэдээнд зүрх сэтгэлээ зангуудан тогтоож чадна. Бид энэ дугаарын эдгээр болон бусад өгүүлэл Христийн мэндэлсний баярын сүнсийг буюу Их Эзэний Сүнсийг мэдрэхэд тань тусална гэдэгт итгэлтэй байна. Үүнд:

- Ахлагч Д.Тодд Кристоффэрсон бидэнд Аврагч яагаад хэрэгтэй болохыг заасан (12-р хуудсыг үзнэ үү).
- “Христийн мэндэлсний баяраар Аврагчийн гэрлийг хуваалцах нь” хэсэгт бид Христийн мэндэлсний баяраар тохинуулах хэдэн санааг санал болгосон (8-р хуудсыг үзнэ үү).
- Иакоб Жөүнс Ариун Сүнсний бэлгийг амьдралдаа урин авчрахын тулд Их Эзэнд бидний өгч болох дөрвөн бэлгийн талаар бичив (28-р хуудсыг үзнэ үү).
- Тэргүүн Зөвлөл энэ оны эхээр, дараа сараас эхлэн насанд хүрэгчид, өсвөр үеийнхэн, хүүхдүүд тус бүрд зориулсан Сүмийн нийт гурван шинэ сэтгүүл хэвлэн гаргахаар баталсан. Эдгээр сэтгүүл хэдэн арван хэл дээр гарах бөгөөд сайн мэдээг дэлхийн өнцөг булан бүрд байх хожмын үеийн гэгээнтнүүдэд хүргэх болно. Эдгээр шинэ сэтгүүлээр дамжуулан бид Их Эзэний үйлчлэгчдээрээ дамжуулан хүргэсэн дуу хоолойг сонсох ба Сүмийн гишүүд дэлхий даяар бие биетэйгээ холбогдох юм. (Дэлгэрэнгүй мэдээллийг 6-р хуудаснаас үзнэ үү.)

Лиахона сэтгүүлийн ажилтнуудын зүгээс Христийн мэндэлсний баярын мэнд хүргэе!

Агуулга

5 Та дэлхийг гэрэлтүүлж чадна ⏱

6 Гурван шинэ сэтгүүлээ тэсэн ядан хүлээж байна
Дараа жил *Лиахонад* оруулах сэтгэл хөдлөм өөрчлөлтүүд

8 Тохинууллын зарчмууд
Христийн мэндэлсний баяраар Аврагчийн гэрлийг хуваалцах нь
Христийн мэндэлсний баярын өдрүүд бидэнд онцгой арга замаар тохинуулах боломж олгодог.

12 Яагаад Есүс Христ бидэнд хэрэгтэй вэ?
Ахлагч Д.Тодд Кристоффэрсон
Энэ Христийн мэндэлсний баярын өдрүүдэд дуу шуугианыг багасгаж, Бурханы Хүү дээр төвлөр.

18 Бүх хүнд тохинуулах нь
Ахлагч Ричард Нийтзэл Холзапфэл
Бусдад хэрхэн энгийн, ердийн арга замаар тохинуулах вэ?

24 Ойртон очих: Аврагчийн адил хайрлах нь
Бэки, Бэннэтт Бордэн
Бид Аврагчийн бусадтай харилцаж байсан үлгэр жишээнээс ихийг сурч чадна.

28 Бэлэг хүлээн ав
Иакоб Р.Жөүнс
Христийн мэндэлсний баярын жинхэнэ бэлэг болох Бурханы хайрыг мэдрэх 4 арга зам

32 Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой ⏱
Францад дүрвэгчид болон орон гэргүй хүмүүст туслах нь, шоронд хариулагдсан залбирлуудыг санах нь, аравны нэг төлөхийг сонгох нь, гунигтай сүнслэг мэдрэмж хүлээн авах нь.

36 Ирээд, Намайг дага: Мормоны Ном 📖 ⏱
Долоо хоног тутмын эдгээр нийтлэл энэ сард Мормоны Номоос судлах үйл явцыг тань дэмжих болно.

40 Би хүүхдүүдтэйгээ сайн мэдээний талаар энгийн байдлаар хэрхэн ярилцах вэ?
Сайн мэдээний талаар ярилцахдаа албархаг, ёсорхуу байх шаардлагагүй.

⏱ Богино өгүүллүүд

📖 *Ирээд, Намайг дага* дэмжлэг

Хавтсан дээр
Нялх Есүсийг өхөөрдсөн нь,
Матиас Стомэр,
Bridgeman Images.



Хэсгүүд

Залуучуудад зориулав
42
Бусдыг шударга бусаар шүүмжлэх эсвэл өөрийгөө бусадтай харьцуулах юм бол олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бидэнд хор хөнөөл учруулж болно. Бид хэрхэн **олон нийтийн мэдээллийн хэрэгслийг** сайн нөлөө болгож чадах тухай суралцаарай.



Өсвөр үеийнхэнд зориулав
50
Сэтгэлээр унаж, дараа нь **Христийн мэндэлсний баяраар адислагдав**, хэдэн өсвөр үеийнхэн өөрсдийн хүлээн авсан **сүнслэг бэлгүүдийнхээ** талаар хуваалцав, хиймэл гэрлүүд биднийг **Христийн Гэрлээс** холдуулж болно, **Моронайн туршлагууд** бидэнд амьдралын сургамжийг заадаг.

Хүүхдүүдэд зориулав
Найз
Бидний өгч бас хүлээн авч болох **бэлгүүдийн** тухай суралц.

12-Р САРД ЗӨВХӨН ЦАХИМ ХУВИЛБАРААР ГАРАХ НИЙТЛЭЛҮҮД

Аравны нэгийн чимээгүй адислалууд
Кимберли Жэнсэн

Аравны нэгийн адислалууд жижигхэн болович хүчирхэг байх нь олонтоо.

Христтэй холбогдох замаар ганцаардалтай тэмцэх нь
Кайли Парриш

Нэг залуу зарим үед ганцаардуулдаг энэ улирлаар хэрхэн Аврагчид төвлөрч болох талаар бодлоо хуваалцав.



***Ирээд, Намайг дага* гарын авлагыг бие даан судлахад хэцүү байна уу? Шинэ жилд зориулсан хэд хэдэн тустай арга**
Аннэлис Гарднэр

Нэг залуу *Ирээд, Намайг дага* гарын авлагыг бие даан судалж байхдаа, хэрхэн илүү ихийг сурч болох талаар бодлоо хуваалцав.

ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД

Та Gospel Library аппликэйшнээс болон liahona.ChurchofJesusChrist.org вэбсайтаас дараах зүйлсийг олж болно. Үүнд:

- Энэ дугаарыг ол.
- Зөвхөн цахим хувилбараар гарах агуулгыг унш.
- Өмнөх дугааруудаас хай.
- Өөрийн түүх, санал хүсэлтийг илгээ.
- Сэтгүүл захиал эсвэл бусдад бэлэг болгон захиалж өг.
- Цахим хэрэгслийн тусламжтайгаар суралцах үйл явцаа сайжруул.
- Таалагдсан нийтлэл, видео бичлэгээ хуваалц.
- Нийтлэлүүдийг татаж ав эсвэл хэвлэ.
- Дуртай нийтлэлүүдээ сонс.

БИДЭНТЭЙ ХОЛБОО БАРИХ

Асуулт, санал хүсэлтээ liahona@ChurchofJesusChrist.org хаяг руу илгээнэ үү.

Өөрийн түүхийг liahona.ChurchofJesusChrist.org вэб-сайт руу эсвэл доорх хаягаар шуудангаар илгээнэ үү.
Liahona, flr. 23
50 E. North Temple Street
Salt Lake City, UT 84150-0023, USA

2020 ОНЫ 12-Р САРЫН ДУГААР
БОТЬ 21, №6
ЛИАХОНА 16727 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Рассэлл М.Нэлсон, Даллин Х.Өүкс, Хэнри Б.Айринг

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга: М.Рассэлл Баллард, Жэффри Р.Холланд, Дийтр Ф.Угдорф, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Күк, Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн, Роналд А.Расбанд, Гари И.Стивэнсон, Дэйл Г.Рэнланд, Гэррит В.Гонг, Улиссэс Соарэс

Эрхлэгч: Рэнди Д.Фанк

Зөвлөхүүд: Бэкки Кравэн, Шэрон Эубанк, Кристина Б.Франко, Уолтэр Ф.Гонзалэз, Ларри С.Кэйчэр, Жан Э.Ньюмэн, Адриан Очао, Майкл Т.Ринвүүд, Верн П.Стэнфилл

Гүйцэтгэх захирал: Ричард И.Хийтон

Сүмийн сэтгүүлийн захирал: Аллан Р.Лойборг

Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Адам С.Олсон

Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр

Хэвлэлийн туслах: Камилла Кастрион

Редакцийн баг: Дэвид Диксон, Дэвид А. Эдвардс, Маттью Д.Флиттон, Гаррэтт Х. Гарфф, Жон Райн Жэнсэн, Аарон Жонстон, Шарлотт Ларкэбэл, Майкл Р. Моррис, Эрик Б.Мөрдок, Жошуа Ж. Пэркий, Жан Пинбороү, Ричард М.Ромни, Минди Сэлү, Лори Фүллэр Соса, Чакэлл Вардлэй, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер: Ж.Скотт Кнудсэн

Зургийн дарга: Тадд Р.Пэтэрсон

Уран бүтээлийн ажилтнууд: Жинэтт Эндрьюс, Фэй П.Андрус, Мэндий Бэнтли, С.Кимбалл Ботт, Томас Чайлд, Жошуа Дэннис, Дэвид Грийн, Коллийн Хинкли, Эрик П.Жонсэн, Сюзан Лофгрэн, Скотт М.Моой, Алэни Рэжэр, Марк В.Робисон, К.Никол Вокэнорст

Оюуны өмчийн зохицуулагч: Коллэтт Нэбэкэр Аун

Хэвлэлийн менежер: Аммон Харрис

Хэвлэх баг: Ира Глэн Адэйр, Жюли Бөрдэтт, Жосэ Чэвиз, Брайн В.Гайги, Жинни Ж.Нилсон, Мэррисса М.Смит

Хэвлэлийн эх бэлтгэгч: Жошуа Дэннис, Аммон Харрис

Хэвлэлийн захирал: Стивэн Т.Льюис

Хуваарилалт хариуцсан захирал: Трой Р.Баркэр

Нэгдсэн Улс, Канадаас бусад орон дахь захиалга болон үнийн талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт liahona.ChurchofJesusChrist.org руу; шуудангаар *Liahona,* Fl. 23, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0023, USA хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ChurchofJesusChrist.org хаягаар ирүүлнэ үү.

Лиахона (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин" буюу "залагч") нь албани, англи, армен, бислам, болгар, вьетнам, гайти, герман, грек, дани, индонез, ирланд, испани, итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл, монгол, нидерланд, норвеги, орос, польш, португал, румын, свахили, самоа, себү, словени, солонгос, сингал, тагалог, тай, тамил, тахити, телуг, тонга, украйн, унгар, урду, фижи, фин, франц, хинди, хорват, хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2020 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Зохиогчийн эрхийн талаарх мэдээлэл: Өөрөөр заагаагүй бол хувь хүмүүс арилжааны бус зорилгоор (Сүмийн дуудлага зэрэг) хувийн хэрэгцээндээ *Лиахонагаас* материал хувилан авч, ашиглаж болно. Энэ эрх ямар ч үед өөрчлөгдөхгүй. Хэрэв зураг чимэглэлийн тухайд ямар нэг хязгаарлалт тогтоосон бол үзүүлэнгийн материалыг хуулбарлаж болохгүй. Зохиогчийн эрхийн талаар асуух зүйл байвал дараах хаягаар хандана уу. Intellectual Property Office, 50 E. North Temple St., FL 5, Salt Lake City, UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн cor-intellectualproperty@ChurchofJesusChrist.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada: December 2020 Vol. 21, No. 6. LIAHONA (USPS 311-480) Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year (January, April, June, July, October, and December) by The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price is $5.00 per year; Canada, $6.50 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days' notice required for change of address. Include address label from a recent issue; old and new address must be included. Send USA and Canadian subscriptions to Salt Lake Distribution Center at address below. Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders (American Express, Discover, MasterCard, Visa) may be taken by phone or at store.ChurchofJesusChrist.org. (Canada Post Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 507.1.5.2). NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368, Salt Lake City, UT 84126-0368, USA.

ТА ДЭЛХИЙГ ГЭРЭЛТҮҮЛЖ ЧАДНА

Таныг энэ сард Есүс Христийн мэндэлснийг болоод Түүний амьдралыг тэмдэглэхэд, бусдад тусламжийн гараа сунгах, амьдралд тань авчирдаг Түүний гэрлийг бусадтай хуваалцахад туслах хэд хэдэн санааг энд оруулав.

THE CHRIST CHILD ВИДЕО БИЧЛЭГИЙГ ХУВААЛЦАХ

- Видео бичлэгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хуваалц.
- Гэртээ өөр итгэл үнэмшилтэй найзуудаа үзүүл.
- Автобусанд танихгүй хүнтэй хуваалц.
- Гэр бүлийн үдшийн хичээлдээ хэрэглэ.

ӨВЧТЭЙ, ЗОВЖ ШАНАЛЖ БУЙ ХҮМҮҮСИЙГ ЭРГЭЖ ОЧИХ

- Эрүүл ахуйн багц хий.
- Өвчтэй хүмүүстэй хамт цагийг өнгөрөө.
- Хэрхэн туслахаа асуу.
- Хүмүүнлэгийн ажилд хандив өргө.

ӨЛССӨНИЙГ ХООЛЛОХ

- Гэр оронгүй хүмүүсийг хооллодог гал тогоонд сайн дураараа ажилла.
- Хоол цуглуулахад оролц.
- Хэн нэгэнд хоол аваачиж өг.
- Хэн нэгнийг Христийн мэндэлсний баярын үдшийн зоогт урь.

ХООЛООР ДАЙЛЖ БАЙГАА ХҮМҮҮСИЙН ГЭРЭЛ ЗУРГИЙГ GETTY IMAGES-ЭЭС АВАВ

ГАНЦААРДСАНЫГ ТАЙТГАРУУЛАХ

- Ганцаараа байгаа нэгний хажууд суу.
- Ганцаараа амьдардаг хүнийг эргэж оч.
- Ганцаардаж байгаа хүмүүсийг гэртээ урь.
- Шинэ найзтай бол.



ХҮМҮҮСИЙГ СҮМД УРИХ

- Хэнийг урихаа мэдэхийн тулд залбир.
- Бусдыг 12-р сарын 20-ны Христийн мэндэлсний баярын онцгой цугларалтад урь.
- Биечлэн болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр урь.
- Найз нөхдөө Христийн мэндэлсний баярын үйл ажиллагаанд урь.

Гурван шинэ сэтгүүлээ тэсэн ядан хүлээж байна

Сүмийн сэтгүүлд орсон өөрчлөлтүүд дэлхий даяарх Сүмийн өсөлтийг харуулж байна.

Бурханлаг луужингийн нэрээр нэрлэгдсэн *Лиахона* сэтгүүл (Алма 37:38–45) уншигчдаа бидний Аврагч, Есүс Христ рүү чиглүүлэх зорилготой. Одоо энэ нь Сүмийн сэтгүүлүүдэд гарч буй гайхалтай өөрчлөлтүүдийн хувьд шинэ эхлэл болж байгаа юм.

Дараагийн сараас эхлэн, Сүм дэлхий даяар гурван шинэ сэтгүүлийг, тухайлбал насанд хүрэгчдэд зориулсан *Лиахона*, өсвөр үеийнхэнд зориулсан *Өсвөр үеийнхний бат бөх байдлын төлөө*, хүүхдүүдэд зориулсан *Найз* зэрэг сэтгүүлүүдийг хэвлэн гаргах гэж байна. Аль хэл дээр гарахаасаа шалтгаалаад, сэтгүүлүүд сар бүр юм уу 2 сард 1 удаа гарах боломжтой.

Хэрэв та одоогийн *Лиахона* сэтгүүлийн захиалагч бол таны захиалгын үлдсэн хугацаагаар тооцогдож, дараа жил захиалгын эрх тань автоматаар сунгагдах болно. Хэрэв танай гэр бүл *Найз* эсвэл *Өсвөр үеийнхний бат бөх байдлын төлөө* сэтгүүлүүдийг хүлээн авахыг хүсэж байвал та орон нутгийнхаа хангамжийн төв дээр очиж эсвэл store.ChurchofJesusChrist.org руу орж захиалж болно.

Тойрог, салбарууд саяхан баптисм хүртсэн гишүүдийг, тэр тусмаа эцэг эхгүйгээр сүмд явж байгаа хүүхэд, өсвөр үеийнхнийг сэтгүүл захиалахад нь урамшуулан дэмжих болно. Сэтгүүлүүдийн эдгээр онцлог талыг авч үзээд, тэдгээр нь таныг төдийгүй таны гэр бүл, найз нөхдийг хэрхэн адислах талаар бодож үзээрэй.





Лиахона: Насанд хүрэгчдэд зориулав

Сүмийн удирдагчдын захиас

Итгэлтэй гишүүдийн туршлага

Ирээд, Намайг дага гарын авлагыг судлахад туслах өгүүллүүд

Шинэ гишүүдэд зориулсан сайн мэдээний үндсэн ойлголтууд

Танай бүсээс оруулсан мэдээ, нийтлэлүүд





Өсвөр үеийнхний шинэ сэтгүүлийн тухай илүү ихийг мэдэж авахын тулд энэ хэвлэлийн 50-р хуудсыг үзээрэй.

Өсвөр үеийнхний бат бөх байдлын төлөө: Өсвөр насныханд зориулав

Сүмийн удирдагчдын захиас

Гэр бүлийн үдшийн үзүүлэнт хичээл

Өсвөр үеийнхний асуултын хариулт

Хэвлэл мэдээлэл, жишгүүд, найз нөхөд, бусад холбогдох сэдвийн талаарх нийтлэл



Найз: Хүүхдүүдэд зориулав

Сүмийн удирдагчдын захиас

Жаахан хүүхдүүдэд зориулсан үйл ажиллагаа

Хүүхдүүдийн бичсэн түүх

Сайн мэдээний талаар ойлголттой болгох өгүүлэл

Хүүхдийн урлагийн бүтээл





Та **store.ChurchofJesusChrist.org** хаягаар орж, хэвлэмэл сэтгүүл захиалах юм уу бэлэглэх захиалга хийж болно. Та Gospel Library аппликэйшн юм уу **liahona.ChurchofJesusChrist.org** хаягаар орж сэтгүүлүүдийг цахим хэлбэрээр уншиж болно.

ЛИАХОНАГИЙН ЗУРГУУДЫГ БЭТ ВАЙТЭКИР

Тохинуулллын зарчмууд

ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРААР АВРАГЧИЙН ГЭРЛИЙГ ХУВААЛЦАХ НЬ

Тохинуулдаг хүмүүсийнхээ талаар бодож үз. Та Христийн мэндэлсний энэхүү баяраар Христэд ойртоход нь тэдэнд хэрхэн тусалж чадах вэ?

Бид Аврагч Есүс Христийг жилийн туршид санахын зэрэгцээ Христийн мэндэлсний баярын өдрүүдээр, бидэнд "Бурхан ертөнцийг үнэхээр хайрласандаа цорын ганц Хүүгээ өгсөн" (Иохан 3:16) хамгийн том бэлэгт баярлан, тэмдэглэн өнгөрүүлдэг. Бид Христийн мэндэлсний баярын өдрүүдэд тохинуулахдаа Аврагчид ойртоход нь туслах бэлгийг хүмүүст өгч чадна. Тэнгэрлэг Эцэгийн өгсөн тэр бэлгийг бусдад өгөх гайхалтай сайхан.

Би авсан бэлэгтээ одоо ч гэсэн талархдаг

Сьюзан Харди, АНУ, Калифорни

Намайг 11-тэй байхад манай Ням гаргийн ангийн багш Дийтс ах хэрэв манай ангийнхан Итгэлийн тунхгийг цээжлэн, утгыг нь өөрт нь ярьж өгөх юм бол бидэнд өөрийн гэсэн судрын багц авч өгнө гэсэн юм.

Дийтс ах, эгч хоёр дөнгөж гэр бүл болсон залуу хос байв. Дийтс ахыг хүн бүрд бэлэг авч өгч чадна гэж би

ХРИСТИЙН ТӨРӨЛТИЙГ ХАРУУЛСАН ЗУРГИЙГ НИЛЦА БИЙТРИЗ САНТИЛЛАН КАСТИЛО

бодохгүй байсан ч Итгэлийн тунхгийг цээжлэхийг үнэхээр чухал гэж бодож байгаа тул би урилгыг нь хүлээн авахаар шийдлээ.

13 хэсгийг бүгдийг цээжилсний дараа цаг хугацаа ч өнгөрч, би ч түүний амлалтыг мартсан байв.

Тэгтэл Христийн мэндэлсний баярын өдөр би нэрийг минь дээр нь бичсэн илгээмж хүлээн авсан юм. Нээнгүүт би зөвхөн надад зориулсан судрын багц байхыг олж харсан ба дотор нь байнга уншиж байхад урамшуулсан ил захидал байв. Энэ явдал 1972 онд болсон бөгөөд тэр судар өнөөдрийг хүртэл надад байсаар байгаа. Энэ судар надад үнэ цэнтэй.

Энэ бэлгийн үнэ нь биш, харин түүний намайг гэсэн сайхан сэтгэл, миний төлөө гаргахад бэлэн байсан золиос нь Бурханы үгийг судлах гүн хүсэлтэй болгосон юм. Би Дийтс ахын үлгэр жишээг даган, эргэн тойрныхоо хүмүүст утга учиртай бэлэг өгч, тэр миний амьдралыг адисалсны адил тэдний амьдралыг ч гэсэн адисална байх хэмээн найдан түүний тохинуулын жишээг дагахыг хичээдэг.

Өөрийн үүргийг биелүүлэх урилга

Ричард М.Ромни, АНУ, Юта

Тойргийн Христийн мэндэлсний баярын үйл ажиллагааг төлөвлөж байгаа хүмүүс идэвх султай нэгэн гишүүнийд очиж, хөтөлбөрт оролцоход урихыг надаас хүсэв. Би сандарч байснаа хэлэх нь зүйтэй болов уу. Би тойргийн өмнөх үйл ажиллагаанд оролцож байхдаа Даррэнтай ганцхан удаа таарч байсан байлаа. Тэр мотоцикл унахдаа өмсдөг боолтыг толгойдоо зүүсэн байв. Тэр урт цагаан үсээ ардаа боосон, цав цагаан том сахалтай, гараараа дүүрэн шивээстэй байлаа.

Харин одоо би хорооныхоо гишүүнтэй хамт Даррэнг юу гэж хэлэх бол гэж бодон үүдэнд нь зогсож байв. Тэр биднийг дотогшоо орохыг урихад бид түүнд ирсэн учраа тайлбарлав. "Тэгэлгүй яах вэ, би ийм үйл ажиллагаанд дуртай" гэж тэр хэллээ.

Тэр үйл ажиллагааг олон хүнд утга учиртай болгоход туслан, гайхалтай зүйл хийсэн юм. Үүний дараахнаас

ТУРШЛАГАА ХУВААЛЦ

Та бусдад эсвэл бусад хүн танд тохинуулж байсан туршлагаасаа бидэнд илгээнэ үү. Та liahona.ChurchofJesusChrist.org вэбсайт руу ороод, "Submit an Article or Feedback" дээр дарна уу.

БЭЛГИЙН ГЭРЭЛ ЗУРГИЙГ GETTY IMAGES-ЭЭС АВАВ.

тохинуулалын хамтрагч бид хоёрыг Даррэнийд байнга очихыг хүсэж билээ. Тэр үргэлж бидэнтэй баяртай уулздаг байсан бөгөөд бид сайхан яриа өрнүүлдэг байв. Тойргийн үйл ажиллагааны хөтөлбөрт оролцоход түүнийг урих сүнслэг өдөөлт сайхан нөхөрлөл үүсгэхэд намайг хөтөлсөнд би талархдаг.

Христийн мэндэлсний баяраар бусдад тохинуулах

Тохинуулдаг хүмүүстээ, ялангуяа жилийн энэ цаг үед тэдний тухай бодож явдгаа харуулахын тул таны хийж болох зарим зүйлийг энд оруулав. Үүнд:

1. **Заримдаа утсаар ярих эсвэл мессеж бичих нь гайхалтай үр дүнг авчирдаг.** "Сайн байна уу, ямархуу байна даа?" гэх зэрэг энгийн асуултаар яриа өрнүүлэх нь өөрчлөлтийг тавих эхлэл болж болно.
2. **Тохиромжтой бол тэдний баярт нэгдээрэй.** Христийн мэндэлсний баяр нь нийтлэг итгэл үнэмшлийн талаар суралцах сайхан цаг юм. Та итгэл үнэмшлээ хуваалцаж, бусдыг сонссоноор илүү сайн ойлголцох үүд хаалгыг нээдэг.
3. **Нэрийг нь дуудан, тэдний төлөө залбир.** Тэнгэрлэг Эцэгт хандан тэднийг Хүүд нь ойртуулах арга замыг бодож олоход туслахыг хүс.
4. **Энгийн бэлэг хамгийн дурсамжтай бэлэг байдаг.** Бэлэг заавал сүртэй байх албагүй. Цаг хугацааны бэлэг, сонсох бэлэг мөн гэрэл зураг болон дурсамжаа хуваалцах гээд энэ бүхэн сэтгэлийн бэлэг болж чадна.
5. **Гэрчлэлийн бэлэг өг.** Аврагчийг хайрлах хайраа хуваалцахыг тэднээс хүсэж, өөрөө ч бас хуваалц.

Дэлхийг гэрэлтүүл аяныг ашиглан тохинуулах

Та тохинуулахдаа Дэлхийг гэрэлтүүл аяныг ашиглаж болно. Эхлэхэд тань туслах хэд хэдэн санааг харуулав. Үүнд: (Илүү дэлгэрэнгүйг ComeuntoChrist.org хаягаас аваарай.)

1. **The Christ Child видео бичлэгийг хуваалц.** Та уг видео бичлэгийг постолж, холбоосыг нь хуваалцахад эсвэл хамт үзэхэд бусдыг урьж болно.
2. **Христийн мэндэлсний баярын үйлчлэлд оролцоход хүмүүсийг урь.** Зарим хүн шүтэн биширэхийг хүсдэг ч хаашаа очихоо мэддэггүй. Тэднийг өөртэйгөө хамт шүтэн биширэхэд уриарай.
3. **Тэднийг байгаа зүйлээ бусадтай хуваалцахад урамшуул.** Тэд Сүмийн хүмүүнлэгийн үйлчлэлд юм уу орон нутгийн энэрлийн байгууллагуудад хандив өгч болно. Хэрэв та Сүмийн өглөгийн машин бүхий хотод байдаг бол хандив өгөхөөр явахдаа тэднийг дагуулж явж болно. Уг машин нь дэлхий даяарх хүмүүсийг адислах бэлэг илгээх хамгийн энгийн арга зам юм.
4. **Өдөр бүр үйлчлэх төсөлд бүртгүүл.** Та бас бусдад бүртгүүлэхэд нь тусалж болно. Эдгээр төсөл та нарт хамтдаа үйлчлэх боломжийг гаргаж өгч болох юм.

5. **Тэдний гэр оронг амар амгалангаар дүүргэ.** Зүрх сэтгэлд нь хайр, найдвар төрүүлэх Христийн мэндэлсний баярын онцгой захиас номлогчдод байгааг тэдэнд хэл.
6. **Дэлхийг гэрэлтүүл аяныг тэдэнд танилцуул.** ComeuntoChrist.org дээрээс илүү дэлгэрэнгүй мэдээллийг хэрхэн авч болохыг тэдэнд харуул.

Цуглаанаар бүгдэд тохинуулах

Цуглаан бүрийн хэрэгцээ өөр өөр. Зарим цуглаанд том хэмжээний үйл ажиллагаа зохион байгуулах нь тустай байхад заримд нь энгийн бөгөөд цомхон үйл ажиллагаа тустай байж болно. Үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулахад оролцож байгаа хүмүүс одоогийн хэрэгцээг хэрхэн хангахаа залбирч байгаад бодож үздэг.

- Францын Парис дахь гурван гадасны гишүүд авьяасаа үзүүлэх, загвар үзүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулж, Дэлхийг гэрэлтүүл аяныг дэмжин тусалсан. Тэд дүрвэгсдэд болон орон гэргүй хүмүүст өгөх зүйлсийг бэлтгэсэн юм. (“Парист дэлхийг гэрэлтүүлцгээе,” 32-р хуудсыг үзнэ үү.)
- Хойд Каролина Шарлотт төв гадас нь “Дэлхий даяарх Христийн мэндэлсний баяр” хэмээх олон нийтийн арга хэмжээ зохион байгуулсан ба хоол унд, олон улсын Христийн мэндэлсний баярын уламжлалыг харуулсан үзэсгэлэн, дуу хөгжим, үйлчлэлийн төсөл, Христийн мэндэлснийг харуулсан хүүхдийн тоглолт хийх зэргээр Христийн мэндэлсний баярыг тэмдэглэн өнгөрүүлэв.
- Флорида Веро Бийч гадасны гишүүд бид яагаад Христийн мэндэлсний баярыг тэмдэглэдэг болохыг олон нийтэд сануулах үйл ажиллагаанд нэгдэн оролцов. Мөн орон нутгийн энэрлийн байгууллагуудад тоглоом хандивлажээ. Хүүхдийн хэсгийн найрал дуучид дуулж, олон олон сүм мэдээлэл бүхий танилцуулга гаргасан байв.
- Жаксонвилл Флорида Өмнөд гадас олон нийтэд зориулан *Дэлхийн Аврагч* хэмээх уран бүтээл туурвижээ. ■



АВРАГЧИД ИЛҮҮ ОЙР

“Бид өөрийн биеийг ‘Шөнийн цагаар сүрлэн дээр нойрсох Бурханыг харахаар Бетлехем дэх малын хашаанд’ байна гэж төсөөлөн бодвол Аврагчийг нинжин сэтгэлтэй, биднийг хайрладаг Тэнгэрлэг Эцэгийн өгсөн бэлэг гэдгийг илүү сайн ойлгоно.”

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэйл Г.Рэнланд, “Бүх хүмүүнийг өөртөө татаж болохын тулд,” *2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 23.



Ахлагч Д.Тодд Кристоффэрсон
Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын

ЯАГААД Есүс Христ БИДЭНД ХЭРЭГТЭЙ ВЭ?

Энэ Христийн мэндэлсний баяраар дуу шуугианаа багасгаж, Бурханы Хүүгийн гайхамшигт төвлөр.

12-р сар нь бидэнд Христийн мэндэлсний баяр дээр нэмээд, 12-р сарын 23-нд төрсөн бошиглогч Иосеф Смитийн амьдрал, түүний оруулсан хувь нэмрийн талаар тунгаан бодох боломжийг олгодогт би талархдаг. Байнгын эсэргүүцэл, хавчлага, сорилтын дунд, Их Эзэний мутар дахь зэмсгийн хувьд түүний хийж бүтээсэн зүйлсийг бүрэн дүүрэн ойлгох аргагүй. Бид ирээдүйд бошиглогч Иосефыг өмнөх бүх эрин үе бүгд урвалтаар төгссөн ч амжилт олох хувь заяатай энэхүү агуу хийгээд сүүлийн эрин үеийн зохистой тэргүүн хэмээн өргөмжлөгдөхийг харах болно.

Энэ эрин үед хүнээс биш, харин Бурханаас эмээж сурсан өөр хүн энэ бошиглогчоос өөр байхгүй болов уу (Сургаал ба Гэрээ 3:7–8-ыг үзнэ үү). Их Эзэн Иосефоос маш хүнд бэрх зүйлсийг хүссэн. Тэр хүссэн зүйлсийг нь гүйцэтгэсэн ба үр ашгийг нь бид хүртэж байгаа билээ.

Мормоны Номыг орчуулж, хэвлүүлсэн нь том амжилт байсан бөгөөд энэхүү сүүлийн эрин үед Их Эзэний үйл хэргийг амжилтад хүргэх үндэс суурь болсон. Иосеф Мормоны Номоор болон үзэгдэл, илчлэлтээрээ дамжуулан Бурханы Цорын Ганц Хүү, хүн төрөлхтний Гэтэлгэгч Есүс Христийг шинэ эрин үед жинхэнэ мөн чанараар нь илчилсэн.

Нэн ялангуяа энэ баярын өдрүүдэд бид бошиглогч Аврагчтай ямар хувийн харилцаатай байсныг мөн "[Христийн] талаар [түүний өгсөн] хамгийн сүүлчийн гэрчлэл болох Тэр амьд" (Сургаал ба Гэрээ 76:22) хэмээх гэрчлэлийг дурсан санадаг. Амьд Христийн талаарх Иосефын гэрчлэл ерөнхийлөгч Гордон Б.Хинклигийн (1910–2008) мэдэгдлийг надад сануулдаг. Тэрээр "Христийн амилсны баяргүйгээр Христийн мэндэлсний баяр байхгүй байх байсан. Бетлехемийн нялх Есүс, Гетсемаийн болон Калварийн гэтэлгэгч Христгүйгээр мөн Амилуулалтын гайхамшигт ялалтгүйгээр өөр хүү байх байсан"[1] хэмээсэн.

ADORATION OF THE SHEPHERDS, BY MICHELANGELO MERISI DA CARAVAGGIO, BRIDGEMAN IMAGES

Яагаад Есүс Христ бидэнд хэрэгтэй вэ?

Хэсэг хугацааны өмнө, олон жил Сүмийн гишүүн байсан нэгэн хүн надаас "Яагаад Есүс Христ надад хэрэгтэй вэ? Би зарлигуудыг дагадаг сайн хүн. Яагаад Аврагч надад хэрэгтэй вэ?" гэж асуусан юм. Сургаалын маань хамгийн чухал хэсэг болох авралын төлөвлөгөөний үндэс суурийг энэ гишүүн ойлгоогүй байсан нь намайг гайхшируулсан гэдгийг дурдах нь зөв болов уу.

"За, эхлээд үхэл гэх нэг жижигхэн асуудал бий. Эцсийн эцэст үхлээр төгсөхийг та хүсэхгүй гэж би бодож байна. Мөн Есүс Христгүйгээр амилуулалт гэж байхгүй байх байсан" гэж би хариулсан юм.

Хамгийн сайн хүмүүс ч гэсэн зөвхөн Аврагчийн цагаатгагч ач ивээлээр дамжуулан өршөөгдөж, цэвэршүүлэгдэх хэрэгтэй болох талаар би ярьсан.

Хайраар өдөөгдсөн Тэнгэрлэг Эцэг маань Өөрийн Цорын Ганц Хүүг бидний нүглийн төлөөс болгон өргөж, нигүүлслийг бий болгов.

Гэтэл цаашлан, "Бурхан бидэнд хайртай юм чинь хүссэн бүхнээ хийж, Аврагчийн тусламжгүйгээр биднийг аварч болохгүй юм уу?" гэсэн өөр түвшний асуулт гарч ирж болох юм. Өнөөгийн дэлхийд иим утга агуулгатай асуулт тавих хүн олон байж магад. Тэд Бурханд болон мөнх бус оршихуйн дараах амьдралд итгэдэг атлаа Бурхан бидэнд хайртай учраас бидний хийдэг хийдэггүй зүйлс Түүнд хамаагүй, Тэр зүгээр л асуудлыг шийддэг гэж боддог.

Энэ үзэл бодол бүр эртнээс улбаатай. Жишээ нь, Нихор "эцсийн өдөр бүх хүн төрөлхтөн аврагдах болно, мөн тэд айх бас чичрэх ч хэрэггүй, харин тэд тэргүүнээ өргөн мөн баясаж болох ажээ; учир нь Их Эзэн бүх хүмүүнийг бүтээсэн, мөн түүнчлэн бүх хүмүүнийг гэтэлгэсэн; мөн, төгсгөлд нь, бүх хүмүүн мөнх амьдралтай байна хэмээн тэрээр хүмүүст түүнчлэн гэрчлэв" (Алма 1:4) гэжээ.

Нихорын сургаалаас хамгийн эмгэнэлт дүр болох, "өглөөний хүү" Люсиферийн дэвшүүлсэн авралын талаарх хандлагыг харж болно (Исаиа 14:12-ыг мөн Сургаал ба Гэрээ 76:25–27-г үзнэ үү). Бурхан Люсиферыг "мөн адил эхлэлээс байгаа бөлгөө, мөн тэрээр миний өмнө ирж, хэлэв,— Болгоогтун, би энд байна, намайг илгээгтүн, би таны хүү байх болно, мөн нэг ч бодгаль хаягдахгүйгээр бибээр хүн төрөлхтнийг гэтэлгэх болно, мөн үүнийг би гарцаагүй хийх болно, иймийн тулд өөрийн алдар хүндэтгэлийг надад өгөгтүн.

Гэвч, болгоогтун, миний Хайрт мөн эхлэлээс Сонгогдсон Хайрт Хүү минь, надад хэлэв—Аав аа, таны таалал хэрэгжих болно, мөн алдар суу үүрд таных байх болно" (Мосе 4:1–2) хэмээн тайлбарлажээ.

Энэ нь зөвхөн Есүс Эцэгийн төлөвлөгөөг дэмжиж, Люсифер бага зэрэг өөрчлөлт оруулахыг санал болгосон явдал биш байлаа. Люсиферийн санал бидний өөрсдийн сонголтоор үйлдэх боломжийг үгүй болгон, төлөвлөгөөг устгах байв. Люсиферийн төлөвлөгөө үнэн хэрэгтээ Бурханы бусад бүх охид, хөвгүүдийг буюу биднийг өөрийн утсан хүүхэлдэй болгох дарамт дээр суурилах байлаа. Эцэг энэ бүхнийг иин дүгнэжээ.

"Иймийн тул, Сатан миний эсрэг бослого гаргасан хийгээд бибээр Их Эзэн, Бурхан, мөн тэрчлэн түүнд өгсөн хүмүүний сонгох эрхийг эрэлхийлэн мөн би түүнд өөрийн хүчийг өгөх ёстой гэсний учир түүнийг би Төрсөн Ганцынхаа хүчээр доош хаягдахаар болгосон бөлгөө;

Мөн тэрээр Сатан, тийм ээ, бүр чөтгөр, хүмүүнийг мэхлэн мөн харалган болгох, мөн тэднийг, бүр *миний* дуу хоолойг үл сонсох болгоныг таалалдаа боолчлон хөтлөх бүх худал хуурмагийн эцэг болсон билээ" (Мосе 4:3–4; тодотгол нэмэгдсэн).

Харин эсрэгээрээ, Эцэгийн арга замаар үүнийг хийснээр бидэнд нэн хэрэгтэй мөнх бус амьдралын туршлага олгох байсан. "Мөнх бус амьдралын туршлага" гэдэг нь миний хувьд сонгох эрх буюу бид "сайн сайхны үнэ цэнийг мэдэж болохын тулд

НЭГ НЭГЭЭР НЬ, ВОЛТЭР РЭЙН

гашууныг [амсаж]" (Мосе 6:55), сурч боловсрон, наманчилж, өсөж хөгжин, зүгээр "үйлдүүлэх" (2 Нифай 2:13) явдал биш, харин өөрсдийнхөө төлөө үйлдэх чадавхтай нэгэн болж, эцэст нь хилэнцтийг ялан дийлж, селестиел хуулийн дагуу амьдрах хүсэл, чадвараа харуулна гэсэн үг юм.

Энэ нь биднээс сайн, муугийн талаарх мэдлэг, хоёр зүйлээс нэгийг нь сонгох чадавх, боломжийг шаарддаг. Мөн энэ нь хийсэн сонголтынхоо өмнөөс хариуцлага хүлээхийг шаарддаг. Үгүй бол энэ бүхэн сонголт байж чадахгүй билээ. Сонголт нь эргээд хуулийг юм уу урьдчилан харах боломжтой үр дүнг шаарддаг. Бид тодорхой үйлдэл эсвэл сонголтоор тодорхой үр дүн, үр дагаварт хүрэх ёстой. Харин үүний эсрэг сонголт нь эсрэг үр дагаварт хүргэдэг. Хэрэв үйлдлүүд тодорхой үр дагаварт хүргэхгүй бол үр дүнг хэн ч хянах боломжгүй бөгөөд сонголт хийх нь утгагүй байх болно.

Хууль ба шударга ёс

Алма *шударга* ёсыг *хуультай* адил утгаар хэрэглэн, "Эдүгээ шударга ёсны ажил [хуулийн үйл ажиллагаа] устгагдах учиргүй; хэрэв тэгвэл, Бурхан нь Бурхан байхаа болих сон" (Алма 42:13) гэж хэлжээ. Бурханы хуулийг ойлгох төгс ойлголт, үүнийг ашиглах байдал, өөрөөр хэлбэл Өөрийнх нь шударга ёс Өөрт нь хүч өгдөг гэсэн үг юм. Сонгох эрхтэй мөн уг эрхээ хэрэгжүүлэх боломжтой байхын тулд бидэнд Бурханы Өөрөө дагаж мөрддөг, хэрэгжүүлдэг, тогтсон, хувиршгүй хуулийн тогтолцоо, шударга ёс хэрэгтэй.[2] Энэ шударга ёс бол бидний үйлдэх эрх чөлөөний үндэс суурь ба туйлын аз жаргалд хүрэх цорын ганц арга зам юм.

Их Эзэн бидэнд "хуулиар зохицуулагддаг тэр нь тэрчлэн хуулиар хамгаалагдан мөн төгөлдөржиж мөн түүгээр ариусгагддаг бөлгөө" (Сургаал ба Гэрээ 88:34) хэмээн хэлсэн. Гэхдээ бид үргэлж, найдвартай "хуулиар зохицуулагдаагүй" гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Хууль зөрчсөн үедээ бид хууль, шударга ёс биднийг хамгаалж, төгөлдөржүүлэхийг хүлээх ёсгүй (2 Нифай 2:5-ыг үзнэ үү). Тиймээс шударга байхын зэрэгцээ хайраар өдөөгдсөн Тэнгэрлэг Эцэг маань нигүүлслийг бий болгосон. Тэрбээр үүнийг Өөрийн Цагаатгалаар, бидний төлөө шударга ёсны төлөөсийг төлж чадах Нэгэн болох Өөрийн Цорын ганц Хүүг бидний нүглийн төлөө өргөл болгон өгснөөр биднийг буруутгалгүй хуулийн өмнө зөвтгөсөн, дахин нэг удаа дэмжиж, хамгаалах замаар гүйцэтгэсэн. Алма ийн тайлбарлажээ.

"Мөн эдүгээ, нигүүлслийн төлөвлөгөө нь цагаатгал хийгдэхгүйгээр улиран тохиогдох боломжгүй; тиймийн тул Бурхан нь төгс, шударга Бурхан, мөн түүнчлэн нигүүлсэнгүй Бурхан байж болохын тулд нигүүлслийн төлөвлөгөөг гүйцэлдүүлэхээр, шударга ёсны шаардлагыг хангахаар Бурхан өөрөө дэлхийн нүглийн төлөө цагаатгалыг нөхөн төлдөг. . . .

Гэвч хууль өгөгдсөн, мөн шийтгэл нь [эсвэл үр дагавар нь] тогтоогдсон, мөн наманчлал олгогдсон юм; нигүүлсэл нь наманчлалыг шаардана; өөрөөр бол, шударга ёс нь уг хүнийг шаардаж, мөн шударга ёс хуулийг хэрэгжүүлж, мөн хууль нь шийтгэлийг оноодог; хэрвээ тийм бус аваас, шударга ёсны ажлууд устгагдаж, мөн Бурхан нь Бурхан байхаа болих сон.

Гэвч Бурхан Бурхан байхаа болихгүй, мөн нигүүлсэл нь гэмшигчийг шаарддаг, мөн нигүүлсэл нь цагаатгалын учир ирдэг" (Алма 42:15, 22–23).

Мэдээж наманчилдаг хүмүүс л хариуцлага үүрч, наманчлалаар дамжуулан Түүний нигүүлслийг хүлээн авдаг.[3] Өөрөөр хэлбэл, Өөрийнх нь Хайрт Хүү бидний нүглийн төлөө Цагаатгалыг

гүйцэтгэсэн учраас бидэнд зөвхөн Тэнгэрлэг Эцэг л санал болгож болох тэрхүү өршөөлийн энэрэнгүй бэлгийг нэхэж авахын тулд бидний хийх зүйл бол наманчлал юм.

Есүс Христийн Цагаатгал

Есүс Христийн Цагаатгалын ачаар бид муу сонголтынхоо үр дагавраас эргэн босож чадна. Бусдын нүгэл, алдаа дутагдлын бидэнд үзүүлсэн нөлөө, шударга бус бүхэн Есүс Христийн Цагаатгалын ачаар нөхөн төлөгдөнө. Бүрэн бүтэн болж, ариусгагдахад бидэнд Аврагч хэрэгтэй. Тиймээс бидний асуултад "Үгүй ээ, Бурхан хүнийг аврахын тулд Өөрийн хүссэнээрээ үйлдэж чадахгүй. Тэр дур зоргоороо байхын зэрэгцээ шударга байж чадахгүй. Хэрэв Бурхан шударга биш байвал Бурхан байхаа болино." Тиймээс аврал, өргөмжлөл нь хөдөлшгүй хууль, шударга ёсыг дагаж мөрдөх замаар гүйцэлдэх ёстой. Аврагчийг өгснөөр шударга ёсыг хамгаалж үлдсэнд нь Бурхандаа талархъя" гэж хариулна.

Энэ сүнсэн Ууган Хүү махан биетэй Төрсөн Цорын Ганц Хүү болж, зовж шаналан, биднийг гэтэлгэхийн тулд ухэхийг сайн дураараа сонгосон юм.

Мөнх бус оршихуйн өмнөх амьдрал дахь агуу зөвлөлөөр Люсифер сайн дураараа бидний аврагч болъё гээгүй гэдгийг анхаарна уу. Тэр бидний өмнөөс зовж шаналж, амиа өгч, цусаа урсгах сонирхолгүй байсан. Тэр шударга ёс гүйцэлдэхийг хүссэнгүй, харин өөрөө хууль тогтоогч болохыг эрэлхийлж байв.[4] Люсифер Эцэгтээ "өөрийн алдар хүндэтгэлийг надад өгөгтүн" (Мосе 4:1) гэж хэлэхдээ, уг хүчийг өөрийн дур зоргоор ашиглахын тулд "Захирах эрхийг надад өгөөч" гэсэн утгаар хэлсэн гэж би боддог. Түүний хэлсэн зүйл ямар ч цаг мөчид хууль болох байсан. Ийм байдлаар хэн ч өөрийн хүслээр үйлдэж чадахгүй байх байсан. Люсифер бүхнээс дээгүүр заларч, өөр хэн ч ахиж дэвшихээргүй байх байсан.

Нөгөө талаас, Есүс ах дүү нь өсөж хөгжихөд өөрчлөгдөн хувирдаггүй шударга ёс, нигүүлсэл хоёрын аль аль нь байх шаардлагатай гэдгийг ойлгожээ. Тэрээр Эцэгтэй хамт биднийг хүчээр захирч, ноёрхохыг эрэлхийлээгүй, харин Эцэгтэй хамт "бүхний дээр байж," "бүх хүч байж" (Сургаал ба Гэрээ 132:20) болохын тулд биднийг чөлөөлж, өргөн дэмжихийг эрэлхийлсэн.

Энэ сүнсэн Ууган Хүү махан биетэй Төрсөн Цорын Ганц Хүү болж, төсөөлөхийн аргагүй зовж шаналан, биднийг гэтэлгэхийн тулд гутамшигт үхлээр үхэхийг сайн дураараа сонгосонд бид хэчнээн их талархах ёстой билээ. Тэрбээр шударга ёс, нигүүлсэл хоёрыг төгс байдлаар нэгтгэдэг. Тэрээр биднийг

ХРИСТ ГЕТСЕМАНИЙН ЦЭЦЭРЛЭГТ ЗАЛБИРЧ БАЙГАА НЬ, ХЕРМАНН КЛЕМЕНИЗ

нүгэлтэй байлгах гэж бус, нүглээс гэтэлгэхээр ирсэн (Хиламан 5:10–11-ийг мөн Матай 1:21-ийг үзнэ үү).

Тэр бас биднийг Уналтаас, сүнслэг болон бие махбодын үхлээс гэтэлгэдэг. Тэр үхэшгүй байдал болон мөнх амьдралын үүд хаалгыг нээж өгдөг. Түүний хайранд умбахгүй байхын аргагүй. "Үнэхээр Тэр бидний сул дорой байдлыг тээж, Өвчин зовлонг маань үүрчээ. . . .

. . . Тэр гэмт үйлдлийн маань улмаас Тэр хатгагдан, Хилэнцийн маань улмаас Тэр бяцарч авай. Амар тайвны маань төлөө Түүн дээр гэсгээл байж, шархаар нь бид эдгэрчээ" (Исаиа 53:4–5).

ЕСҮСИЙГ ХАЙРЛАН БИШРЭВ, МАТТИАС СТОМЭР, BRIDGEMAN IMAGES

Бурханыг магтъя

Христийн мэндэлсний баяр ойртох тусам зарим нь асуудалтай, зарим нь ирээдүйдээ санаа зовдог байж болох юм. Таны амьдрал маш их "чимээ шуугиантай," амсхийх завгүй, нам гүм эргэцүүлэн бодох цаггүй, өөрийн сэтгэл зүрхийг уудлан харж, хаана байгаа, хаашаа явахаа тодорхойлох цаг гаргахгүй, их бага хэмжээгээр байнга онлайн дээр өнгөрч байж болох юм. "Шууд төгс төгөлдөр болох ёстой" эсвэл "амьдралдаа байнга аз жаргалтай, амжилттай байх ёстой" зэрэг бодит бус шаардлага танд нөлөөлж байж ч болно.

Та эдгээр буруу бодлоо хаяж, "чимээ шуугианаа" багасгаж, Христийн мэндэлсний баярын өдрүүдэд их биш юм аа гэхэд ядаж нэг цагийг Бурханы Хүүгийн "гайхамшгуудын" талаар тунгаан бодоход зарцуулаасай хэмээн би хүсэж байна. . . ."[5] Энэ цаг хугацааг дахин баталгаа авах, шинэчлэх цаг болго.

Би өмнөх Христийн мэндэлсний баяраар дараах захиасыг бичиж байв.

"Бид Есүс Христийн мэндэлснийг ярихдаа, үүний дараа тохиолдох зүйлийн талаар зохих ёсоор ярьдаг. Биднийг илүү их халамжлахад Түүний мэдрэх зүйл, туулах зовлон буюу Түүний цовдлолт, амилалтын улмаас Түүний төрөлт туйлын ач холбогдолтой байсан (Алма 7:11–12-ыг үзнэ үү). . . .

[Гэхдээ би] жилийн энэ үеийг тэвшин дэх нялх хүүхдийн талаар бодох тохиромжтой үе гэж боддог. Ирээдүйд болох зүйлүүдээс сүрдэх эсвэл тэдгээрийн талаар санаа зовох хэрэггүй. . . . Тэнгэрлэг бошиглолын биелэл, Түүний дэлхийн амьдралын эхлэлийг тунгаан бодохын тулд чимээгүй, амар тайван хэдэн хормыг зарцуул.

Түр амсхийх, амар тайван байх, оюундаа энэ бяцхан хүүхдийг төсөөлөн харах цаг гарга. Түүний эсвэл таны амьдралд юу тохиолдох бол гэж тэгтлээ санаа зовох хэрэггүй. Үүний оронд, дэлхийн түүхэн дэх хамгийн амгалан мөч буюу "Дээр өндөрт алдар нь Бурханд байх болтугай, доор газарт амар тайван нь Түүний таалалыг олсон хүмүүст байх болтугай" (Лук 2:14)[6] гэсэн захиастай хамт тэнгэр баясаж байсан мөчийг тунгаан бодоход амар тайван хэдэн мөчийг зориул. ■

2017 оны 12-р сарын 12-нд Бригам Янгийн Их Сургууль дээр хэлсэн "A Message at Christmas" үгээс авав.

ЭХ СУРВАЛЖ

1. *Teachings of Presidents of the Church: Gordon B. Hinckley* (2016), 330.
2. "Мөн хаант улс болгонд хууль өгөгдсөн болой; мөн хууль болгонд тодорхой хязгаарууд тэрчлэн мөн нөхцөлүүд буй. Тэдгээр нөхцөлийг мөрддөггүй бүх хүмүүн зөвтгөгддөггүй бөлгөө" (Сургаал ба Гэрээ 88:38–39). Бурхан хамгийн дээд хаант улсын хуулийг дагаж мөрддөг. Тиймээс "Тэрээр бүх зүйлийг ухамсарладаг, мөн бүх зүйл түүний өмнө байдаг, мөн бүх зүйл түүний эргэн тойронд байдаг, мөн тэрбээр бүх зүйлийн дээгүүр, мөн бүх зүйлд байдаг, мөн бүх зүйлээр дамжсан байдаг, мөн бүх зүйлийн эргэн тойронд байдаг; мөн бүх зүйл түүгээр, мөн түүнээс, бүр Бурханаас, үүрд мөн мөнхөд болой" (Сургаал ба Гэрээ 88:41).
3. "Тийм ээ, мөн миний хүмүүс наманчлах болгонд би тэднийг миний эсрэг алдаануудад нь өршөөх болно" (Мозая 26:30).
4. Сатаныг дагадаг тэдгээр нь адил зорилготой бөгөөд Их Эзэний тунхагласанчлан "Хууль зөрчигч, мөн хуулийг мөрддөггүй атлаа өөрөө өөртөө хууль бий болгохыг эрэлхийлдэг, мөн нүгэлд байхыг хүсдэг, мөн бүхэлдээ нүгэлд байдаг тэр нь хуулиар ч, мөн нигүүлслээр ч, шударга ёсоор ч, мөн шүүлтээр ч ариусгагдаж чадах нь үгүй. Тиймийн тул, тэд бузар хэвээр үлдэх ёстой" хэмээн орчин үед тодорхойлсон байдаг (Сургаал ба Гэрээ 88:35).
5. *Teachings: Gordon B. Hinckley,* 331.
6. Д.Тодд Кристофферсон, "Амар амгалан бай," *Лиахона,* 2015 оны 12-р сар, 36.



GETTY IMAGES-ИЙН ЗУРАГ



Ахлагч Ричард Нийцэл Холзапфэл
Бусийн дал, Юта бус

БҮХ ХҮНД тохинуулах нь

Ахлагч Угдорфын энгийн бөгөөд ердийн арга замаар тохинуулах уриа сайн мэдээг хуваалцдаг арга замыг тань хэрхэн өөрчилж чадах вэ?

Сүмийн удирдагчид илүү ариун, илүү дээгүүр түвшинд тохинуулах бидний хүчин чармайлтын нэг хэсэг болгож, "тэдний нэр тохинуулагч эгч, ахын нэрсийн жагсаалтад тань байгаа эсэхээс үл хамааран тэдэнд тохинуулах"[1] гишүүн номлогчийн ажлын талаар ярьж эхлээд байна. Энэ илүү сайн арга зам бол сэтгэлгээний өөрчлөлт буюу бид яагаад, хэрхэн бусдад үйлчлэх талаар бүхнийг өөрчилж чадах ахисан түвшний хандлага юм.

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дийтр Ф.Угдорф ийн тэмдэглэн хэлсэн. "Өөрийнхөө хувьд хамгийн энгийн, эвтэйхэн гэсэн байдлаар Есүс Христ болон Түүний Сүм яагаад таны хувьд чухал болохыг хүмүүстэй хуваалц. Тэднийг *'ирээд, хар'* хэмээн урь. Тэгээд тэднийг *ирж, туслахад* урамшуул. Сүмд маань хүмүүст туслах олон боломж боломцоо бий.

Номлогчдыг зөвхөн сонгогдсон хүмүүсийг олоосой гэж бүү залбир. *Ирээд харах, ирээд туслах, ирээд үлдэх* хүмүүсийг олохын төлөө өдөр бүр бүхий л зүрх сэтгэлээрээ залбир."[2]

Тохинуулах гэдэг нь Аврагчтай адилхан зүрх сэтгэлтэй, өрөвчхөн, Есүс Христийн илүү үнэнч, хөрвөгдсөн

шавь болно гэсэн үг юм. Их Эзэн биднийг хайрладаг тул бусдад энгийн, ердийн арга байдлаар бусдад үйлчлэх замаар өсөж хөгжихийг уриалсан. Энэ нь тохинуулал *хийх* тухай бус, харин Есүс Христтэй адил тохинуулагч *болох* тухай юм.

Томилогдсон хүндээ тохинуулж сурах

Бид хэрхэн тохинуулагч ах, эгч болоход суралцсаар байна. Ийм өөрчлөлтийг хийхэд цаг хугацаа шаардагдах ба бид алдаа гаргах нь гарцаагүй. Миний бодлоор ийм алдаануудын нэг бол тохинуулын даалгаврыг энгийн бөгөөд ердийн бус, зүгээр л нэг “хуурамч” эсвэл “албадлагын” нөхөрлөл гэж үзэн үл тоомсорлох явдал юм. Гэвч Их Эзэн тохинуулагч ах, эгч нарын хувьд бидэнд тодорхой даалгавар өгдөг. Ингэснээр Тэр хэнийг ч үлдээхгүй байхад анхаардаг.

АНУ-д байгалийн гамшиг болоход Улаан загалмай нийгэмлэгээс болон Үндэсний хамгаалах албанаас сайн дурын ажилтнуудаа дайчлан, өргөн цар хүрээг хамруулахын тулд тэдэнд тодорхой хэсгүүдийг хуваарилан хариуцуулдаг. Даалгавар хүлээн авах нь сайн дурынхны зориулж буй цаг хугацаа, хайрыг сайн дураараа өгөөгүй мэт болгодог гэсэн үг биш юм. Амьдралд нь гай гамшиг тохиолдож байсан ямар ч хүн ийм даалгаврыг хүлээн авахдаа эргэлздэггүй. Хүлээн авагч хүн хэн нэгнийг туслахаар ирсэнд талархдаг.

Үндэсний хамгаалах алба, Улаан загалмайн нийгэмлэгийн сайн дурынхны адил бид ариун нандин гэрээ байгуулан Есүс Христийн шавь болсноор бусдад туслах тодорхой үүрэг

Бүгдэд тохинуулахын тулд эргэн тойрондоо байгаа буюу Их Эзэний бидний замд тавьсан хүмүүсийг харах зүрх сэтгэл, мэлмийтэй байх хэрэгтэй.



даалгаврыг гүйцэтгэхээр сайн дураараа оролцдог.

Эдгээр даалгавар ихэнхдээ алдаан дээрээ үндэслэн тохинуулах чадвараа дээшлүүлэн суралцаж, өсөж хөгжих боломж олгодог. Гэвч бидний хөлд, хэлд орж, дугуй унаж, хөгжмийн зэмсгээр тоглож, спортоор хичээллэж сурдагтай адил тохинуулал нь тун удалгүй бидний "хоёрдогч мөн чанар" болж эхэлнэ.

Бүгдэд "энгийн, ердийн арга замаар" тохинуулах гэдэг нь юу гэсэн үг вэ?

Тохинууллын даалгаврууд маань биднийг "бүх хүнд" энгийн бөгөөд эвтэйхэн байдлаар тохинуулахад бэлтгэдэг. Бүгдэд тохинуулахын тулд эргэн тойрондоо байгаа буюу Их Эзэний бидний замд тавьсан хүмүүсийг харах зүрх сэтгэл, мэлмийтэй байх хэрэгтэй. Тэр үед "тохинуулал" нь тэднийг "ирээд, хар" эсвэл "ирээд, тусал" гэж урихтай адил энгийн, ердийн зүйл болсон байна.

Аврагч үлгэр жишээ үзүүлсэн. Есүс Өгөөмөр нутгийн ариун сүмд хүмүүс дээр ирээд, тэдэнд "Гэвч эдүгээ би Эцэгт очиж, мөн түүнчлэн Израилын төөрөлдсөн овгуудад өөрийгөө үзүүлэхээр явлаа" (3 Нифай 17:4) хэмээн хэлсэн.

Аврагчид ч гэсэн бидэнтэй адил явах газар байсан юм. Уг түүх цааш нь:

"Мөнхүү улиран тохиох дор Есүс ийн яриад, тэрбээр дахин цугларсан олны зүг хараа бэлчээж, мөн тэд нулимс унагаж буйг, мөн тэд өөрийг нь тэдэнтэй хамт дахин хэсэгхэн зуур ч гэсэн үлдэхийг гуйх мэт түүний зүг тэд ширтэн харж байхыг болгоов.

Мөн тэрбээр тэдэнд: Болгоогтун, *та нарт хандсан өрөвдөх сэтгэлээр зүрх сэтгэл минь дүүрэв*" (3 Нифай 17:5–6; тодотгол нэмэгдсэн)[3] хэмээн хэлэв.

Аврагч өөр газар очихоор төлөвлөсөн байсан ч Түүнд харах нүд, мэдрэх зүрх байсан тул тэнд үлдэж тохинуулсан.

"Та нарын дунд өвчтөнүүд байна уу? Тэднийг наашаа авчрагтун. Доголон, эсвээс хараагүй, эсвээс хазгар, эсвээс тахир дутуу, эсвээс уяман өвчтэй, эсвээс татанги, эсвээс дүлий, эсвээс ямар нэгэн байдалд зовж зүдэрсэн нэгэн байна уу? Тэднийг нааш авчрагтун мөн би тэднийг эдгээх болно, учир нь та нарыг өрөвдөх сэтгэл надад буй; зүрх сэтгэл минь нигүүлслээр дүүрэв" (3 Нифай 17:7).

Аврагчийн хэн болохыг бид мэддэгчлэн, Түүний хувьд дараагийн газраа очихын өмнө өвчтөнүүдийг эдгээх нь ердийн зүйл байсан. Бидний хувьд бүгдэд энгийн бөгөөд ердийн арга замаар тохинуулахад аль хэдийн хийхээр эсвэл оролцохоор төлөвлөсөн үйл ажиллагаандаа хэн нэгнийг урих явдал орж болох юм.

Хэрэв та бие даах чадвар хөгжүүлэх хичээлд сууж байгаа бол хөршөө хамт явахад урь. Хэрэв та тойргийнхоо үйл ажиллагаанд очих гэж байгаа бол цуг ажилладаг хүнээ хамт явахад урь. Харин та гэр бүлээрээ судраас суралцах юм уу гэр бүлийн үдэш хийх гэж байгаа бол найзыгаа нэгдэхэд урьж болно. Энэ нь "ирээд, хар" гэсэн үг юм. Энэ нь завгүй хуваарьтаа нэг үйл ажиллагааг нэмж оруул гэсэн үг биш. Түүнчлэн тухайн хүн дээр очих боломжгүй үед мессеж бичиж, э-мэйл илгээж эсвэл утсаар ярин тохинуулж болно.

Тохинуулахаар итгэл хүлээсэн нь

Ерөнхийлөгч М.Рассэлл Баллард намайг Юта Провогийн Залуучуудын нэгдүгээр гадасны шинэ ерөнхийлөгчөөр онцгойлон адислахдаа "Удирдагчид болон гишүүдээ гэр оронд нь очиж эргэ" гэсэн энгийн

бөгөөд тодорхой даалгавар өгсөн юм. Тэр үүнээс өөр ямар ч сургалт, даалгавар өгөөгүй.

Бид гадасны чуулган болсноос хойш хоёр өдрийн дараа буюу мягмар гаргаас эхлэн өөрсдийн гаргаж буй хүчин чармайлтыг бишопынхтойгоо уялдуулан холбосон. Бид гадсандаа тохинуулж байхдаа алдаа гаргаж, боломж бололцоогоо алдан, заримдаа "Би ингэж хэлдэг байж уу?" эсвэл "Би илүү сайн асуулт тавьдаг байж" гэж боддог байсан.

Бригам Янгийн Их Сургуулийн ерөнхийлөгч Кэвин Ж. Вортэн "бүтэлгүйтэл бидний мөнхийн өсөлт хөгжлийн буюу төгс болох аян замын чухал хэсэг юм. Хэрэв бид бүтэлгүйтэлдээ зөв арга замаар хандах юм бол Цагаатгалын ачаар бүтэлгүйтэл маань төгс төгөлдөр болох үйл явцын нэг хэсэг болох боломжийг олгодог шинэ суралцах боломжоор биднийг адислах болно"[4] хэмээн хэлсэн.

Бид гадасны удирдагч, гишүүдэд болон уулзсан бусад хүндээ тохинуулж сурахдаа ийм туршлага олж авсан юм. Үргэлжлүүлэн тохинуулах үед Их Эзэн бидний замд илүү олон хүнийг тавьж эхэлсэн.

Нэг удаа би өөрийн нэг зөвлөх Ж.Б.Хоустай хамт орон сууцны хорооллоор явж байгаад машины зогсоол дээр нэг залуутай таарав. Бид түүнтэй мэндлэхээр түр зогсоод, манай гадаснаас шилжиж байгааг нь мэдэж билээ. Бид хэсэг ярилцаад, итгэлдээ эргэлзэж буй, эргэж ирсэн номлогч болохыг нь мэдсэн юм. Миний зөвлөх хүмүүстэй амархан холбоо харилцаа тогтоодог, сайн мэргэшсэн багш байлаа. Ийм асуултад хариулах нь Ж.Б-ийн хувьд энгийн бөгөөд ердийн зүйл байсан тул тэднийг ярилцаж байх хооронд тэр залуугийн нүдэнд алга болсон байсан оч дахин гэрэлтэхийг би харсан юм.

Ж. Б түүнийг болон түүний асуулт, асуудлыг анхааран, сонирхож байгаа нь илт байв. Ж.Б залууд сайхан сэтгэлээр хандаж байсан тул өөрийгөө түүнд нээсэн байлаа. Манай зөвлөхийн "зүрх сэтгэл хайраар дүүрэн" байсан тул тэр залууг шүүмжлэлгүйгээр ойлгохыг хүссэн. Шинэ байрандаа төвхнөснийх нь дараа очиж болох уу хэмээн Ж.Б-ийг асуухад залуу толгойгоо дохиж, тэд гар утасны дугаараа солилцоод, дараа уулзалдахаар тохиров.



Явахаасаа өмнө бидний тусламж хэрэгтэй эсэхийг асуухад тэр "Өнөөдрийн хувьд надтай мэндлээд өнгөрсөн чинь л надад зориулан хийж болох хамгийн чухал зүйл байлаа" гэсэн юм. Тэр орой надад "Хэрэв Ж.Б. бид хоёр гадуур тохинуулахаар яваагүй байсан бол энэ залуутай хэзээ ч уулзахгүй байх байсан" гэсэн бодол төрж билээ.

Их Эзэн тэр орой биднийг тохинуулна гэдгийг мэдэж байсан тул уулзаж, тохинуулна хэмээн найдаж, тэр залууг бидний замд тавьсан бололтой.

Бид өдөр тутмын ердийн амьдралдаа бүх хүнд тохинуулах хүсэлтэй байвал Их Эзэн биднийг гар утаснаасаа салан өнгийж, танихгүй хүн рүү инээмсэглэнэ, зах дээр эсвэл сургууль, ажил, сүм гээд хаана ч байсан тааралдсан хүндээ асуулт тавина гэдэгт итгэдэг тул хүмүүсийг бидний замд гарган тавих болно.

Тохинууллын гайхалтай үр дүн

Би 3 Нифай дээрх Аврагчийн үлгэр жишээг эргэж хараад, тохинууллын чухал зарчмыг олж мэдсэн юм. Та нарын санаж байгаагаар:

"Мөнхүү улиран тохиох дор түүнийг тийн ярихад, бүх цугласан олон, нэгэн зэрэг, өвчтэй мөн зовж зүдэрсэн, мөн доголон, мөн хараагүй, мөн хэлгүй, мөн ямар нэгэн байдлаар зовж зүдэрсэн тэд бүгдтэйгээ урагшлав; мөн тэрбээр тэднийг түүнд авчрагдахад нэг бүрчлэн эдгээв.

Мөн тэд бүгд, эдгээгдсэн тэд мөн эрүүл байсан тэд аль аль нь, түүний хөлд доош бөхийн мөн түүнийг бишрэв; мөн цугласан нь олон байсан хэдий ч ирж чадсан болгон нь түүний хөлийг үнсэж, үүний хэрээр түүний хөлийг тэд нулимсаараа булхав" (3 Нифай 17:9–10; тодотгол нэмэгдсэн).

Таньж мэддэг, хайрладаг хүмүүсээ Есүс Христэд авчран илүү их ойртуулж тусалсан эдгээр тохинуулагч ах, эгч өөрсдийгөө мөн адил Аврагчийн хөлд бөхийн, бишрэн шүтэж, хөлийг нь үнсэж, нулимсаараа булхсаныг ойлгогтун.

Бид бусдад тохинуулахдаа Христийг сэтгэл санааны болон сүнслэг мөн бие махбодын шархнуудыг эдгээхийг харах болно. Түүнчлэн бид бусдыг энгийн бөгөөд ердийн байдлаар "ирээд, хар," "ирээд, тусал" хэмээн урьснаар өөрсдийнхөө шархыг эдгэж байгааг ухаарах болно. ■

Бид өдөр тутмын ердийн амьдралдаа бүх хүнд тохинуулах хүсэлтэй байвал Их Эзэн хүмүүсийг бидний замд гарган тавих болно.



ЭХ СУРВАЛЖ

1. Дийтр Ф.Угдорф, "Номлолын ажил бол зүрх сэтгэл доторхоо хуваалцах явдал юм," *2019 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 14.
2. Дийтр Ф.Угдорф, "Номлолын ажил бол зүрх сэтгэл доторхоо хуваалцах явдал юм," 14.
3. Лук 7:11–16-д Есүс Христ хэрхэн ийм арга замаар Найны бэлэвсэн эмэгтэйд тохинуулсныг олж мэднэ үү.
4. Kevin J Worthen, "Successfully Failing: Pursuing Our Quest for Perfection" (Brigham Young University devotional, Jan. 6, 2015), 3, speeches.byu.edu.

ОЙРТОН ОЧИХ: Аврагчтай адил хайрлах нь

Бид Аврагчийн бусадтай харилцах үлгэр жишээнээс ихийг сурах боломжтой.

Бэки, Бэннэтт Бордэн

Бид Сүмийн гомо гэгдэх гишүүдийн хувьд, Сүмийн гишүүдтэй болон бусадтай хэрхэн харилцаагаа хамгийн сайнаар авч үлдэж болохыг ойлгоход туслуулахдаа Аврагчийн үлгэр жишээг үргэлж дагадаг байсан. Нэг өдөр бид Аврагч биднээс хэрхэн “Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биенээ хайрлагтун” (Иохан 13:34) хэмээн хүссэн талаар бодож байв. Тэрээр “би та нарыг хайрласан *учраас* гээгүй, харин” “би та нарыг яаж хайрласан *шиг*” гэсэн нь бидэнд сонирхолтой санагдсан. Энэ нь Аврагч хүмүүсийг *хэрхэн* хайрладаг байсан юм бол гэж бодоход биднийг хүргэв. Тэр ямар байдлаар хайраа харуулдаг байсан бэ?

Бид Шинэ Гэрээг, ялангуяа Аврагч мөнх бус амьдралдаа бусадтай хэрхэн харьцаж байсан тухай түүхүүдийг судлахад цаг гаргахаар шийдэв. Бид хоёр хоёулаа ижил хүйстэндээ татагддаг эхнэр, нөхрийн хувьд, ялангуяа нийтийн ерөнхий ойлголтоос ангид байдаг бололтой хүмүүст Есүс хэрхэн ханддаг байсныг илүү сайн ойлгохыг хүссэн юм. Энд анзаарсан хэдэн загвараа дурдъя. Үүнд:

Есүс соёлын ялгааг элдгээр хүлээн авдаг байсан

Бид Аврагчийн амьдралынхаа туршид үзэж туулсантай адилхан, нийгмийн болон улс төрийн хувьд асар их талцаж буй цаг үед амьдарч байна. Түүний амьдарч байсан цаг үе дэх зарим асуудал урт удаан хугацаанд байсан, түүхийн болон соёлын итгэл үнэмшилд гүн гүнзгий суурилсан байв.

Жишээ нь, Их Эзэн олон зуун жил үргэлжилсэн дайсагналын улмаас иудейчүүдийн зайлсхийлдэг байсан Самари нутгаар зориуд дайрч аялсан. Есүс нэгэн эмэгтэйтэй таарч, түүнээс ус татаж өгөхийг хүсэхэд тэрээр Түүнд иудей, самари үндэстний хоорондын ялгаанаас болж улс төр, шашны хувьд “өөр” хүн гэдгээр нь хандсан бололтой. (Иохан 4-ийг үзнэ үү.) Харин Есүс хариуд нь тэр эмэгтэйтэй Бурханы охин гэдгээр нь харьцсан. Тэр энэ эмэгтэйтэй хайраар, сэтгэлээсээ ярилцсан нь бид бүхэнд агуу үлгэр жишээ болдог. Дайсны түгээмэл ашигладаг башир арга бол тэр биднийг өөр хооронд нь тулалдуулахаар өөр өөр хуаранд салгадаг явдал юм. “Их Эзэн зүрхийг нь хардаг” (1 Самуел 16:7).

Энэ түүхээр өгсөн сургамжийг манай өнөөгийн нийгэмд хэрэгжүүлэх амархан. Бид өдөр бүрийн ердийн амьдралдаа, Сүмийн цуглаан болон үйл ажиллагаан дээр янз бүрийн нөхцөл байдалтай хүмүүстэй таардаг. Заримыг нь бүр улс төр, соёлын дайсан хэмээн нэрлэж ч болно. Бид ялгаж салгадаг зүйлс дээр биш, харин Тэнгэрлэг эцэг эхийн хүүхдүүдийн хувьд нийтлэг зүйлс дээрээ анхаарлаа хандуулж, бусадтай Аврагчийн адил хайраар ярилцаж сурах сонголтыг хийж чадна.

ХУДАГ ДЭЭР, КРИСТАЛ КЛЭУС

Аврагч амилсныхаа дараа Америк дахь хүмүүс дээр айлчлан очиж, “Чөтгөр нь . . . зөрчилдөөний эцэг юм, мөн тэрбээр хүмүүний зүрх сэтгэлийг нэг нэгэндээ уурлан зөрчилдөхөд өдөөн хатгадаг” (3 Нифай 11:29) хэмээн заасан. Хүмүүс Түүнийг сонсож, дараагийн үеийнхэн нь “баян ба ядуу, боол ба чөлөөт гэж байсангүй, харин тэд бүгдээр эрх чөлөөтэй, мөн тэнгэрлэг бэлгээс хүртэгсэд болгогдсон” (4 Нифай 1:3) нийгмийг бүтээлцжээ.

Есүс холдон явахын оронд ойртон очсон

Есүс гол төлөв шоовдорлогдон нийгмээс адлагдсан хүмүүсээс Өөрийгөө тусгаарлах шалтаг хайхын оронд тэдэнд сэтгэлээрээ, бүр биеэр ойртохыг хичээдэг байсан.

Жишээ нь, Есүс нэг удаа хатингир гартай хүнтэй таарчээ. Хүндэтгэлийн өдөр байсан тул шашны зан үйлээс болоод тухайн өдөр зарим зүйл хийж болохыг хориглосон байв. Есүс нийтээрээ хүлээн зөвшөөрсөн боломж гартал тусламж хэрэгтэй хүнээс зайлсхийхийн оронд нэн даруй “сайн[ыг] үйлдсэн” (Матай 12:12) юм. Тэрээр уг хүнд хандан гараа сунга гэв. “Тэр сунгамагц гар нь нөгөөтэйгөө адил зүгээр болов” (Матай 12:13).

Судар дээр үүнтэй төстэй түүх олон бий. Есүс бузар хэмээн тооцогдсон эмэгтэйд өрөвч сэтгэлээр хандаж, (Лук 8-ыг үзнэ үү), олон дуу хоолой сонсож, өөрийгөө зүсдэг байсан хүнийг хүлээн авч, эдгээн (Марк 5), хүмүүс буруугаар ойлгодог байсан хүнийг эдгээсэн (Иохан 9:1–7-г үзнэ үү). Судраас харж болох нэг загвар бол “Есүс гараа сунгахдаа” (Матай 8:3) ихэвчлэн бусдыг урамшуулж, хайрлаж, эдгээж, амар амгаланг өгдөг байв.

Магадгүй биднээс өөр байж болох хүмүүстэй илүү их ойрт гэсэн урилгыг бид эдгээр түүхээс авч болох юм. Жишээ нь, бусдаас өөр маягаар хувцасласан хэн нэгнийг сүмд ирэхэд бид түүний хажууд суух уу? Бид үүдний танхимд өрнөж буй яриандаа тэдэнд зай гарган, оролцох боломж олгох уу? Бид тэдэнтэй илүү сайн танилцаж, бидний нэг хэсэг гэдгийг мэдрэхэд нь туслан, инээмсэглэн мэндчилж, эелдэг байдлаар асуулт тавьдаг уу?

Хамгийн чухал нь, бид Аврагчийн адил амар амгалан, хайраа хуваалцаж, бусадтай сэтгэл санааны болон сүнслэг байдлын хувьд хэрхэн дотно харилцаатай болж болох вэ? Хичээл зүтгэл гарган, ялангуяа өөрөөсөө өөр хүмүүстэй холбогдвол Бурхан биднийг адисалдаг гэдгийг бид мэднэ.

Есүс хүмүүсийг хамт хооллоход урьдаг байсан.

Бид Шинэ Гэрээг судалж байхдаа, Аврагчийг байнга бусадтай хамт хооллодог байсанд сэтгэл хөдөлсөн. Тэрээр цагийг хамт өнгөрүүлэхээр сонгосон хүмүүсээсээ болж олон удаа шүүмжлүүлж байв.

Нэг жишээ нь, Есүс “татвар хураагч” буюу тухайн цаг үед эрх баригч засгийн газрыг төлөөлж байсан Матай гэгч хүнийг Өөрийн шавиар дуудсан (Лук 5:27-г үзнэ үү; Судруудын удирдамж, “Татвар хураагч”). Иудейчүүд татвар хураагчдыг ихэнхдээ үзэн яддаг байв. Тиймээс Матайг Есүст болон Түүний шавь нарт зориулан томоохон зоог барихад Бурханы зарлигуудыг дагадаг хэмээн өөрийгөө үздэг байсан хуулийн багш нар болон фарисайчууд гомдолложээ. “Та нар чинь яагаад татвар хураагч нар ба нүгэлтнүүдийн хамт идэж ууж байдаг билээ?” гэхэд Есүс “Эмч эрүүлд нь бус, өвчтэйд нь хэрэгтэй” (Лук 5:30–31) хэмээн хариулжээ.

Энэ бол Аврагч гадна төрх, дэлхийн нэр хүнд зэрэгт автахгүй байхыг сонгож байсны тод жишээ юм. Харин үүний оронд Тэрээр хувь хүн бүрийн хэрэгцээ, үнэ цэн, чадавхад анхаарлаа төвлөрүүлдэг байсан. Есүсийг Матайтай болон бусадтай цуг хооллож байсан тухай уншиж байхад нэг сонирхолтой зүйл бидний анхаарлыг татаж билээ. Бид хүмүүстэй холбогдохгүй бол хэзээ ч тэдэнд нөлөөлж чадахгүй. Бид тэднийг таньж

ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД

Сүмд ижил хүйстэндээ татагдах гэх мэт эмзэг сэдвийг сайн мэдээний өнцгөөс харж сайтар ойлгоход тань туслах эх сурвалж бий. **ChurchofJesusChrist.org** руу орж, “Living life”-ыг, дараа нь “Life Help”-ийг сонгоно уу.

КИДРОН ХӨНДИЙД ЕСҮС ШАВЬ НАРЫНХАА ХАМТ, БАЛАЖ БАЛО, УРАН ЗУРГИЙН САН

мэдэн, аян замынхаа хаана явж байгаагаас нь үл хамааран хайрлаж мөн хүлээн зөвшөөрөхгүй бол тэдний амьдралд нөлөөлж чадахгүй нь ойлгомжтой.

Та "нүгэлтнийг хайрла, нүглийг үзэн яд" гэхийг сонсож байсан байх. Бид энэ урилгын эхний хэсэгт хангалттай цаг зарцуулж чаддаг уу? Есүс бидэнд "бие биенээ хайрлагтун" (Иохан 13:34-ийг үзнэ үү) мөн "дал дахин долоон удаа" (Матай 18:22-ыг үзнэ үү) уучил хэмээсэн. Бид хэн нэгний нүглийг тодорхойлж, үзэн ядахад цаг заваа зарцуулахын оронд энэ хүчээ бусад ах, эгчтэйгээ харилцаагаа сайжруулахад ашиглаж болно.

Бид "нүгэлтнийг хайрла, тэднийг хоолонд урь" гэж хэлэх дуртай. Бид *бүгд* нүгэл үйлдсэн тул "Бурханы алдар сууд хүрдэггүй" (Ром 3:23). Тиймээс бид энэ боломжийг ашиглан, Бурханы Сүнс орших газар хайраар бэлтгэсэн зоогоор дамжуулан бусдад хангалттай сайн үйлчлэх ёстой. Бүгдээрээ чин сэтгэлээсээ эелдэг яриа өрнүүлэн, жинхэнээсээ нөхөрлөн, Есүс хэрхэн биднийг хардгийн адил бие биенээ харахыг хичээж, ширээгээ тойрон суцгаая.

Сионыг байгуулах

Энэ жил бид Есүс Христийн сайн мэдээ сэргээгдэнэ хэмээн тунхагласан Анхны үзэгдлийн хоёр зуун жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн. Бид дараа жил энэхүү эрин үед дэлхий дээр Их Эзэний хаант улсыг байгуулахад тусалсан эхэн үеийн гэгээнтнүүдийн үлгэр жишээнээс суралцана. Хэдийгээр улс үндэстэн, шашны итгэл үнэмшил, нийгэм эдийн засгийн гарал үүслийн хувьд өөр өөр байсан ч эхэн үеийн тэдгээр гэгээнтэн хамтран ажиллах, нэгдмэл байх арга замыг олох хэрэгтэй байв.

Өнөөгийн энэ цаг үед ч бидэнд үүнтэй адилхан боломж гарч ирдэг. Биднийг салган бутаргахыг хичээдэг соёлын болон улс төрийн ялгаанаас үл хамааран бид ямар нэг байдлаар итгэлдээ хэрхэн нэгдэх арга замаа ойлгох ёстой. Бид зөвхөн Аврагчийн удирдлаган доор үүнийг хийх боломжтой. Тэрээр бидний сул талыг төгс ойлгодог ба сул дорой зүйлсийг хүчирхэг болгож чадна (Ифер 12:27-г үзнэ үү). Тэр бидний зовлонг төгс ойлгодог ба биднийг эдгээж тусалдаг (Алма 7:11–12-ыг үзнэ үү). Тэрээр бидний өөр хоорондын ялгааг төгс ойлгодог төдийгүй Сургаал ба Гэрээ 49:25-д дүрсэлснээр бид Сионд цэцэглэн хөгжиж, баясана хэмээн амласан. Хамтдаа. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

Бэлэг хүлээн ав

Бурханы үгийг судлах, үйлчлэх, наманчлах, ариун сүмд очих зэрэг нь энэ Христийн мэндэлсний баяраар Бурханы хайрыг мэдрэхэд бидэнд тусална.

Иакоб Р.Жөүнс

11-р сарын нэг орой гэртээ иртэл хүүхдүүд маань унтлагын өрөөгөө Христийн мэндэлсний баярын үлгэрийн орон болгосон байв. Зул сарын гацуур мод, гялтганасан саа, хэлхээтэй гэрэл, цаасан цасан ширхгүүд булан тохой, орны хүрээ, хана, тааз зэргийг чимсэн байлаа. Түлээний мод, гэрэл, оймсоор чимэглэсэн, гараар хийсэн ханын зуухны дүр зургийг гүйцээж тавьсан байв. Христийн мэндэлсний баярын энэ сүрлэг дүр зураг гэр орон, зүрх сэтгэлийг маань дулаацуулсан юм.

Христийн мэндэлсний баярын талаарх миний дуртай өөр нэг дүр зургийг бошиглогч Нифай дүрсэлсэн байдаг. Нифайн эцэг Лихай жимс нь сэтгэлийг нь үлэмж баяраар дүүргэх сайхан жимстэй нэгэн модыг үзэгдлээр олж харснаа хуваалцсан (1 Нифай 8:12-ыг үзнэ үү). Нифай бас эцгийнхээ дүрсэлсэн модыг харах хүсэлтэй байв. Нифай залбирлынхаа хариуд уг үзэгдлийг харсан. Энэ үйл явдлын талаарх Нифайн цэдэг миний хувьд Христийн мэндэлсний баярын гайхамшигт түүх юм. Тэр ийнхүү бичжээ.

"Мөнхүү улиран тохиох дор би модыг хараад, Сүнсэнд хандан: Та надад бүхнээс эрхэм дээд тэр модыг үзүүлснийг би ухаарав хэмээн хэлэв.

Мөн тэрээр надад: Юуг хүснэв та? хэмээв.

Мөн би түүнд хариулж, өгүүлсэн нь: Үүний утгыг мэдэх хүсэлтэй гэв . . .

. . . Мөн би Назар хотыг үзэв; бас Назар хот дахь онгон бүсгүйг би харав, мөн тэрбээр үлэмж хонгор мөн цагаан байлаа. . . .

. . . Мөн тэр надад хандан: Болгоогтун, таны харж буй тэр онгон бүсгүй бол Бурханы Хүүгийн махан бодийн биеийг төрүүлэгч эх нь бөлгөө хэмээв.

. . . Мөн би сайхь онгон бүсгүйг дахин харж, гар дээрээ хүүхэд тэвэрсэн байхыг болгоов.

Мөн тэнгэр элч надад хандан: Бурханы Хургыг, тийм ээ, бүр Мөнхийн Эцэгийн Хүүг болгоогтун! . . . хэмээв" (1 Нифай 11:9–11, 13, 18, 20–21).

Нифай уг модны утгыг мэдэхийг хүсэхэд түүнд Христийн мэндэлсний анхны баярыг үзүүлсэн нь чухал ач холбогдолтой гэж би үздэг. Дараа нь Сүнс модны утгыг ойлгосон эсэхийг Нифайгаас асуухад Нифай энэхүү сүнсээр өдөөгдсөн дараах хариултыг өгчээ.

"Тийм ээ, энэ бол хүмүүний үрсийн зүрхэнд хааяагүй түгэх Бурханы хайр; иймийн тул, энэ нь бүхнээс илүү, хамгийн ихээр хүслийг татагч буюу" гэхэд

Сүнс "Тийм ээ, мөн бодгальд хамгийн их баясгалант болой" (1 Нифай 11:22–23) хэмээн нэмж хэлжээ.

Нифай энэ туршлагаараа дамжуулан бидний бодгальд хамгийн хүсүүштэй, баясалтай зүйл бол Бурханы Хүү, Есүс Христээр дамжуулан Түүний хайрыг мэдрэх явдал юм гэдгийг ойлгосон. Энэ бол Христийн мэндэлсний баярын жинхэнэ бэлэг юм. Гэвч бидний дунд олон хүн амьдралдаа, тэр бүү хэл энэ баярын өдрүүдэд ч Бурханы хайрыг мэдэрч чаддаггүй. Энэ Христийн мэндэлсний баярын өдрүүдэд Бурханы хайрын бэлгийг хүлээн авахын тулд бидний хийж болох дөрвөн зүйлийг доор санал болгон оруулав.

1. Бурханы үгсийг судлах

Судрууд, амьд бошиглогчдын үгсийг тогтмол судал эсвэл дахин судалж эхэл. Лихай үзэгдэлдээ мод руу хөтөлсөн "төмөр бариулыг" харсан (1 Нифай 8:19). Бурханы хайрыг мэдэрсэн хүмүүс төмөр бариулд



хүрч, зууран барьсаар модны жимснээс хүртэх хүртлээ тавилгүй, урагшилсаар байв (1 Нифай 8:30). Энэ төмөр бариул Бурхан үг байсныг Нифай мэдэж авдаг (1 Нифай 11:25-ыг үзнэ үү).

Бид Их Эзэний үгсийг судалснаар Түүнийг амьдралдаа урин авчирч болно. Бидний амлалт дааж давшгүй хүнд байх шаардлагагүй. Найзуудыгаа судраа хэр удаан судлах ёстой вэ гэж асуухад би дандаа "Сүнсийг мэдэртлээ унш. Дараа нь үргэлжлүүлж унших хэрэгтэй гэдгээ мэдэрч магад" гэж хариулдаг. Бидний унших цаг, шүлэг, бүлгийн тоо тийм ч чухал биш. Хамгийн чухал нь судлах явцдаа Сүнстэй хамт байхыг эрэлхийлэх хэрэгтэй. Их Эзэн бидний гаргасан хүчин чармайлтыг өчүүхэн гэлтгүй адислах болно.

12-р сарын *Ирээд, Намайг дага* судлах материалд Моронайн ном болон "Христийн мэндэлсний баяр" гэсэн онцгой бүлэг багтсан. Ариун ёслолын залбирлуудыг болон Моронай гэх мэт бошиглогчдын Есүс Христийн талаар хүчтэй хувийн гэрчлэлээ хуваалцсан үгсийг судлан, өөрсдийгөө судarт умбуулах шиг сайхан боломж өөр хаана байх билээ?

Бид бас *Ерөнхий чуулганы* сэтгүүлээс чуулганы үгсийг уншиж эсвэл Gospel Library дээрх тэдний үгийг сонсон, амьд бошиглогчдын үгсийг судалж болно. Лихайн зүүдэн дэх төмөр бариулын адил Христийн үгсийг шинээр судлах нь энэ Христийн мэндэлсний баяраар Бурханы хайрыг мэдрэхэд биднийг хөтөлж болох юм.

2. Үйлчлэх

Өсвөр насанд минь болж өнгөрсөн хамгийн нандин Христийн мэндэлсний баяр бол гэр бүлээрээ авга, нагац ах эгч, үеэлүүдтэйгээ хамт тусламж хэрэгтэй байсан орон нутгийнхаа гэр бүлд хувцас хунар, хоол хүнс, тоглоом, нүдний шил, цахилгаан бараа хандивлахад оролцсон явдал байв. Христийн мэндэлсний баярыг гэрт нь авчирсан урт цувааны нэгэн хэсэг байснаа би хэзээ ч мартахгүй. Энэ мэдрэмж Христийн мэндэлсний баяр өнгөрсний дараа ч хоногшиж үлдсэн бөгөөд ээжийнх нь болон дөрвөн хүүхдийнх нь талархсан сэтгэгдэл надад дурсамж болон үлдсэн юм. Тэр гэр бүлд үйлчилсэн нь миний зүрхэнд Бурханы хайрыг "хааяагүй түг[ээсэн]" (1 Нифай 11:22).

Бусдад үзүүлж буй үйлчлэл маань том эсвэл төвөгтэй байх албагүй. Бишопоор үйлчилж байхдаа ганцаардсан, түгшсэн эсвэл сэтгэлээр унасан хүмүүс манай орон нутаг, тойрогт ямар ч үед гарч ирж болно гэдгийг би мэдсэн. Утсаар ярих, санаа тавьсан мессеж, зэлдэг үгтэй ил захидал илгээх, гэртээ хийсэн амттанг өгөх, ойр зуур хамтдаа алхах эсвэл хэн нэгэнд хүүхдийг нь харж өгч туслах нь тэнгэрээс илгээсэн гайхамшиг, залбирлынх нь хариу байж болно.

Хэрэв бид Тэнгэрлэг Эцэгээсээ "Өнөөдөр миний тусалж чадах хэн нэгэн байна уу?" гэж асуувал нэр эсвэл царай төрх нь бидний оюун санаанд орж ирэн, Ариун Сүнсний өдөөлт уг хүнийг хэрхэн адисалж болохыг ойлгоход бидэнд тусална. Бид тэдгээр өдөөлтийн дагуу үйлдсэнээр Бурханы тэднийг гэсэн хайрыг мэдрэх болно.

Сүмийн “Дэлхийг гэрэлтүүл” санаачилга Бурханы хайрыг бусдад мэдрүүлэхэд туслах үйлчлэлийн энгийн үйлдлүүдийг санал болгодог. Энэ Христийн мэндэлсний баяраар үйлчлэлээр дамжуулан амьдралдаа Бурханы хайрын бэлгийг хүлээн ав хэмээх Сүнсний өдөөлтийг хүлээн авбал Дэлхийг гэрэлтүүл санаачилга танд эхлэхэд тусална (ComeuntoChrist.org руу орно уу).

3. Наманчлах

Гурав дахь урилга бол Аврагчийн наманчлалын бэлгийг хүлээн авах явдал юм. Далын ахлагч Линн Г.Роббинс “Наманчлал бол бүтэлгүйтлээс бүтэлгүйтэл рүү урам зоригоо алдалгүй явах боломжийг бидэнд олгодог, байнга боломжтой байдаг Бурханы бэлэг юм. Наманчлал бол биднийг бүтэлгүйтсэн үед хэрэгжүүлэх Түүний нөөц төлөвлөгөө биш. Харин наманчлал *бол* биднийг алдаа гаргана гэдгийг мэдэж байсан Түүний төлөвлөгөө мөн”[1] гэж заасан.

Энэ амьдрал хэцүү. Мөнх амьдралд хүрэх зорилгынхоо төлөө явах үед бид бүгдээрээ хүчин мөхөсдөж, Христийн Цагаатгалын гэтэлгэгч хүч бидэнд хэрэг болдог. Аврагчийн бидний гэм нүглийн шийттэлийг сайн дураараа Өөр дээрээ авахаар сонгосон шалтгаануудын нэг бол бидэнд наманчлалын бэлгээс хүртэх боломж олгох явдал байв. Тэрээр төлөөсийг нь аль хэдийн төлсөн. Бидэнд зөвхөн Түүний дараах урилгыг хүлээн авах эсэхийг сонгох л үлдсэн.

“Тиймийн тул, наманчилж мөн бяцхан хүүхдийн адил надад ирэх хэнийг боловч, би түүнийг хүлээн авах болно, учир нь Бурханы хаант улс бол ийм хүмүүсийнх юм. Болгоогтун, ийм хүмүүсийн төлөө би амиа өгч, мөн үүнийгээ буцаан авсан юм; тиймийн тул наманчил, мөн дэлхийн хязгаарууд та нар надад ир, мөн аврагдагтун” (3 Нифай 9:22).

Сүнс бидэнд ачаагаа буулга хэмээн сүнслэг өдөөлт өгдөг ч бид бүгдээрээ ямар нэгэн нүглийн ачааг үүрч явдаг гэж би боддог. Манай бишоп, гадасны ерөнхийлөгчид бидэнд тусалж чадна. Аврагч сайхан сэтгэлтэй, өршөөнгүй тул Өөрийн үйлчлэгчдэд энэ сэтгэлээсээ хуваалцдаг. Тэд биднийг хайрлаж, Аврагчийн Цагаатгалаар дамжуулан эдгэрэхэд тусалдаг. Бид бүгдээр Аврагчийн Өөрт нь ирэх саналыг хүлээн авч, Христийн мэндэлсний энэ баяраар эдгэрч чадна.

4. Их Эзэний өргөөнд морилох

Түүний хайрыг хамгийн их мэдэрч байсан мөчүүдийн маань зарим нь Бурханы ариун сүмүүдэд тохиосон. Би тэнд сайхан эхнэртэйгээ энэ амьдралд төдийгүй мөнхөд лацдан холбогдсон. Би тэнд шийдвэр гаргахад туслах удирдамж хүсэн, хүнд бэрх үед амар амгаланг олохоор очдог. Ариун сүмд тэнгэрт арай илүү хурдан хүрч, илчлэлт арай илүү урсан ирдэг мэт санагддаг.

Ариун сүмийн ёслолууд гээд Мелкизедек санваарын ёслолуудын талаар Их Эзэн “Тиймийн тул, үүний ёслолуудад бурханлиг чанарын хүч илэрхийлэгддэг” (Сургаал ба Гэрээ 84:20) хэмээн хэлжээ.

Ариун сүмийн ёслолуудад оролцсоноор бид Бурханыг таньж эхэлдэг бөгөөд амар амгалан, бурханлаг амьдралын хүч бидний амьдралд ирдэг.

Ерөнхийлөгч Томас С.Монсон (1927–2018) “Биднийг ариун сүмд очиход хүмүүний зүрх сэтгэлд төрж болох аливаа мэдрэмжээс хавьгүй хол давсан сүнслэг байдлын цар хүрээ, амар амгалангийн мэдрэмж бидэн рүү ирдэг”[2] хэмээн амласан.

Хэрэв та амар амгаланг мэдрээгүй хэсэг хугацаа өнгөрсөн бол энэ Христийн мэндэлсэн баярын өдрүүдэд яагаад ариун сүмийг дахин нээгдэхэд ариун сүмд байнга орж байх шинэ амлалтын эхлэлийг тавьж болохгүй гэж? Хэрэв та хишгээ хараахан хүртээгүй байгаа бол танай тойрог эсвэл салбарын удирдагчид танд бэлтгэхэд тусална. Бид бас өвөг дээдэс маань ариун сүмийн адислалуудыг хүлээн авч болохын тулд тэдний нэрсийг олж, илгээснээр Бурханы хайрыг мэдэрч чадна.

Жинхэнэ бэлэг

Бурханы үгс, чин сэтгэлийн үйлчлэл, наманчлах, ариун сүмийн ёслолуудад оролцох зэрэг нь бүгд Христийн мэндэлсний баярын жинхэнэ бэлгийг хүлээн авах боломж юм. Төлөөлөгч Иохан “Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн” (Иохан 3:16) хэмээн бичсэн. Энэ Христийн мэндэлсний баяраар бидний хүн нэг бүр Бурханы Хүү, Есүс Христээр дамжуулан Түүний гайхамшигт хайрын бэлгээс хүртэхэд бидэнд туслах эдгээр зүйлийг сонгохдоо Сүнсээр удирдуулах болтугай хэмээн би залбирч байна. ■

ЭХ СУРВАЛЖ

1. Линн Г.Роббинс, “Дал дахин долоон удаа,” *2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 25.
2. Томас С.Монсон, “Ариун сүмийн адислалууд,” *2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 77.

Дэлхийг гэрэлтүүлцгээе арга хэмжээ Парист

Жоржэтт Лалаус, Франц, Франц Иль Де Франц

Үйлчлэх нь дүрслэхийн аргагүй баяр баясгаланг авчирдаг ба энэ жижиг үйлдлүүд хувь хүмүүсийг гайхалтай арга замаар өргөн дэмждэгийг би мэдсэн юм.

Гудамжны орон гэргүй хүмүүс, Францын Парисын цэцэрлэгт хүрээлэнд унтах дүрвэгсдийн зэрэгцээ бусдад туслах хэрэгцээ Христийн мэндэлсний баярын өдрүүдэд ч гэсэн бидний нүдний өмнө илхэн байсаар. Би хоёр найзтайгаа хамт тусалж чадах газраа тусламж үзүүлэхээр Хамтдаа үйлдэх эв санааны нэгдэл хэмээх орон нутгийн бүлэг байгуулахаар шийдсэн юм.

Орон нутгийн олон сайн дурынхны болон Парис дахь гурван гадасны хожмын үеийн гэгээнтнүүдийн дэмжлэг туслалцаатайгаар бид тусламж хэрэгтэй ах дүүсдээ туслахаар Дэлхийг гэрэлтүүлцгээе арга хэмжээг зохион байгуулсан.

Гурван жил дараалан бид жилийн эцэст Дэлхийг гэрэлтүүлцгээе аяныг зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээнд Парисын янз бүрийн сүм, байгууллагын уран бүтээлчид, сайн дурынхан, зочид ирж тоглолт хийн, тусламж хэрэгтэй хүмүүст хандив өгдөг. Олон сар бэлддэг ч сайн дурынхан болон дуучид, бүжигчид, жүжигчид энэ арга хэмжээнд оролцсоноор гайхалтай баяр хөөрийг мэдэрдэг. Хэн ч үүнд оролцох боломжийг алдахыг хүсдэггүй. Манай гурав дахь удаа зохион байгуулсан Дэлхийг гэрэлтүүлцгээе арга хэмжээ жолооч нарын ажил хаялттай давхацсан ч 82 оролцогч ирсэн.

Арга хэмжээ болохоос өмнө бид Парис дахь дүрвэгсэд, орон гэргүй хүмүүст тараах зорилгоор эрүүл ахуйн бүтээгдэхүүнээр дүүргэсэн үүргэвч олныг бэлтгэн, цуглуулсан юм. Бид бас дүрвэгсдэд өгөх хөнжил, даавуу, дэр, спорт хэрэглэл, шүршүүрийн шаахай, бүр унадаг дугуйг хүртэл цуглуулсан.

Өнгөрсөн жил бид арга хэмжээний үеэр загварын үзүүлбэр бас зохион байгуулсан юм. Уг арга хэмжээнд оролцсон 22 настай загвар зохион бүтээгч хүлээн авсан дэмжлэг нь түүнд өөрийн чадавхад итгэх хүчийг өгсөн хэмээн хэлсэн. Түүнтэй ярилцсан явдал хүн бүрд хэн нэгэнд хэрэгтэй гэдгээ мэдрэх хэрэгтэйг мөн бид бүхэнд ямар нэг хэрэгцээ үргэлж байдгийг сануулсан.

Бид дараа жилийг тэсэн ядан хүлээж байгаа бөгөөд илүү олон хүн оролцож, олон олон үйл ажиллагаа багтана гэж төлөвлөж байна. Зарим нь бүр биднийг тусламж хэрэгтэй хүмүүсийг эрүүл тэнцвэртэй хоолоор хооллохоор орон нутгийн агентлагуудтай хамтран ажиллах мөн олон улсын кейтерингийн томоохон компанитай түншлэн ажиллахад агуулах, хөргөлтийн фургонуудоор туслахаар санал болгосон. Мөн бид франц хэлийг хоёрдогч хэл болгон сурч байгаа хүмүүст зориулан үнэ төлбөргүй франц хэлний хичээл заах арга хэмжээ зохион байгуулж байгаа.

Сайн үйлсийн төлөө үйлчлэх нь хязгааргүй их баяр баясгаланг авчирдгийг би олж мэдсэн. Жижиг жижиг үйлдэл хувь хүмүүсийг гайхалтай арга замаар өргөн дэмждэг. Бидэнд өгсөн инээмсэглэл, талархал бидэнд илүү ихийг хийх эрч хүч өгдөг. ■

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АЛЛЭН МАРЭЛЛО

Шорон дахь залбирлын хүч

Порша Лаудэр, АНУ, Юта

Би тэр Христийн мэндэлсний баярын өмнөх оройг хэзээ ч мартахгүй.

Би үл хөдлөх хөрөнгийн залилангийн хэргээр холбооны шоронд дөрвөн жил хагас хоригдсон юм. Тэнд байгаа эмэгтэйчүүдийн ихэнх нь дуугүй, бусадтай хүндэтгэлтэй харьцдаг хүмүүс байв. Хэсэг хугацааны дараа 10 эмэгтэй миний өөдөөс харсан өрөөнд шилжиж ирсэн юм.

Тэд шөнө орой болтол инээлдэж, чанга хөгжим сонсдог байв. Тэдний байгаа байдал бусдад хэрхэн нөлөөлж байгааг тэд тоодоггүй байлаа. Өрөөнийхөн маань намайг тэдэнтэй ярилцуулахыг хүссэн ч ихэвчлэн иим яриа шоронд сайнаар өнгөрдөггүй байв. Үүний оронд би энэ эмэгтэйчүүдийг зан байдлаа өөрчилж, тайван амгалан байдалд эргэж орохын төлөө залбирсан ч байдал улам бүр дордож байлаа.

Нэг орой би залбирч байхдаа, хөршүүдтэйгээ танилцахын тулд ямар ч хүчин чармайлт гаргаагүйгээ ухааран ойлгосон юм. Би маргааш нь тэдний өрөөнд орж, тэдэнтэй ярилцав. Тэд надад гэр бүл, хайртай хүмүүсийнхээ зургуудыг үзүүлэв. Тэд бас хэтэрхий чанга дуутай байсандаа уучлал гуйж билээ. Тэр үеэс хойш тэд намайг харахаараа даллаж, баяртай байгаагаа илэрхийлдэг болов.

Христийн мэндэлсний баяр болохоос хэдэн долоо хоногийн өмнө тэд намайг Христийн мэндэлсний баярын өмнөх оройн хоолонд урьсан юм. Бид бас өөрсдөдөө тохиолдсон сүнслэг туршлагуудаа бие биетэйгээ хуваалцахаар төлөвлөв. Христийн мэндэлсний баярын өмнөх орой бид хамтдаа цугларан, хэдэн цаасан чимэглэл өлгөлөө. Христийн мэндэлсний баярын мод байгаагүй ч бид амар амгалангийн сүнсийг мэдэрч билээ. Бид туна загас, төмсний чипсээр даруухан оройн зоог барьсныхаа дараа туршлагаасаа хуваалцав. Бид бүгдээрээ өөр өөр шашин шүтлэгтэй, өөр өөрийн гэсэн өвөрмөц түүхтэй байсан ч зүрх сэтгэл маань хоорондоо холбогдож, Сүнс тэнд оршиж байсан.

Април бидэнд 14-тэй байхад нь ээж нь хар тамхи хэтрүүлэн хэрэглэснээс болж нас барсан тухай ярив. Тэр гудамжинд гарч, 15 насандаа хүүхэд төрүүлж, хүүхдээ үрчлүүлсэн байлаа. Тэр хар тамхинд донтож бас хар тамхи наймаалж эхэлсэн бөгөөд эцэст нь шоронд орсон байв.

"Нэг өдөр би, яагаад би амьд яваа юм бол гэж бодсон. Би үхсэн байлаа ч юу ч өөрчлөгдөхгүй. Хэн ч намайг шоронд орсныг мэдээгүй. Намайг үхсэн ч хэн ч мэдэхгүй өнгөрнө гэж бодсон" гэж Април хэлж билээ. Дараа нь тэр залбирч, өөрийг нь хэн болохыг мэдэх эсэхийг Бурханаас асуусан байв.

Дараагийн долоо хоногт шоронгийн зөвлөх түүнд үрчлүүлсэн охиноос нь ирсэн захидлыг өгөхдөө, "Бурхан чамайг харж хандаж байгаа бололтой" гэж хэлжээ.

Април "Би одоо охиндоо захидал бичдэг мөн тэр намайг нэг удаа эргэж ирсэн. Би шашны талаар сайн мэдэхгүй ч Бурхан миний залбиралд хариулсан тул надад санаа тавьдгийг нь мэддэг болсон" гэж хэлж билээ.

Априлыг түүхээ хуваалцсаны дараа бид бүгдээрээ нүдэндээ нулимс цийлэгнүүлэн чимээгүй суунгаасан.

Би шоронд байх хугацаандаа Тэнгэр дэх Эцэгтээ хандан, гэр бүлийг минь харж хамгаалаач хэмээн зүрх сэтгэлээ уудлан, залбирдаг байв. Харин би шоронгийн хажуу өрөөний хүмүүсийнхээ төлөө залбирахдаа тэдний бурханлаг чадавхыг олж харан, Аврагчийн хайр, нигүүлслийг илүү бүрэн дүүрэн мэдрэх болсон юм.

Шоронд өнгөрүүлсэн тэрхүү Христийн мэндэлсний баярын өмнөх орой гайхалтай сайхан байсан. ■

ЗУРГИЙГ ФИЛ АРТ

Христийн мэндэлсний баярын бэлэг үү, аравны нэг үү?

Анна Виллиамс, АНУ, Алабама

Би сайн мэдээг үнэн гэдэгт итгэдэг байсан ч аравны нэгээ төлж чадах болов уу?

Номлогч эгч нар надад Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийг танилцуулах хүртэл би сүмийг хайж явсан юм. Би сар хагасын дараа баптисм хүртэж, гишүүнээр батлуулсан. Номлогчдын надад заасан зүйлсийн нэг бол аравны нэгийн зарчим байв.

“Хэрэв та аравны нэгээ төлбөл адислалууд хүлээн авах болно” гэж тэд надад хэлсэн.

Би өрх толгойлсон эх байсан бөгөөд олсон мөнгө маань арай гэж хоол хүнсэнд бас төлбөрөө төлөхөд хүрэлцдэг байв. Ихэнхдээ аравны нэгээ төлөх үү, хоол хүнсээ худалдаж авах уу мөн ус цахилгааныхаа мөнгийг төлөх үү эсвэл машины төлбөрөө хийх үү гэдэг асуудал гардаг байв.

Олон жилийн турш би аравны нэгээ ямар нэгэн байдлаар төлөхийг хичээсээр ирсэн. Эцэст нь би “Хэрэв чи сайн мэдээ үнэн гэдэгт итгэдэг байвал анхны алхмаа тавих хэрэгтэй. Анхны алхмаа тавьж чадах л юм бол Бурхан чамайг адисалж чадна” гэж хэлсэн юм.

Би аравны нэгд 500 доллар төлөх ёстой байсан ч зарим төлбөр тооцоогоо хийхэд дахин 503 доллар хэрэгтэй байв. Би энэ бүхэн яаж биелэгдэхийг сайн мэдэхгүй байсан ч “Оролдоод үзье” гэж шийдэв. Тэгээд би аравны нэгээ төлж билээ. 503 доллар нэмж хэрэгтэй байсныг маань хэн ч мэдээгүй байсан ч хэн нэгэн нэрээ нууцлан, надад 100 долларын таван дэвсгэрт шуудангаар илгээсэн байлаа.

Энэ нь миний хувьд бүх зүйлийг орвонгоор нь өөрчилсөн мөч байсан юм. Энэ намайг сүнслэг байдлын хувьд өөрчилсөн. Бурхан надад хайртай, надад санаа тавьдаг, намайг амжилттай байгаасай хэмээн хүсдэгийг би ухаарч билээ. Тэр цагаас хойш би аравны нэгээ төлдөг болсон. Гэхдээ энэ нь үргэлж амар байгаагүй.

Олон жилийн өмнө, Христийн мэндэлсний баяраар том охин маань намайг аравны нэгээ төлж *бас* охиндоо болон дүү нарт нь Христийн мэндэлсний баярын бэлэг авч өгч чадахгүй гэж хэлж байсныг санадгаа ярьж билээ.

“Бид юу ч авахгүй юм байна гэдгээ мэдэж байсан ба авахгүй байсан ч гомдохгүй байв. Бид ч бас таныг аравны нэгээ төлсөн нь дээр гэж шийдсэн” гэж охин маань дараа нь надад хэлсэн юм.

Их Эзэн үргэлж биднийг харж ханддаг байсан ба тэднийг Христийн мэндэлсний баярын бэлэггүй үлдээж байгаагүй.

Хүүхдүүдээ тэжээж, аравны нэгээ төлөх нь ганц бие эхийн хувьд том асуудал. Би аравны нэгээ төлөх шийдвэр гаргасан тэр мөчөөс эхлэн адислагдсан. Би баян биш ч Их Эзэн надад үргэлж замыг маань бэлдэж өгдөг.

Би бас өөр арга замаар адислагдсан. Сүмийн гишүүдийн болон гэр бүлийн сайн үлгэр жишээ намайг болон хүүхдүүдийг маань Сүмдээ идэвхтэй хэвээр үлдэхэд тусалсан юм. Энэ бүхэн Их Эзэний өгнө хэмээн амласан буюу тэнгэрийн цонхыг нээнэ хэмээн амласан адислалынх нь нэгэн хэсэг болохыг бид тэдэнд хэлсэн. ■

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АЛЛЭН ГАРНС

Хэн нэг нь дараа жил байхгүй

Рэбэкка Кларксон, АНУ, Калифорни

Христийн мэндэлсний баярын өмнөх орой би гэрийнхэндээ хэчнээн их хайртайгаа бодов. Ийн бодож суутал нэгэн онцгой мэдрэмж төрөв.

Христийн мэндэлсний баярын өмнөх орой байлаа. Гэр бүлийнхээ уламжлалын дагуу бид шинэ унтлагын хувцсаа өмссөн байв. Хүүхдүүд Христийн мэндэлсний баярын хөгжим тавьж, эргэн тойронд хүн бүр бүжиглэж байлаа. Уурлаж уцаарласан хүнгүй, бүгд баяр хөөртэй, инээмсэглэж, хөгжилдөж байв. Би давхар биетэй болсноо мэдэж байсан тул гэр бүлийнхэндээ хэчнээн их хайртайгаа, бас ахиад нэг хүүхэдтэй болж байгаадаа хэчнээн их баярлаж байгаагаа бодон суусан юм.

Ийн бодож суутал нэгэн онцгой мэдрэмж төрөв. Гэр бүлийн маань нэгэн гишүүн дараа жил бидэнтэй хамт байхгүй хэмээн Сүнс надад шивнэлээ.

Орой нь нөхөр Тимтэйгээ хамт модны доор бэлгүүдээ тавьж байх зуур гэр бүлийн маань нэг гишүүн дараагийн Христийн мэндэлсний баярын өмнөх орой бидэнтэй хамт байхгүй хэмээн тэр уг орой төрсөн мэдрэмжээ надад хэлж билээ. Надад ч гэсэн мөн адил мэдрэмж төрснийг би Тимд хэлэв.

Христийн мэндэлсний баярын дараа өөр мужид байдаг гэрийнхэн дээрээ айлчилж очихоор явахынхаа өмнө Тим аялж байх замдаа аюулгүй байх талаар хүүхдүүддээ заасан юм. Аян замдаа гэр бүлийн гишүүнээ алдах вий гэхээс айж байсан ч бүх зүйл сайхан болохыг баталсан мэдрэмж бидэнд төрөв. Бид аялж, гэрийнхэн дээрээ маш сайхан зочилж, гэртээ аюулгүй буцаж ирлээ.

Удалгүй жирэмсний хуваарьт үзлэгийн цаг маань боллоо. Эмч гунигтай мэдээ хэлэв. Хэт авиан шинжилгээгээр хүүхэд үзлэг болохоос хоёр долоо хоногийн өмнө эндсэн байсныг тогтоосон юм.

Тим бид хоёр машинаараа гэр рүүгээ явж байхдаа сэтгэлээр унасан байсан ба хоёр долоо хоногийн өмнө Христийн мэндэлсний баярын өмнөх орой байсныг ойлгосон. Сүнс яг хэзээ биед ордгийг мэдэхгүй ч хүүхэд маань хэсэгхэн хугацаанд боловч Христийн мэндэлсний баярын өмнөх орой гэр бүлтэйгээ хамт байж, тойрон бүжиглэж, аз жаргалтай байсныг Тим бид хоёр мэдэрч билээ. Бид маш их баяр баясгаланг мэдэрсэн ба хүүхэд маань үүний нэгэн хэсэг байсныг мэдсэн. Тэр биднийг орхин одоходоо, дараагийн Христийн мэндэлсний баярын өмнөх орой бидэнтэй хамт байхгүй байх, гэр бүлийн маань тэрхүү гишүүн болсон гэдэгт итгэдэг. Хэзээ нэгэн өдөр бид хүүхдээ дахин харна гэдэгт би итгэдэг. Энэ итгэлийг надад өгдөг амар амгаланд би талархдаг. ■

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КЭНДРА БИННИ

Моронай 1–6
(11-Р САРЫН 30-ААС 12-Р САРЫН 6)

Бид Моронайн номоос юу сурч болох вэ?

Моронай үймээн самуунтай цаг үед амьдарч байсан. Тэр нифайчуудын эцсийн устгалыг, эцэг нь дайнд үрэгдэхийг (Мормон 8:3-ыг үзнэ үү), Есүс Христийг үгүйсгээгүй нифайчууд алагдахыг харсан (Моронай 1:2-ыг үзнэ үү). Моронай бас “Христийг үгүйсгээгүй” (Моронай 1:3-ыг үзнэ үү). Тэр аюулаас дайжиж, олон жилийн турш нууглаж амьдарсан.

“Би өөр цөөн хэдэн зүйлийг би бичье” (Моронай 1:4)

Энэ үед Моронай ялтаснууд дээрх бичээс нь дууссан гэж бодож байсан ч “ирээдүйн нэг өдөр, . . . ах дүүст минь чухал байж магад хэмээх тул [тэр] өөр цөөн хэдэн зүйл бичих нь” (Моронай 1:4) Их Эзэний таалал байв.

Тэр яагаад үүнийг бичсэн бэ?

Моронай Мормоны Номын бурханлаг зорилгыг мэдэж байсан тул бичих зүйлсээ сайн бодож сонгох хэрэгтэй байв. Моронайн номыг уншсаныхаа дараа, Моронай цэдэглэсэн зүйлсээ яагаад сонгосныг асуухыг бодоорой. Тэр юуг чухал гэж бодож байсан бэ? Моронайн сүүлчийн гэрчлэл Мормоны Номын талаарх таны бодол санаанд хэрхэн нөлөөлсөн бэ?

Тэр юу бичсэн бэ?

Моронай Мормоны Номын 8, 9-р бүлгийг нэмж, Иферийн номд өөрийн хураангуйллыг оруулж, Мормоны ялтаснууд дээр өөрийн номыг (Моронайн номыг) нэмжээ.

Моронайн бичээст бидэнд үнэ цэнтэй олон зүйл агуулагддаг. Тэрээр Сүмийн үйл хэргийн талаар бичиж (Моронай 1–6-г үзнэ үү), өөрийн эцэг Мормоны заасан зүйлсийг багтаан, (Моронай 7–9-ийг үзнэ үү), сүүлчийн гэрчлэлээ цэдэглэн үлдээсэн юм (Моронай 10-ыг үзнэ үү).

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АНДРЮ БОСЛИ

Моронай 7–9

(12-Р САРЫН 7–13)

“Та нар юуны төлөө найдах билээ?” (Моронай 7:41)

“Та нар **Христийн** цагаатгал, мөн түүний амилалтын хүчээр, мөнх амьдралд босгогдохын тулд **найдахыг** би та нарт хэлье, мөн энэ нь амлалтын дагуу түүнд итгэлтэйн тань учир болой”

(Моронай 7:41).

СОХОР ХҮНИЙГ ЭМЧИЛСЭН НЬ, КАРЛ БЛОХ

Моронай 10
(12-Р САРЫН 14–20)

Би сүнслэг бэлгүүдийг хэрхэн эрэлхийлэх вэ?

Бурхан бидэнд туслахын тулд сүнслэг бэлгүүдийг Ариун Сүнсээр дамжуулан өгдөг (Моронай 10:8-ыг үзнэ үү). Бидний хүн нэг бүр Бурханы сүнслэг бэлгүүдээр адислагдсан ба хүлээн авч болох олон бэлэг бий.

Зарим сүнслэг бэлгийг судруудад тодорхойлсон байдаг ч (Моронай 10:9–16; Сургаал ба Гэрээ 46:13–25-ыг үзнэ үү) заримыг тодорхойлоогүй байдаг. Бурханы танд өгсөн сүнслэг бэлгүүдийг та хэрхэн тодорхойлж, хөгжүүлж чадах вэ? Та бусад бэлгийг хэрхэн хөгжүүлж чадах вэ? Танд туслах хэдэн санаа өгье.



Асуух

Бурхан таныг ямар ямар сүнслэг бэлгээр адисалсныг эсвэл ямар бэлгийг хөгжүүлэхийг хичээх вэ гэдгээ залбирч асуу. Тэрээр чамд туслах болно. Таны патриархын адислал сүнслэг бэлгүүдийг тань түүнчлэн илчилж болох юм. Хэрэв та патриархын адислалаа аваагүй бол авах талаар бишоптойгоо эсвэл салбарын ерөнхийлөгчтэйгөө ярилцах талаар бодож үз.

Суралцах

Сүнслэг бэлгүүдийг хүлээн авахын тулд хүчин чармайлт гаргах шаардлагатай. Тодорхой бэлэг хүлээн авахыг хичээхдээ судар, патриархын адислал зэргээс эсвэл Ерөнхий чуулганд хэлсэн үгсээс энэ талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл олж авахыг бодож үз. Та бусад хүнээс туршлагынх нь талаар асууж болно.

Үйлдэх

Сүнслэг бэлгүүдийн талаар суралцах нь тустай ч бид уг мэдлэгээ ашиглах хэрэгтэй. Та Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлж, наманчлан, гэрээнүүдээ сахиснаар сүнслэг бэлгүүдийг хүлээн авах эрхтэй болно. Мөн сүнслэг бэлгүүдээ ашиглаж болох нөхцөл байдлыг олж мэдээрэй. Эдгээр бэлэг бидэнд төдийгүй бусдад ч ач тустай гэдгийг бүү март (Сургаал ба Гэрээ 46:26-г үзнэ үү). Та бусдад туслахын тулд энэ сүнслэг бэлгүүдээ хэрхэн ашиглаж болох вэ?

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БЭТ ЖЭППСОН

Христийн мэндэлсний баяр

(12-Р САРЫН 21–27)

Мормоны Номын бошиглогчид Христийн мэндэлсний баярын талаар бидэнд юу заадаг вэ?

Дараах судруудыг унших үед бошиглогч бүр Аврагчийн мэндэлсэн талаар бидэнд юу заасан байна вэ? Бодол санаагаа бичиж тэмдэглэхийг эсвэл гэр бүлийнхэнтэйгээ хуваалцахыг бодоорой.

Хиламаны хүү Нифай (ойролцоогоор МЭ 1 он)
"Их Эзэний дуу хоолой түүнд ирж, хэлсэн нь: . . . маргааш бибээр дэлхийд ирэх болно" (3 Нифай 1:4–22-ыг үзнэ үү).

Нифай (ойролцоогоор МЭӨ 600 он)
"Би хүүхэд тэвэрсэн онгон бүсгүйг болгоов. Мөн тэнгэр элч надад хандан: Бурханы Хургыг, тийм ээ, бүр Мөнхийн Эцэгийн Хүүг болгоогтун!" (1 Нифай 11:13–33-ыг үзнэ үү) хэмээн хэлсэн.

Абинадай (ойролцоогоор МЭӨ 148 он)
"Тийм ээ, мөн дэлхий эхэлснээс хойш бошиглож асан бүр бүх бошиглогчид—. . . Бурхан өөрөө хүмүүний үрсийн дунд доош ирэхийг . . . тэд хэлсэн бус уу?" (Мозая 13:33–35-ыг үзнэ үү).

Хаан Бенжамин (ойролцоогоор МЭӨ 124 он)
"Их Эзэн хүмүүний үрсийн дунд . . . бууж ирэх болно, . . . тэрээр Есүс Христ, Бурханы Хүү хэмээн нэрлэгдэх болно, . . . мөн түүний эх Мариа гэгдэх болно" (Мозая 3:5–11-ийг үзнэ үү).

Залуу Алма (ойролцоогоор МЭӨ 83 он)
"Тэр Мариагаас төрөх болно, . . . бүр Бурханы Хүү" (Алма 7:7–13-ыг үзнэ үү).

Лемен үндэстэн Самуел (ойролцоогоор МЭӨ 6 он)
"Дахин таван жил өнгөрөхөд, мөн болгоогтун, тэгэхэд Бурханы Хүү ирэх болно" (Хиламан 14:1–13-ыг үзнэ үү).

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ДАН БӨРР

Би хүүхдүүдтэйгээ сайн мэдээний талаар **энгийн байдлаар** хэрхэн ярилцах вэ?

НЭМЭЛТ ЭХ СУРВАЛЖ

- “Хүндэт эцэг эхчүүд ээ,” (*Найз* сэтгүүлийн арын хуудсанд)
- “Хүүхдүүдтэйгээ хамт өнгөрүүлсэн цаг мөч ба хонин гурвэл, дэвхрэг хоёр” (2019 оны 6-р сарын *Лиахона*)
- “Хүүхдүүдээ хамгаалах нь” (2019 оны 10-р сарын *Лиахона*)
- “Хүндхэн сэдвүүдээр ярилцах нь” (2015 оны 3-р сарын *Лиахона*)

Эцэг эхийн хувьд бид хүүхдүүддээ сайн мэдээний талаар заах үүрэгтэй. Гэвч сайн мэдээний талаар ярилцахдаа албархаг, ёсорхуу байх албагүй. Өдөр тутмын амьдралдаа сайн мэдээний талаар ярилцлага өрнүүлэх хэд хэдэн санааг дурдав.

Албан бус ярианы 7 цаг үе

Хамт хооллох эсвэл унтахаар зэхэж байхад

Хүүхдэд тань хүнд хэцүү зүйл тулгарах үед

Ярилцлага эхлүүлэх 7 арга зам

Бидний үзсэн Ерөнхий чуулган дээр хэлсэн үгнүүдийн талаар чи юу бодож байна вэ?

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ЖӨҮЗИ ПОРТИЛЛО

Найз нөхдийн чинь хэн нэг нь шашны зүйлүүдийн талаар асуусан уу?

Та нээлттэй, зүрх сэтгэлдээ хайраар дүүрэн байж мөн сонсож, ойлгох хүсэлтэй хандаж чадвал хэзээ ч ярилцаж болно.

Сүнслэг захиастай холбоотой ямар нэг зүйл олж харахдаа

Гэр бүлийн түүхийн талаар эсвэл өвөг дээдсийнхээ тухай ярьж байхад

Үйлчлэлийн төслийн явцад эсвэл бусдад тусалж байхад

Сүмийн цуглаан, үйл ажиллагааны өмнө эсвэл дараа

Сүүлийн үед бидний *Ирээд, Намайг дага* гарын авлагаас уншсан зүйлүүдээс юу нь санаанд чинь одоо хүртэл байна вэ?

Өнөөдөр чамд сүм дээр ямар нэгэн асуух зүйл гарсан уу?

Би сүүлийн үед энэ судрын талаар бодож байгаа. Чи энэ тухай юу гэж бодож байна вэ?

Чи сүүлийн үед судраас юу уншсан бэ? Чамд ямар нэгэн асуулт байна уу?

Чиний дуудлагат ажил (эсвэл Сүмийн бусад үүрэг даалгавар) хэр явагдаж байна вэ? Чамд юу тус болох вэ?

Бодол ба санаа

- **Сайн мэдээний талаар асуух зүйл гарч ирэх нь ердийн зүйл гэдгийг хүүхдүүддээ заа.** Эцсийн эцэст асуулт л Иосеф Смитийг тус-ламж хүсэн залбирч, Анхны үзэгд-лийг үзэхэд хөтөлсөн. Бүх хариултыг аваагүй ч гэрчлэлээ хөгжүүлж чадна гэдгийг ойлгоход нь тэдэнд тусал.
- Гэр бүлийн үдшээр, сүм дээр эсвэл нар жаргах гайхалтай цаг мөчид гээд ямар ч үед **Сүнсийг мэдэрснээ онцолж бай.** Энэ нь Сүнс бидэнд хэрхэн ярьдгийг таньж эхлэхэд тэдэнд туслах болно. Сүнс бол халуун дулаахан, хөнгөн мэдрэмж, тодорхой бодол санаа, амар амгалан мэдрэмж гээд олон замаар бидэнтэй харилцдаг гэдгийг тайлбарла.
- **Сайн мэдээний захиасыг хялбар, хүртээмжтэй болго.** Өсвөр насны хүүхэд тань утсан дээрх Сүмийн сэтгүүлийн нийтлэлийг харахгүй байж магад, гэхдээ ширээн дээрх *Лиахонаг* эргүүлэн харж магадгүй. Тэд чөлөөт цагаараа Ерөнхий чуул-ганыг сонсохгүй байж магад, гэхдээ таныг хоол хийх зуураа сонсож буй чуулганы хэлсэн үгээс хэдэн үг олж авч болох юм.
- **Хамгийн гол нь үр дүн өгөхгүй байгаа мэт санагдсан ч үргэлж-лүүлэн хийгээрэй!** Судруудад залуу Алмагийн адил эхэндээ үг сонсдог-гүй байсан хүүхдүүдийн түүх дүүрэн байдаг. Нэг л өдөр сүнслэг үнэнүүд тэдний сэтгэл зүрхэнд нэвтрэн орно гэдэгт та итгээрэй. ■

Залуучуудад зориулав

Энэ хэсэгт

44 **Зөв шударгаар шүүх (олон нийтийн мэдээллийн хэрэгсэл дээр ч гэсэн)**

Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий хорооны гишүүд *Лиахона* сэтгүүлийн ажилтнууд

48 **Төгс профайл зургийн цаадах бодит байдал**

Барбара Родригэз

Зөвхөн цахим хувилбараар

Чулуу шидэхгүй байх нь бидний үүрэг

Нэрийг нууцлав

Хэрхэн олон нийтийн мэдээллийн *хэрэгсэл дээр байгаа ч дотор нь орохгүй байх* вэ?

Фэйт Фэргүсон

Эдгээр болон өөр бусад нийтлэлийг доорх эх сурвалжаас олж авна уу.

- **liahona.ChurchofJesusChrist.org**
- **YA Weekly** (Gospel Library аппликэйшн дээрх "the Young Adults" хэсэгт буй)

Түүхээ хуваалц

Танд хуваалцах туршлага байна уу? Эсвэл та тодорхой нэгэн сэдвээр бичсэн нийтлэл уншмаар байна уу? Хэрэв тийм бол бид таныг сонсохыг хүсэж байна! Та өөрийн нийтлэл, санал, сэтгэгдлийг **liahona.ChurchofJesusChrist.org** руу илгээнэ үү.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг эерэг орон зай болгох нь

Таван жилийн өмнө нөхөр бид хоёр Есүс Христийн Сүмийн гишүүдийн хувьд хэрхэн амьдардгаа үнэн зөв хуваалцаж эхлэхээр YouTube суваг ашиглан ажиллахаар шийдсэн юм. Бид амьдралын хэв маягаараа дамжуулан итгэл үнэмшлийнхээ талаар ярих санаатай байсан.

Дагагчдын маань дундаас хэд хэдэн хүн анх удаа сүмд очиж, бүр баптисм хүртсэн тухай бидэнд дуулгасан ба энэ урамтай мэдээ биднийг асар ихээр адисалсан юм! Эдгээр мэдээ биднийг баяр баяслаар дүүргэж байлаа.

Олон нийтийн мэдээллийн сүлжээгээр дамжуулан амьдралаа бусдад харуулах замаар сэргээгдсэн сайн мэдээний захиасыг бусдад түгээх боломжтой байснаар баялаг туршлага хуримтлуулахад тусалсанд бид талархдаг. Хэдийгээр олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь гайхалтай туршлага хуримтлуулан, утга учиртай харилцаа үүсгэхэд тусалж, сайн мэдээний гэрчлэлээ хуваалцах боломжийг бидэнд олгодог ч нөгөө талаар энэ нь сүнслэг байдлын хувьд биднийг сулруулж, бусдыг шударга бус байдлаар шүүж, өөрсдийгөө үнэхээр хэн болохыг мартахад бас хүргэдэг.

Энэ сарын залуучуудад зориулсан хэсэгт энэ болон бусад сэдвийг хөндөх болно. Өөрсдийгөө эсвэл амьдралаа олон нийтийн мэдээллийн хэрэгслээр харж буй зүйлтэйгээ харьцуулахад амархан ч бид олон нийтийн мэдээллийн хэрэгслийг өөрсдийгөө болон бусдыг шүүмжлэхээс татгалзах, бурханлаг мөн чанартаа итгэлтэй болох, хамгийн чухал нь Есүс Христийн сайн мэдээний бидний амьдралд авчирдаг аз жаргалыг өөрсдийн үлгэр жишээгээр дамжуулан хүмүүст хүргэх зэрэг эерэг орчин болгон ашиглаж сурч чадна.

Bárbara

Барбара Родригэз

Зөв шударгаар **шүүх** (олон нийтийн мэдээллийн хэрэгсэл дээр ч гэсэн)

Бид Аврагчийн тусламжтайгаар, Түүний биднээс хүсдэг арга замаар шүүж сурах боломжтой.

Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий хорооны гишүүд болон *Лиахона* сэтгүүлийн ажилтнууд

"Бүү шүү."

Бид өнөө үед энэ үгийг, бусдыг шүүх эрхгүй гэсэн захиасын хамт дэлхий даяар их сонсох болсон. *Шүүмжлэх* гэдэг үгийг олон сөрөг утга дагалддаг. Гэвч бид Аврагчийн Сүмийн гишүүдийн хувьд, Түүний арга замаар шүүмжилбэл шүүмжилж болно хэмээн бидэнд Түүний зөвлөснийг мэднэ.

Мосегийн хуулиар Хүндэтгэлийн өдөр хийж болох зүйлсийг хязгаарладаг байсан тул Есүсийг Хүндэтгэлийн өдөр хүн эдгээхэд хатуу шүүмжилсэн ба Түүнийг эдгээр удирдамжийн дагуу үйлдэхгүй байна гэж хүмүүс үзэж байлаа. Гэвч тэднийг бусдаас алдаа олж харахдаа хурдан байгаад Аврагч зэмлэв. Тэр дараа нь "гаднах төрхөөр нь бүү шүү, харин шударга шүүлтээр шүү" (Иохан 7:24; Иосеф Смитийн Орчуулга, Матай 7:1–2-ыг үзнэ үү) хэмээн тэдэнд зөвлөжээ.

Бид Аврагчийг шүүсэн хүмүүстэй адил хэр олон удаа бусдыг шударга бусаар шүүдэг бол? Магадгүй бодож байгаагаас маань ч олон байх! Ялангуяа олон нийтийн мэдээллийн хэрэгслээр бусдыг шүүмжлэх амархан байдаг тул өнөөгийн дэлхий ертөнцийг зөв шударгаар шүүх Аврагчийн зөвлөгөөг бид хэрэгжүүлж сурах хэрэгтэй байж болох юм.

Шударга, шударга бус шүүмжлэлийг хооронд нь ялган таних

Шүүмжлэх нь бидний сонгох эрхийн нэгэн хэсэг юм. Ажил мэргэжлээ сонгох, цагаа хэнтэй, *хэрхэн* өнгөрүүлэх, ямар мэдээллийн хэрэгсэл ашиглах гэх мэт амьдралд шийдвэр гаргахын тулд шүүн тунгаах хэрэгтэй олон зүйл бий. Гэвч бид хэрхэн ийн шүүн тунгааж чадах вэ? Эцсийн эцэст *бүх* шүүмжлэл үнэхээр зөв шударга байж чадах уу?

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, ерөнхийлөгч Даллин Х.Өүкс хэрхэн зөв шүүж тунгаах талаар дараах зургаан удирдамжийг өгсөн юм. Дараах тохиолдолд бидний шүүмжлэл зөв шударга болохыг бид мэдэж авч болно. Үүнд:

1. Хэн нэгнийг "өргөмжлөл хүртэнэ эсвэл тамын галд эргэлт буцалтгүй хаягдана хэмээн мэдэгдэхээс татгалздаг" бол
2. "Уур хилэн, өс хонзон, атаархал эсвэл хувиа бодсон байдлаар бус, харин Их Эзэний Сүнсний удирдамжийн дагуу" бол
3. "Бидний ажил үүргийн хүрээнд" байвал



4. "Бодит мэдээлэл хангалттай өгсөн" байвал
5. Хүмүүсийн тухай биш, харин нөхцөл байдлын талаар бол
6. "Шударга жишиг хэрэгжүүлж байвал"[1] зэрэг юм.

Бошиглогч Моронай хэрхэн зөв шударга шүүх удирдамж өгсөн. "Сайн болох бүх зүйл Бурханаас ирдэг; мөн хилэнцэт болох тэр нь чөтгөрөөс ирдэг; учир нь чөтгөр Бурханы дайсан . . . мөн хилэнцэтийг үйлдэхэд үргэлж урьж мөн татдаг буюу" (Моронай 7:12).

Бид олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гүйлгэн харж, найзлах уу үгүй юу гэж бодохдоо эсвэл цагаа хэрхэн өнгөрүүлэхээ шийдэхдээ, шүүлт хийхийнхээ өмнө энэ пост/хүн/үйл ажиллагаа:

- надад амар амгалан, таатай мэдрэмж төрүүлж байна уу?
- намайг сайныг үйлдэхэд урьж байна уу?
- Бурханыг хайрлаж, Түүнд үйлчлэхэд надад тусалж байна уу гэж өөрөөсөө асууж болно.

Бүх сайн сайхан Бурханаас ирдгийг ойлгосноор бид бусдын болон өөрсдийнхөө талаар мөн амьдралаа юугаар дүүргэх тал дээр ухаалаг, зөв шударга шийдвэр гаргахдаа сонгох эрхээ ашиглаж чадна.

Шударга бус шүүлтийн эргүүлгээс гарах

Зөв шударга шүүлт гэж юу болохыг бид одоо ойлгосон тул шүүмжлэлийн сөрөг эргүүлэгт автагдах үедээ юу хийж болох вэ? Энд хэдэн жишээ авч үзье.

- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээс хол байх мацаг barь. Энэ нь танд амсхийж, бодол санаагаа цэгцэлж, бусадтай бодит байдлаар холбогдох боломж олгоно. Та олон нийтийн мэдээллийн хэрэгслээс гадуур аль болох олон хүнтэй уулзах тусам тэднийг бодит асуудалтай, бодитой хүн юм байна гэдгийг ойлгож, тэднийг шүүмжлэх тань багасна.
- Өөрийнхөө талаар пост оруулахын оронд танд урам зориг өгсөн хэн нэгний тухай пост оруулаарай. Тэр хүнийг ягаад хүндэлдгээ хүмүүст хэл. Энэ нь өөрөөсөө бусдыг харж, бусдад онцгой сэтгэгдэл төрүүлэхийн оронд бусдыг адислах боломж олгох юм.
- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан өдөр бүр хэн нэгэнд төрсөн өдрийн мэндчилгээ, баяр хүргэсэн үгс, сайхан үгтэй зурвас гээд чин сэтгэлийн үгтэй хариу бичиж байгаарай.
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл дээр дэндүү их юм хуваалцдаг, зөвхөн гайхалтай амралтынхаа талаар тавьдаг, төгс гэр бүлтэй юм шиг харагддаг эсвэл байнга хэрүүл хийдэг хүмүүс байсаар байх болно. Бид шүүхээ урьдал болголгүй "Их Эзэн энэ хүний талаар юу мэддэг бол, би тэдний талаар юу мэдэж авч болох вэ?" гэж өөрөөсөө асууж болно. Тэднийг Түүний хардаг арга замаар харахад туслахыг хүсэн залбир. Харин пост нь байнга сөрөг мэдрэмж төрүүлэх юм бол дагахаа хэзээ ч больж болно.

Хүн бүрийг тэнгэрлэг эцэг эхийн жинхэнэ хүүхэд гэдгээр нь харвал энэ нь тэдний талаарх өнгөцхөн ойлголтыг маань мөнхийн талаас харах чадвараар солино. Хүн бүрийн жинхэнэ мөн чанар, зорилгыг ухамсарлахад хүч чадал бий болдог. Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Мишэлл Крэйгийн хэлснээр:

"*Зөвхөн танд л байх тэнгэрлэг шинж чанар, зорилго бий. . . .*

Өөрийгөө бусадтай харьцуулах амархан. Бүх зүйл нь болж бүтэж байгаа юм шиг эсвэл биднээс илүү чухал мэт харагддаг хүмүүс байсаар байна. Гэвч тэдний зорилго биднийхээс өөр гэдгийг бид ихэвчлэн мартдаг. Бид өөрсдийн жинхэнэ мөн чанарын дагуу амьдрахыг хичээж, хувь хүний хувьд бидэнд онцгойлон өгсөн Бурханы бэлэг, авьяас чадварыг ойлгож, үнэлэх юм бол баяр баясгаланг жинхэнээсээ мэдрэх болно."[2]

Эцсийн эцэст олон нийтийн мэдээллийн хэрэгслээр шүүмжлэх эргүүлгээс гарахын тулд бид өөрсдөөсөө шалтгаалах зүйлээ хийх хэрэгтэй. Хэн нэгний амьдралд нөлөөлөхийн тулд өөрсдийн хүрээллийн гадуур харах ёстой. Үүний тулд бусдыг өргөн дэмжиж, Христийн Гэрлийг хуваалцах хэрэгтэй. Ийн үйлдсэнээр бид бусдад үйлчлэхийн зэрэгцээ өөрсдийнхөө талаар сайхан бодол тээдэг болно.

Өөрийгөө өөлөх, хортой байдлаар харьцуулж жишихээ болих

Өөрийн жинхэнэ мөн чанарын талаар зөв ойлголттой болоход саад болох нь Сатаны хүчирхэг зэмсгүүдийн нэг юм. Бид өөрсдийн жинхэнэ мөн чанараас холдвол өөрийгөө өрөвдөж, хайрлах мэдрэмжийг өөрийгөө өөлөх, шүүмжлэх бодлуудаар орлуулах болно. Бид бусдаас, өөрөөсөө, бүр Ариун Сүнснээс холддог.

Үнэндээ, харьцуулж жиших нь өөрсдийгөө харьцуулж байгаа хүнд биш, харин бидэнд, бидний өөртөө итгэх итгэлгүй байдалд оршдог. Харьцуулж жиших нь үнэндээ өөрсдийгөө шударга бусаар шүүж буй хэрэг юм.

Хэдийгээр харьцуулах нь баяр баясгалангийн *хулгайч*[3] байдаг ч өөрийн үнэ цэн, давуу тал, авьяас чадварыг мөн Тэнгэрлэг Эцэгийн бидэнд зориулсан зорилго болон өөрсдийн хэн болж чадахыг мэдэх нь баяр баясгалангийн *түлхүүр* байж болох юм.

Аврагч амьдралаа сайныг үйлдэхэд зориулсан (Үйлс 10:38-ыг үзнэ үү). Тэр ямар ч алдаа гаргалгүй, бусдын төлөө амьдарсан. Гэсэн хэдий ч Тэр адлуулж, шүүгдсэн. Гэвч Тэрээр Өөрийн үнэхээр хэн болохыг мөн зорилгоо мэддэг байсан тул шүүмжлэлийг толгой өндөр, хийх ёстой зүйлд нь саад болголгүйгээр давж чадсан.

Түүний үлгэр жишээг дагаснаар бид ч гэсэн Түүнтэй адил үйлдэж чадна. Дэлхий ертөнц харьцуулалт, шүүлтээр дамжуулан өөрсдийн хэн болохыг амархан алдаж чадах болгодог ч бид Хүүхдийн хэсгийн ерөнхий ерөнхийлөгч Жой Д.Жонс эгчийн зааснаар "Хэрэв Аврагчийг болон Түүний бидний төлөө хийсэн зүйлийг хайрлах хайр маань сул тал, өөртөө эргэлзэх эсвэл муу дадал хэвшил гэх мэт зүйлсэд зарцуулдаг хүчин зүтгэлээс илүү байх юм бол Аврагч амьдралд зовлон бэрхшээл авчирдаг зүйлийг ялан дийлэхэд бидэнд тусална. Тэр биднийг өөрсдөөс маань аврардаг"[4] болохыг мэдэж авч болно.

Бид "Бодгалийн үнэ цэнэ Бурханы мэлмийд агуу" (Сургаал ба Гэрээ 18:10) гэдгийг мэддэг. Одоо *бодгалийн* гэдэг үгийн оронд өөрийн нэрийг орлуулна уу. Энэ талаар сайтар бод. Тэнгэрлэг Эцэг таны нэрийг мөн үнэ цэнийг мэддэг. Тэрээр таны *энэ* их үнэ цэнийг мэддэг тул Түүний Цорын ганц Хүү таны төлөө амиа өгсөн.

Тиймээс дэлхий хүнд хүчир мэт санагдаж, харьцуулалт нөлөөлөх үед Тэдэнд ойртоорой. Тэгвэл өөртөө эргэлзэж, өөрийгөө шүүх мэдрэмж тань хийсэн алга болж, үнэлж баршгүй үнэ цэнээ мэдсэнээр ирэх өөртөө итгэх жинхэнэ итгэлийг олж авах болно.

Аврагч руу харах

Бид хийж буй бүх зүйлдээ үргэлж Аврагч руу харж, удирдамж хүсэж болно. Түүний Цагаатгалаараа дамжуулан бидэнд өгдөг зүйлсийн нэг бол өөрчлөгдөж мөн Түүний биднээс хийгээсэй хэмээн хүссэн бүхнийг хэрхэн хийхээ мэдэх боломж олгогч хүч юм. Хэрэв бид Түүнийг дагаж, Түүнд ойртохыг сонгох аваас зөв шударга бус шүүмжлэлээс салж, бусдыг болон өөрсдийгөө Аврагчийн нүдээр харж сурахад тусалдаг. ■

ЭХ СУРВАЛЖ

1. Dallin H. Oaks, "'Judge Not' and Judging," *Ensign,* Aug. 1999, 9–12.
2. Michelle Craig, "How Do You Feel Joy in the Lord?" Nov. 22, 2019, blog.ChurchofJesusChrist.org.
3. "Comparison is the thief of joy" is attributed to Theodore Roosevelt.
4. Жой Д.Жонс, "Хэмжээлшгүй үнэ цэн," *2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 141.

Төгс профайл зургийн цаадах **бодит байдал**

Бид олон нийтийн мэдээллийн хэрэгсэл дээрх зүйлстэй өөрсдийгөө харьцуулснаар том дүр зургийг харах чадвараа алддаг.

Барбара Родригэз

Саяхан инстаграм дээрх нэг дагагч маань зурган дээр минь "Би ганц хүүхэдтэй яая гэж байхад чи хоёр хүүхэдтэй байж яаж ийм сайхан гэрэлтэж чадаж байна вэ?" гэж сэтгэгдлээ үлдээсэн байв. Миний инээд шууд хүрч, яг тэр үед ямар харагдаж байгаа зургаа явуулахыг хүсэж билээ.

"Бусад ээжтэй харьцуулбал би өөрийгөө гадаад байдалдаа бараг анхаарал хандуулдаггүй гэж боддог. Энэ бол олон нийтийн мэдээллийн хэрэгслийн нөлөө юм. Бид өөр хэн нэгэнтэй өөрсдийгөө харьцуулж байхад тэр хүн өөрий-гөө өөр хүнтэй харьцуулж байна. Гэвч бодит байдал дээр би яг одоо тэгж гэрэлтэхгүй байгаа бөгөөд яг одоо ямар харагдаж байгаа зур-гаа тавьж ч зүрхлэхгүй байна. Би ихэвчлэн баасан, ням гарагт л гоё хувцаслаж, 'дажгүй' харагддаг" гэж хариулсан юм.

Би олон нийтийн мэдээллийн хэрэгслээр амьдралаа хуваал-цаж эхлээд хэдэн жилийн нүүр үзжээ. Ихэвчлэн би Есүс Христийн Сүмийн гишүүдийн "бодит амьд-рал" ямар байдгийг харуулахыг зорьдог. Ингэхдээ олон нийтийн мэдээллийн хэрэгслийн ач тус, эрсдэлийн талаар бодоход хүргэсэн зүйлстэй тулгарч байсан.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүх зүйлийг үзүүлдэггүй

Энэ нь хэн нэгэн надад иймэрхүү асуулт тавьж байсан анхны тохиолдол байгаагүй. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хүмүүсийн амьдралын маш өчүүхэн хэсгийг л харуулдаг. Миний хувьд бид бодит байдлаа харуулахыг хичээдэг ч бүхнийг харуулах боломжгүй. Бид бас өөрсдийгөө бусадтай харьцуулж эсвэл өөрийн үнэ цэнийг нэг сайхан зураг дээр үндэс-лэн тогтоож болохгүй. Харьцуулах нь, ялангуяа олон нийтийн мэдээллийн хэрэгсэл дээрхтэй харьцуулах нь Бурханаас өгөгдсөн давуу талаа таньж мэдэхийг бидний хувьд улам бүр хүндрэлтэй болгодог.

Хожмын үеийн гэгээнтнүүдийн хувьд бид Есүс Христтэй адил болохыг чадлаараа хичээдэг. Гэвч үнэн хэрэгтээ бидний дунд төгс хүн байхгүй. Олон ний-тийн мэдээллийн хэрэгслээр бид өөрсдийгөө болон бусдыг буруу зөрүү шүүхгүй байхад анхаарвал зохино. Хэн нэгний амьдралыг төгс гэж бодохдоо тэдэнд тулгарч буй хувийн асуудлыг харах боломжгүй гэдгээ бид санах хэрэгтэй. Бид хүмүүсийн сайтар шүүн байж бусадтай хуваалцахаар сонгосон зүйлийнх нь ард амьдрал нь ямар байгааг үнэндээ мэдэхгүй.

Гэр бүлийн бодит зураг

Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр танд харагд-даг гэр бүлийн зургийн ард маш олон зүйл болж өрнөдөг. Зарим нь эдгээр зургийг хараад, өөрсдөөсөө

“Манай гэр бүлийн зураг яагаад сайхан гардаггүй юм бэ?” гэж асуудаг байж болох юм. Гэхдээ тэр “төгс” зургийг авахын тулд ямар хүчин чармайлт гаргадгийг бид мэдэхгүй.

Жишээ нь, бид сүмийн дараа гэр бүлийн зураг авахуулах гэж үзсэн. Хоёр жаахан хүүхэдтэй байхад хэцүү ч би эдгээр цаг мөчөө зурган дээр буулгаж, дараа нь хүүхдүүдээ хэчнээн том болсныг эргэж харах дуртай.

Хүүхдүүдээ суулган зураг авахуулах гэж хичээхдээ, тэврүүлэхийг хүсэн уйлж байгаа хоёр настай Алвин хүүтэйгээ ярилцах хэрэг гарав. Би доош тонгойн, нулимсыг нь арчсаныхаа дараа, босоод өмссөн хувцсаа (тэр өглөө албаар хослуулсан) харуулъя гэж түүнээс гуйсан юм. Гурван настай охин Аврил маань бас л зогсмооргүй байсан тул тэврээч хэмээн аавaa шалж байв. Тэд үнэхээр зураг авхуулахыг хүсэхгүй байв.

Зураг авалт амжилтгүй болж, бид ч бууж өгч билээ. Харин гэртээ ирээд, үүнээс арай илүү зүйлийг би олсон. Ах маань (зураг авч байсан) энэ бүх эмх замбараагүй байдлын үеэр зураг дарсан байв. Нөхөр бид хоёр хоёулаа зурган дээр хүүхдүүдээ тайвшруулж байлаа. Энэ зурганд бидний хувцсыг харуулаагүй, харин жинхэнэ энхрий бодит мөчийг буулгасан байв. Надад тэдгээр зураг үнэхээр таалагдсан.

Би энэ зургаа олон нийтийн мэдээллийн хэрэгсэл дээр тавихдаа “Гэр бүлийн бодит зураг” гэж нэрлэсэн юм. Энэ зураг ийм олон хүнд хүрнэ гэж би бодоогүй ч бүх зүйл үргэлж төгс харагдах шаардлагагүй юм байна гэдгийг надад ойлгуулсан. Урсгалаараа явж, байгаагаараа байх нь зүгээр. Гэхдээ би үүнээс илүү том сургамж авсан буюу энэ нь бид хэн нэгнийг төгс гэж бодох үедээ зүгээр л бүх нарийн ширийн зүйлийг нь мэдээгүй байдаг гэдгийг заасан.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр өөрийн бодит байдлыг бүү далдал

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бол илүү сайн сайхны төлөө ашиглаж болох хүчирхэг зэмсэг юм. Гэвч бид олон нийтийн мэдээллийн хэрэгслээр харж буй зүйлдээ сэтгэлээр унаж эсвэл өөрсдийгөө тэдгээртэй харьцуулахгүй байхыг хичээх хэрэгтэй. Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Гари И.Стивэнсон “Бид бодит байдлыг хэтрүүлсэн зургийг мөн бусдынхтай харьцуулснаас болж урам хугарахад дэндүү их нөлөөлдөг зургийг харахдаа илүү бодитой хандаж, хошигносон байдлаар хүлээн авч, урам хугарах мэдрэмжийг арай цөөн удаа мэдэрч сурах байх гэж найдаж байна” [1] хэмээн хэлсэн.

Бурханы хүүхдүүдийн хувьд бид бурханлаг шинж чанараа санаж байвал сэтгэл өвтгөм харьцуулалтад эсвэл хувийн шүүлтэд орон зай үлдэхгүй гэдгийг би мэднэ. Хэрэв бид бидний чадавхыг үгүйсгэдэг эдгээр харьцуулалтыг сонсохоо боливол зурган дээрх төгс мэт бүх постод санаагаа чилээлгүй, илүү бүрэн дүүрэн амьдрах боломжтой болно. ■

Барбара Родригэз 25 настай бөгөөд Венесуэлын Ансоатегид төрж, тэнд нөхөртэйгөө танилцжээ. Одоо тэд Перугийн Лимад амьдардаг. Барбара олон нийтийн сүлжээн дээр өөдрөг агуулгатай зүйл тавихыг хичээдэг.

ЭХ СУРВАЛЖ

1. Гари И.Стивэнсон, “Сүнслэг хиртэлт,” *2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган*, 33.

ИЛҮҮ ОЛОН
ХУУДАС,
ИЛҮҮ ОЛОН
ТҮҮХ,

ИЛҮҮ ОЛОН ЗҮЙЛИЙГ ТА

2021 оны 1-р сард дэлхийн өнцөг булан бүрд байгаа өсвөр насныхныг нэгтгэж, холбох зорилготой өсвөр үеийнхэнд зориулсан "Өсвөр үеийнхний бат бөх байдлын төлөө" шинэ сэтгүүл гарч эхэлнэ.

ТА ДАРААХ ЗҮЙЛСИЙГ ХҮЛЭЭЖ АВАХ БОЛНО. ҮҮНД:

- Сүмийн удирдагчдын сүнслэг захиасууд
- Өсвөр үеийнхний бичсэн илүү олон түүх

НАРТ ЗОРИУЛАВ!

- Семинар дээр суралцаж байгаа зүйлсэд болон *Ирээд, Намайг дага* хөтөлбөрт зориулсан туслах материал
- Өлгөж байрлуулах эсвэл онлайнаар хуваалцах шинэ зурагт хуудаснууд
- Сайн мэдээтэй холбоотой асуултын тань хариулт

Есүс Христийн сайн мэдээг судлахын зэрэгцээ бусад хүн сайн мэдээний дагуу хэрхэн зоригтой амьдарч байгаа талаар уншиж, үргэлжлүүлэн сүнслэгээр өдөөгдөж, урам зориг ав.

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

ЭНЭ ХЭСЭГТ

52 **Христийн мэндэлсний баярын уламжлалын адислал**
Изабэл Тоа

54 **Чи ямар жагсаалт гаргасан бэ?**
Аннэлиз Гардинэр ба Сэм Лофгран

56 **Асуулт, хариулт: Найзуудтайгаа ойр байх уу? Гэрэлтдэг чулуунууд уу?**

58 **Тэр бол Гэрэл**
Лаура Фачс

60 **Моронайгаас авах амьдралын гурван сургамж**
Дэвид Диксон, Чокэлл Вордлэй Хэрбэрт

64 **Сүүлчийн үг: Христээр төгөлдөржих**
Ахлагч Гэррит В.Гонг

65 **Мормоны Номд гардаг хүмүүс: Мормон, Моронай хоёр**

ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРЫН УЛАМЖЛАЛЫН адислал

Христийн мэндэлсний баярын өдрүүдийг шинэ байрандаа өнгөрүүлэхэд онцгой зүйл байгаагүй ч санваарын нэгэн адислал бүх зүйлийг өөрчилсөн юм.

Изабэл Тоа

Би 14 настайдаа Христийн мэндэлсний баярыг хамгийн анх удаа цасгүй өнгөрүүлж билээ. Гэр бүл маань дөнгөж Ютагийн уулс дундаас АНУ-ын Техаст нүүж ирээд байв. Миний хувьд Техас дэндүү хавтгай, халуун газар санагдсан. Шинэ сургууль дээр найз нөхөд байхгүй, ялангуяа газар дээр ямар ч цасгүй байхад Христийн мэндэлсний баярын уур амьсгалыг мэдрэх хэцүү байв. Надад хаана ч таарч тохирохгүй байгаа мэт санагдаж байсан тул би үе үе ганцаардаж, гуниглаж байв.

Гунигтай байсан ч Христийн мэндэлсний баяр болоход долоохон хоног үлдээд байсан ба гэр бүлийн маань Христийн мэндэлсний баярын уламжлал сэтгэлийг минь сэргээж магад гэж би найдаж байлаа. Манай гэр бүлийн олон жил хийсээр ирсэн хөгжилтэй үйл ажиллагаануудад би их баяртай байдаг байв. Уламжлал манай гэр бүл Христийн мэндэлсний баяраа хэрхэн тэмдэглэж ирсэн явдлын томоохон хэсэг байсан тул би юунд ч санаа зовох хэрэггүй гэж бодож байв. Тэдгээрийг яагаад уламжлал гэж нэрлэсэн нь учиртай байсан тул үргэлжлүүлэн хийнэ гэдгийг би мэдэж байв.

ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРЫН УУР АМЬСГАЛЫГ АВЧ ҮЛДЭХ

Христийн мэндэлсний баярын өмнөх өдөр хоног удаан өнгөрч байлаа. Бид гэр бүлээрээ хамтдаа тэмдэглэх ямар ч зүйл хийхгүй байсанд би нэлээд сэтгэл дундуур байв. Христийн мэндэлсний баярын өмнөх өдөр ч болж, ариун нандин уламжлалуудаа шинэ гэртээ ч гэсэн авч үлдэнэ гэдгийг надад харуулах ямар нэгэн зүйл болохыг би өдөржин хүлээлээ. Би эдгээр үнэ цэнт уламжлалаа өөрөө эхлүүлж болох байсан ч тэгэхийг хүссэнгүй. Нэг талаас би Христийн мэндэлсний баярын уур амьсгал хэвээр байгааг батлах ямар нэгэн зүйлийг хүлээж байлаа.

Өдөр өнгөрч, нар хэвийхэд би илүү их бухимдаж эхлэв. Гэрийнхнийгээ оройн залбирал хийхээр цугларах үед нүдэнд минь нулимс хурлаа. Гэрт хүмүүс амьдарч байсан ч бүхэлдээ л нэг хүйтэн, хөндий оргиж байв. Гэнэт аав нэг асуулт тавьж, нам гүм байдлыг эвдлээ.

“Санваарын адислал авах хүн байна уу?” гэж тэр асуув.

Зүрх минь түр цохилохоо болих шиг санагдлаа. Би Христийн мэндэлсний баярын гэрлээ асааж, баярын жигнэмэг хийх зэрэгт хэт их санаа зовж байсан болохоор Христийн мэндэлсний баярын өмнөх орой хийж дадсан нэгэн онцгой уламжлалаа буюу бүгдээрээ авдаг санваарын адислалын талаар мартсан байв. Ааваасаа адислал авах нь өмнө нь намайг үргэлж тайтгаруулдаг байсан ч гэрийн маань бүх хүн адислал авах дуртай байгаагүй. Заримдаа ээж, ах дүү нар маань адислал авах хэрэггүй гэж бодож байна гэж хэлдэг байсан. Надаас бусад нь авахгүй гэвэл сэтгэлээр унах тул би тэгтлээ найдвар тавихыг хүссэнгүй.

Харин энэ удаа арай өөр байлаа. Ээж босож, аавын авчирсан сандал дээр суув.

“Би авья” гэж тэр аяархан хэллээ.

Бид маш их гайхсан ч аав огт эргэлзсэнгүй. Аав ээжийн толгой дээр гараа тавиад, ярьж эхэллээ. Аав маань ээжийн сэтгэл санаа, хувийн асуудлыг үнэхээр сайн мэдэрч байгааг би мэдэрсэн. Тэр түүнд энэ өөрчлөлт шилжилтийн үеэр даван туулахад туслах тайтгарал, амар амгаланг өгөх үгсийг хэлэв.

Гэнэт хэн нэгэн миний цээжин дотор шүдэнз асаасан мэт шатахыг би мэдэрлээ. Цээжинд шатах мэт энэ мэдрэмж урьд өмнө нь мэдэрдэг байсан Сүнсний мэдрэмжтэй маань адилхан байгаагүй ч энэ нь Ариун Сүнс байсныг би мэдэж байв. Энэ нь миний санваарын адислал байгаагүй ч Тэнгэрлэг Эцэг маань надтай шууд ярьж байгаа мэт санагдаж билээ!

Аавыг “амен” гэж зөөлөн хэлэхэд, би нулимс дүүрэн нүдээ нээн, гэрийнхэн маань бүгд уйлж байгааг харсан юм. Сүнс бидэнд хандан, бүх зүйл сайн сайхан болно хэмээн хайраар дүүрэн намуун зөөлөн арга замаар ярихыг бид бүгдээрээ сонссон байлаа. Аав, ээж хоёрыг тэврэлдэхэд урт хугацаанд миний

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ТРЭЙСИ ВОКЭР

толгой дээр хурсан бороонуудын үүл эцэстээ сарнин алга болох шиг санагдсан.

Би ч бусад маань ч бүгд адислал авсан юм. Миний адислал дээр Их Эзэн намайг үргэлж харж ханддаг бөгөөд намайг жаргалтай байгаасай гэж хүсдэгийг батлав. Энэ нь надад Техаст ирснээс хойш мэдрээгүй амар амгалан, халуун дулаан мэдрэмжийг өгсөн.

САНВААРЫН ХҮЧ БОЛ БОДИТ

Бид тэр жил бүх уламжлалаа дагаагүй ч аавын маань санваарын адислалаар дамжуулан Бурханы хүч хэрхэн урсан орж ирэхийг гэрчлэх ямар санагдсаныг огтхон ч мартаагүй. Энэ нь хэрхэн миний уйтгар гунигийг амар амгалан, баяр баясгалангаар сольсныг би үргэлж санах болно. Би бас санваарын хүчийн талаар үнэ цэнтэй сургамж авсан. Эргэн тойронд тань бүх зүйл буруугаар эргэж байгаа мэт санагдах үед санваарын адислал Их Эзэн таны амьдралыг харж хандан, таныг хайрладгийг танд сануулах болно. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ЧИ ЯМАР **ЖАГСААЛТ** ГАРГАСАН БЭ?

Хүсэж байгаа зүйлсээ жагсааж бичихээ болиод, хэрэгтэй зүйлсээ авч эхэл.

Аннэлиз Гардинэр ба Сэм Лофгран
Сүмийн сэтгүүлүүд

Энэ жилийн Христийн мэндэлсний баяраар та юуг үнэхээр хүсэж байна вэ? Бэлгээс гадна танд үнэхээр *хэрэгтэй* байгаа зүйлсийн тухай бид ярьж байна.

Хэрэгцээ гэдэг нь амьд үлдэхийн тулд танд байх ёстой зүйлс юм. Христийн мэндэлсний баяраар бид бие махбодын хүсэлдээ анхаарлаа хандуулах нь амархан ч сүнслэг хэрэгцээгээ яах вэ?

ХЭРЭГТЭЙ БЭЛГҮҮД

Бидний сүнсэнд байнгын хэрэгцээ байдаг. Судраас суралцах, залбирах гэх мэт бэлэг нь эдгээр хэрэгцээгээ нөхөхөд тусалдаг ч нөхцөл байдлаас шалтгаалан сүнсэнд маань өөр бусад хэрэгцээ гарч ирдгийг бид мэднэ. Сүнсний нь хэрэгцээнд өөр ямар ямар "бэлэг" хэрэгтэй болохыг олж нээсэн, дэлхийн өнцөг булан бүрд байх өсвөр үеийнхний түүхийг бид цуглуулсан юм. Та уншиж байхдаа, сүнсэнд тань ямар бэлэг хэрэгтэй байж болох талаар тунгаан бодоорой.

Семинар бол бэлэг

Чилийн 16 настай Хуан Р. семинар өөрт нь хэрэгтэй байсан тэр зүйл болохыг мэдэж авчээ. Би үнэнийг семинар дээр сурдаг ба Сүнс надад мэргэн ухаан өгдөг. Би Сүнсийг мэдрэх болгондоо Бурханы тэр мөчид намайг хаана байгаасай гэж хүссэн, тэр газар нь байгаагаа мэддэг. Би энэ мэдрэмжийг семинар дээр авдаг тул тэнд байх нь миний хувьд чухал гэдгийг мэддэг юм. Семинарт явбал би өөрт байгаа асуулт, эргэлзээнийхээ хариултыг авна гэдгийг үргэлж мэддэг.

Найз нөхөд бол бэлэг

15 настай АНУ-ын Айдоходамьдардаг Роэта М. нь Сүмийг сонирхож байхдаа сайн найзууд хэрэгтэй байдгийг олж мэдсэн байна. "Намайг ариун ёслол, хичээл, Залуу эмэгтэйчүүдийн ангид явж эхлэхэд олон найрсаг хүмүүс, хайр халамжтай хамт олон тэр даруй угтан авсан юм. Намайг бүх үйл ажиллагаанд хамруулж, шинэ найзууд маань Бурханы төлөвлөгөөг дагахад урамшуулж байв. Тэд сүнслэг зорилго тавьж, зорилгодоо хүрэхэд минь тусалсан." Роэта номлогчдоос их зүйлийг суралцаж, сүмийн найзуудтайгаа холбогдсоноор баптисм хүртэх шийдвэр гаргажээ. "Би ийм сайн хүмүүсийг олсондоо маш их талархдаг ба Сүмд ийм таатай байдлаар шилжин орох боломжоор адислагдсан" хэмээн тэр хэлэв.

Үйлчлэл бол бэлэг

Техасын 16 настай Жули С. өөрт нь дуудлага хэрэгтэйг ойлгожээ. "Би саяхан тойргийн дууны удирдаачаар дуудагдсан бөгөөд энэ дуудлагыг авснаар сүмдээ цагтаа очих хэрэгтэй болсон. Цагтаа очих нь манай гэр бүлийн хувьд том асуудал байсан ч би дуу хөгжимд дуртай тул энэ дуудлага надад баяр баясгалан авчрахын зэрэгцээ манай гэр бүлийг ням гарагт илүү зохион байгуулалттай, цагаа баримталдаг болгосон."

Сайн мэдээ бол бэлэг

Туркт амьдардаг 19 настай Сэм Д. амьдралд нь дутагдаж байсан зүйл Сүм байсныг ойлгожээ. "Би 16-тайдаа баптисм хүртсэн ба үүний дараа л жинхэнэ утгаараа амьдарч эхэлсэн. Бүх зүйл илүү тодорхой болж, би амьдрах зорилготой болсон юм.

ЗӨВЛӨМЖҮҮД

Найз хэрэгтэй байна уу? Найз хэрэгтэй хүмүүсийг олоод, тэдэнтэй найзал. Тойрог, сургуулийнхаа бусад өсвөр үеийнхэнд тусламжийн гараа сунга.

Үүрэг хариуцлага хэрэгтэй байна уу? Бишоптойгоо холбогдож, дуудлага авмаар байгаагаа хэл. Чи бас орон нутагтаа үйлчлэх арга замуудыг эрэлхийлж болно.

Сүнслэг тэжээл хэрэгтэй байна уу? Семинарт яв. Судруудаа унш. Чуулганы үгсийг сонс.

ТАНД ӨӨР ЯМАР БЭЛЭГ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Эдгээр өсвөр үеийнхэн гэрчлэлээ хөгжүүлж, илүү аз жаргалтай болж, Бурханд улам их ойртоход өөрсдөд нь хэрэгтэй зүйлсийг олсон. Тэдний туршлагыг уншсаны дараа танд сүнсний ямар хэрэгцээ байгааг та олж харсан бэ? Тэдгээрийг мартахгүйн тулд жагсаалт гарга.

ӨГӨХ БА ХҮЛЭЭН АВАХ

Одоо Сүнсний хэрэгцээгээ тодорхойлсон бол тэдгээрийг хэрхэн хангах вэ?

Тэрхүү хэрэгцээ шаардлагаа хангахын тулд эхлээд зорилго тавь. Зорилго тавих нь шинэ зүйлсийг гүйцэлдүүлэх гайхалтай арга зам бөгөөд Хүүхэд, өсвөр үеийнхний хөтөлбөр анхны алхмаа хийхэд тань тусална.

Таны өөрийн гэр бүл эсвэл тойрог, салбарын тань гэр бүл ч бай, аль аль нь таны гэр бүлийн хэрэгцээг хангахад туслах өөр нэгэн гайхалтай газар байж болох юм. Моронайн үед ч гэсэн Сүмийн цуглаан хийж байсан гол шалтгаан нь "өөр хоорондоо бодгалиудынхаа аз жаргалын талаар ярих" (Моронай 6:5) явдал байсан.

Мэдээж, Тэнгэрлэг Эцэг сүнслэг хэрэгцээгээ хангаж, Түүнд итгэх итгэлээ нэмэгдүүлэхэд тань туслахыг хүсдэг. Хэрэв та Түүнд хандан залбирах юм бол Тэрээр хэрэгцээ, зорилгоо тодорхойлоход тань тусална.

Энэ Христийн мэндэлсний баяраар сүнслэг хэрэгцээний тань жагсаалтад юу байгааг хэн нэгэн таахыг хүлээлгүй, зорилго тавьж, тэрхүү хэрэгтэй бэлгүүдээ өөртөө өгөөрэй. Гэвч зорилгодоо хүрэхийн тулд хэн нэгнээр туслуулахаас бүү эргэлз. Энэхүү улирал бол өгөөмөр байх улирал тул бусдын сүнслэг хэрэгцээг хангахад туслах арга замыг хайж ол.

Дэлхийд Роэта, Сэм нар шиг хүмүүс байгааг бүү март. Эргэн тойрондох хүмүүстэйгээ сайн мэдээний захиасыг хуваалцахгүй бол тэд аз жаргалтай, зорилготой болохын тулд юу хэрэгтэй, юу дутагдаж байгааг хэзээ ч олж мэдэлгүй өнгөрч болох юм. Энэ бол Христийн мэндэлсний баяраар хэн нэгний авч болох хамгийн сайхан бэлэг мөн! ■



Зарим найз маань сайн нөлөө үзүүлдэггүй. Бид найз хэвээр үлдэж болох уу?

“Дэлхийн бусад хүнд жишиг нь бол! Өөр гэдгээ хүлээн зөвшөөр! Өсвөр үеийнхний бат бөх байдлын төлөө *товхимол* та нарын *жишиг байх ёстой. Энэ нь Их Эзэн Өөрийн өсвөр үеийнхнээс баримтлахыг шаарддаг жишиг юм.”*

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон, “Израилын найдвар” (Өсвөр үеийнхний дэлхий даярх онцгой цугларалт, 2018 оны 6-р сарын 3), HopeofIsrael.ChurchofJesusChrist.org.



Сайн сайхан зүйлсийг хуваалцах

Хэрэв тэд миний найзууд юм бол тэдэнд илүү сайн болж, сайн мэдээг болон үүний дагуу амьдарснаар хүлээн авсан бүх адислалынхаа талаар тэдэнтэй хуваалцах нь миний үүрэг юм. Хэрэв тэд энэ бүх сайн сайхан зүйлийг сонирхохгүй бол би найзуудаасаа бага багаар холдож эхлэх байх. Хэцүү ч гэлээ, заримдаа энэ нь хийж болох хамгийн сайн зүйл байж болох юм.

Матиус Т., 16 настай, Бразил, Минас Жерайс

Юунаас ч айлгүй ярь

Найзууд маань намайг Сүмд явдгийг мэднэ. Бид юуг хийх нь зөв, юуг хийх нь буруу болох талаар ярилцаж байсан. Одоо найз маань надтай хамт байхдаа үлгэр жишээч байдаг бөгөөд энэ нь намайг баярлуулдаг. Энэ явдал надад айж эмээлгүй ярих хэрэгтэй гэдгийг заасан.

Диего Р., 16 настай, Мексик, Мехико

Илүү сайн нөлөөлөгч бай

Сайн нөлөө үзүүлдэггүй найзууд надад байдаг ч энэ нь би тэдэнтэй ярьдаггүй гэсэн үг биш юм. Би тэднийг хүндэлж, тэдэнтэй эелдэг харьцдаг. Би тэднийг шүүж, шүүмжилдэггүй. Найзууд маань бидний бодох, үйлдэх байдалд нөлөөлөхийн зэрэгцээ бидний хэн болохыг хүртэл шийддэг гэдгийг би мэднэ. Би боломж гарах болгонд тэдэнтэй сайн мэдээг хуваалцаж, Сүмийн үйл ажиллагаанд урьдаг.

Сайрэт В., 18 настай, Мексик, Морелос

Хариултын хэмжээг тааруулж тохируулах эсвэл лавлан тодруулахын тулд хянан засварлах магадлалтай. Хэвлэгдсэн хариулт нь туслах, ойлголт өгөх зорилготой бөгөөд Сүмийн сургаалын албан ёсны мэдэгдэл биш юм.



Бурханыг бүхний түрүүнд тавь

Найзууд тань сайн үлгэр жишээг тань хүлээж авахгүй бол сэтгэлээр бүү унаарай. Амин хувиа хичээх, өөрийгөө бодох хоёрын хооронд нарийн зааг бий. Та хэн нэгний төлөө өөрийн жишгийг доошлуулж эсвэл итгэл үнэмшлээ орхиж болохгүй. Бид хэн нэгний таалллыг бус, зөвхөн Тэнгэрлэг Эцэгийн таалллыг олохын төлөө амьдардаг. Удирдамж заавар авахын төлөө залбирч мөн судруудыг судалж, Ариун Сүнсний өдөөлтийг сонсохын зэрэгцээ дэлхийн зүйлсээс болж өөрсдийн нарийн бөгөөд шулуун замаас гарахгүй байх нь юу юунаас илүү чухал.

Райли И., 15 настай, Филиппин, Манила

Ариун газруудад зогс

Хэдий зөвхөн бид байсан ч гэсэн ариун газруудад зогсох хэрэгтэй гэдгийг би Сүмийн удирдагчдаасаа сурч авсан. Жишгүүдийн дагуу үргэлжлүүлэн амьдрах хэвшлийг амьдралдаа болоод зүрх сэтгэлдээ суулгаж өг. Тэднийг хичээлд юм уу ариун ёслолын цуглаанд урихыг хичээгээрэй. Та нар явж буй газруудаа сайн мэдээний гэрлийг хаа сайгүй хүргэж чадна! Юуны өмнө, тэдний хүн нэг бүрд Аврагчийн хайрыг харуулаарай.

Алланис О., 18 настай, Португал, Сэтүбо

ЗАГВАР ӨМСӨГЧДИЙН ОРОЛЦООТОЙ АВСАН ГЭРЭЛ ЗУРГИЙГ GETTY IMAGES-ЭЭС АВАВ

Та юу гэж бодож байна вэ?

Сүнслэг өдөөлтийг дагах зоригийг би хэрхэн олж авах вэ?

Хэрэв хүсвэл хариултаа өндөр нягтралтай зургийн хамт liahona.ChurchofJesusChrist.org хаягаар (“Submit an Article or Feedback” дээр дар) 2021 оны 1-р сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Жаредын ах Их Эзэнээс чулууг гэрэлтүүлэхийг хүссэн нь сонин байсан бус уу?

Юуны түрүүнд Жаредын ах “хүслийнхээ дагуу хүлээн авч болохын тулд” (Ифер 3:2) итгэлтэй залбирсан. Энэ нь тэрээр “Бурханы хувьд бүх зүйл боломжтой” (Лук 1:37) гэдэгт итгэж байсныг харуулдаг. Их Эзэн түүний итгэлтэй хүсэлтийг биелүүлсэн.

Хоёрдугаарт, Жаредын ах Ноагийн хөвөгч авдрын өмнөх жишээг дагасан байж болох юм. Их Эзэн Жаредын ахад хөлөгтөө гал, цонхны алиныг ч байлгаж болохгүй хэмээн хэлсэн ч (Ифер 2:23–24-ийг үзнэ үү) Библи дээр Ноагийн хөвөгч авдар “гэгээвчтэй” (Эхлэл 6:16) байсан тухай өгүүлсэн байдаг. Гэхдээ “гэгээвч” гэж орчуулагдаж буй үг нь үнэндээ цонх биш ч байж болох юм. Еврейн шашны зарим багш болон бусад эрдэмтэн хэлгийн “гэгээвч” нь үнэндээ гэгээвчийг гэрэлтүүлсэн үнэт чулуу байсан байж болох юм хэмээн хэлсэн байдаг (Эхлэл 6:16, зүүлт тайлбар *а*). Ноагийн хөвөгч авдрын тухай түүхийг Жаредын ах мэддэг байсан байх. (Жаредчуудын цэдэгт Бүтээлтээс эхлэн Бабелын цамхаг хүртэлх түүх багтсан байдаг [Ифер 1:3–4-ийг үзнэ үү].) Тиймээс Жаредын ахын хүсэлт тийм ч ер бусын хүсэлт байгаагүй байж болох юм.

Тэр бол ГЭРЭЛ

Гэрээсээ олон мянган бээрийн цаана алс хол байхдаа би олон тэрбум бээрийн тэртээх гэрлийн туяанаас нэгэн сургамж авч билээ.

Лаура Фачс

Хачирхалтай сонсогдож байж болох ч гэр бүлийн асуудал, зар сурталчилгаа гэх мэт анхаарал сарниулах зүйлсгүйгээр хэдэн зуу, бүр хэдэн мянган бээрийн цаана номлолд байхад миний сэтгэл Христийн мэндэлсний баяраар үргэлж догдолдог байсансан. Христийн мэндэлсний баяр бол Христийн тухай баяр бөгөөд бусдыг Түүнд ирэхэд туслахаас өөрөөр хэрхэн сайхан тэмдэглэх билээ?

12-р сарын нэгэн орой хамтрагч бид хоёр Филиппинийн Лаоаг хотын захад байдаг Ла Паз гэгч гайхамшигт газарт номлогчийн өдрийн ажлыг дуусгаад, гэртээ харьж байв. Би гурван дугуйт дотор 183 см өндөр хамтрагчтайгаа шахцалдан сууж байсан ба амьдралаа маш ихээр таашаан хайрлаж байв. Сэрүүн агаар биднийг илбэн, гэрт болдог цас бударсан Христийн мэндэлсний баярыг бага зэрэг сануулсан ч миний дассан 12-р сарын хүйтэнтэй харьцуулахаар хүйтэн биш байв.

Хээр талаар явж байхдаа харц минь тэнгэр өөд чиглэлээ. Тэртээд хотын гэрэл, чимээ шуугианаас хол хэдэн мянган од харагдаж байв. Хотын төв рүү дөхөх тусам харагдах одод цөөрөн цөөрсөөр, зөвхөн хамгийн тод од гэрэлтэн харагдаж байлаа.

Би оддоос гарах гэрэл, Есүс Христийн талаар бодов. Би Христийн мэндэлсэн тухай болон Түүний талаар зарласан, “өглөөний гэрэлт од” (Илчлэл 22:16) болох одны тухай бодсон юм. Тэр бол хамгийн тод од, бид бүгдийн хувьд гялалзан гэрэлтэх үлгэр жишээ юм. Гэсэн хэдий ч гурван дугуйт дээр суунгаа харсан ододтой адил Түүнийг ч гэсэн хурц гэрлийн бохирдол

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ГАБРИЭЛ КРАКОЛИЧИ

халхалж болдог. Анхаарал сарниулах зүйлс болон хуурамч гэрэлтүүлэг хэдий чинээ их байна, байгалийн гэрэл төдий чинээ бүдгэрдэг. Филиппинийн хөдөө нутагт зарим од хотын төвөөс харагддаг бол Манила зэрэг том хотуудад та ганц ч одыг шөнийн цагаар олж харж чадахгүй. Зар сурталчилгаа, бизнес, байрны гэрлүүд бүгд алс хол байх оддын гэрлийг хаадаг.

Өөрсдийгөө анхаарал сарниулах зүйлс, хуурамч гэрлээр хүрээлүүлэх үед ийм зүйл бас болдог ба Христийн гэрлийг харахад улам бүр хэцүү болдог.

Энэ нь Христийн мэндэлсний баяраар бүр ч элбэг тохиолддог. Баярын өдрүүдэд хуанли хэт дүүрч, Манила хот оргил ачааллын цагаар оволзож байдагтай адил өөрсдийгөө завгүй байлгах амархан. Олох ёстой бэлэг, төлөвлөх ёстой үдэшлэг, бичих ёстой ил захидал, үзэж харах ёстой тоолж баршгүй олон тоглолт, арга хэмжээ гарч ирдэг. Дээшээ ч харах цаг зав гарахгүй байна гэж бодохдоо бид Христийн гэрэл бидний амьдралд ямар их бүдгэрснийг ухаарахгүй өнгөрч байж болох юм.

Бид гэр орон, моддоо гэрэлтүүлэхдээ Христийн гэрлийг зүрх сэтгэлдээ гэрэлтүүлэхээ мартаж болохгүй. Бид баяр наадмаа түр зуур хойш тавьж, юуг тэмдэглэж байгаагаа санах хэрэгтэй. Христийн мэндэлсний баяр бол Христийн тухай баяр юм. Тэр бол гэрэл бөгөөд хэрэв бид анхаарал сарниулах зүйлсээ багасгаж, дээшээ харвал Түүнийг дэлхийн бүх хүнд харагдахаар үргэлж нэгэн хэвийн, гэрэлтсээр байгааг харж чадна. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

МОРОНАЙГААС АВАХ АМЬДРАЛЫН ГУРВАН СУРГАМЖ

Дэвид Диксон, Чокэлл Вордлэй Хэрбэрт
Сүмийн сэтгүүлүүд

Мормоны Ном нь эхнээсээ дуусах хүртлээ хүчирхэг мөнхийн үнэн, гайхалтай амлалт, сургамж, Есүс Христэд итгэх итгэлийн урамтай жишээнүүдээр дүүрэн байдаг. Хамгийн сайхан нь энэ бүхэн үнэн!

Гэхдээ бид номын төгсгөлд ирж, Моронайн бүлгүүд дээр очих үед тэрээр хамгийн хүчирхэг үнэнүүд, амьдралыг өөрчлөх сургамжуудыг өгсөн байдаг! Моронай Мормоны Номыг өөрийнхөө гайхалтай гэрчлэл, Христэд ирж, үнэнийг өөрийн биеэр мэдэхийг эрэлхийлэх хувийн урилгаараа төгсгөдөг. Гэхдээ энэхүү гайхалтай номын сүүлийн бүлгүүд дэх хүчирхэг мэдэгдлийн дундаас авч болох, амьдралыг өөрчлөх гурван нэмэлт сургамжийг оруулав.

1. Барианаас цаашхыг хар

Хэцүү ч гэсэн үр шимтэй төслийн ард гарахад сэтгэл ханамж авдаг. Тухайлбал: эвлүүлдэг тоглоомын хамгийн сүүлийнхийг тавих эсвэл сургууль дээрээ хамгийн шилдэг төслийг хийх гэх мэт.

Моронай Ифер номон дээр өгүүлсэн жаредчуудын уналтыг цэдэглэснийхээ дараа, Мормоны Номд оруулах хувь нэмрээ ийнхүү дуусгаж байна гэж бодсон. Тэр номоо "Эдүгээ би, Моронай, Жаредын хүмүүсийн шастирыг хураангуйлахаа төгсгөл болгосныхоо дараа, би өөрийг бичнэ хэмээн бодсонгүй, гэвч би хараахан мөхөөгүй байна" (Моронай 1:1) гэж эхлүүлдэг.

Тэрээр амьд үлдсэн явдлаа таны гайхлыг бодсоноос чинь ч илүүгээр төрүүлсэн байж болох юм. Эцсийн эцэст тэр дайснуудынхаа хаа сайгүй холхисон газраар, ганцаархнаа хэрэн хэсэж байв.

Түүнд хүссэн бүхнээ хийх цаг байсан. Моронай ердөө арван бүлэгт ихийг багтааж чадсан. Түүний бичсэн үнэнүүдэд багш, санваартнуудыг томилох арга, ариун ёслолын заавар (мөн ариун ёслолын залбирлууд), Сүмийн цуглааныг хэрхэн явуулах, итгэл, найдвар, энэрлийн талаарх эцгийнх нь хүчит үг, Мормоны Номын үнэний талаарх хувийн илчлэлтийг хэрхэн хүлээн авах тухай бидэнд заасан Моронай 10:3–5 дээрх ариун нандин амлалт зэрэг нь багтдаг. Гайхалтай!

Моронай бичнэ гэж огт төлөвлөөгүй энэхүү 10 бүлэгтээ Мормоны Номын ирээдүйн уншигчдад зориулан чухал үнэнийг нэмсэн.

Бид бүгдээрээ түүний жишээнээс суралцаж болно. Дараа нь төлөвлөж байснаас тань илүү их цаг зав гарвал эсвэл та чадлынхаа хэрээр шаргуу ажилласан, аль хэзээний хийж амжуулсан гэж бодож байвал хувь нэмэр оруулж болох ямар зүйл байгааг мэдэхийн тулд залбирч, тунгаан бодох нь зүйтэй болов уу?

Эцсийн эцэст Моронайн хийсэн бүгдийн ачаар бүх дэлхий адислагдсан билээ.

2. Чулуун хайрцгийг сана

Хэрэв та дуртай жимсний модоо арынхаа цэцэрлэгт ургуулахаар шийдсэн бол зүгээр нэг тэвчээр гаргах нь хангалтгүй. Жилийн хамгийн тохиромжтой цагт хамгийн сайн ургадаг нөхцөлд тарьсан ч хичээл зүтгэл гарган байж анхныхаа үр жимснээс хүрттэл хэдэн ч жил өнгөрч магадгүй.

Гэхдээ энэ нь хийх боломжтой, тийм үү? Эцсийн эцэст хүлээж чадсан хүнд сайн зүйлс ирдэг. Та бүр хэдэн арван жил ургаж байж бүрэн ургадаг өөр мод (чидун жимсний мод адил) тарьсан байлаа ч үр хүүхэд, ач зээ тань үр шимийг нь хүртэнэ гэж бодож сэтгэл ханамж авч болно.

Гэвч та нарын дунд хэн ч Моронай шиг хүлээхгүй. Аавынх нь бүхий л амьдралын бүтээл байсан, аавыгаа нас барсны дараа хүлээн авсан ажлын үр жимсийг Моронай мөд хүртэхгүй байлаа. 10 жилд ч хүртэхээргүй байсан. Бүр мянган жилдээ ч хүртэхгүй байв. Мормон "Эдгээр зүйлс нь Иаковын угсааны үлдэгдэлд бичигдсэн бөлгөө . . . мөн тэдгээр нь *түүний зохих цагт* урагш ирж болохын тулд Их Эзэний төлөө далдлагдах ёстой" (Мормон 5:12; тодотгол нэмэгдсэн) хэмээн бичсэн.

Моронай энэ ажил яг хэзээ гарч ирэхийг мэдэхгүй байсан ч энэ нь нэлээд их хугацаа өнгөрсний дараа хэрэгжинэ гэдгийг сайн мэдэж байсан байх. Тэрээр бидний энэ цаг үеийг үзэгдлээр харж, оршин байх тодорхой нөхцөл байдлын талаар бошиглосон (Мормон 8:35-ыг үзнэ үү).

Моронай энэ бүхнийг өөрийн гэр бүл, найз нөхөд, танил хүмүүсийн сайн сайхны төлөө хийгээгүй гэдгийг бид баттай мэднэ. Бичиж буулгасан хамгийн зүрх шимшрэм үгсийн нэгэндээ Моронай "Би ганцаараа. Миний эцэг, мөн миний бүх төрөл садан тулалдаанд хөнөөгдсөн, мөн би найз нөхөдгүй мөн явах газаргүй боллоо; мөн намайг хэр удаан амьдарч болно хэмээн Их Эзэн зөвшөөрөхийг би мэдэхгүй" (Мормон 8:5) гэжээ.

Тэр гэр бүлээ *бүхэлд нь*, найз нөхдөө *бүгдийг* нь, соёл иргэншлээ *тэр чигээр* нь алдсан байлаа. Мөн тэр цэдгээ бичиж дуусаад, олон зуун жилийн турш гэрэлд гарч ирэхгүй ариун цэдгийг лацдахаар чулуун хайрцаг бүтээв.

Зөв шударга амьдрах нь дэлхийд эерэг өөрчлөлт авчирдаг. Заримдаа эдгээр усны дусал үр дүнгээ өгтөл олон үе өнгөрдөг. Гэвч Моронай Бурханы цаг хугацаанд үргэлж найдахыг бидэнд заасан. Бид зөвхөн өөрсдийн хийх ёстой зүйлийг л хийх хэрэгтэй.

3. Мөнхийн талаас хар

Юманд бодитоор хандацгаая. Зовлон бэрхшээл тохиолдож, амьдрал шударга бус, заримдаа бүх зүйл зовлонтой байх үе бий. Ялангуяа зовлонг туулаад гарлаа гэж бодох яг тэр үед зовлон солирын бороо адил дээрээс асгаран нүдэж, газарт унагаах тэр мөчид амьдрал бүр дэндүү хүнд санагддаг.

Бид сэтгэлийн хямрал, гутралд орж, хайртай нэгнээ алдаж эсвэл өөр саад бэрхшээлтэй тулгарах үед итгэл найдвараасаа зууран барих нь заримдаа хэцүү байж болох юм. Ийм хүнд үед "Үүнээс илүү доор орох аргагүй болов уу?" гэж бодох амархан.

Моронайн хувьд ийм л зүйл тохиолдсон. Амьдралынх нь сүүлийн цаг мөчид үнэхээр хүнд байсан байх. Бид урагшлах эсвэл итгэл найдвараас зууран барих шалтгаан байхгүй мэт санагдах үедээ түүний ийм их зовлон шаналал амсаж байсан ч гуйвшгүй итгэлтэй байж чадсан жишээнээс суралцаж болно.

Зарим нь Моронайг эмгэнэлтэй амьдрал туулсан хэмээдэг. Хэдийгээр тэр итгэлтэй байсан ч хайртай *бүх хүнээ* алдсан. Тэр соёл иргэншлээсээ үлдсэн хамгийн сүүлийн хүн байсан. Мормон цэдгээ дуусгаж амжилгүй амиа алдсан тул тэр эцгийнхээ цэдгийг дуусгах хэрэгтэй байв. Судрын номоо бичих үед леменчүүд Моронайг мөшгөн хөөж, тэр амиа аврахаар зугтаж байлаа.

Ийм байдал хэчнээн аймаар, найдвар алдам болохыг та төсөөлж байна уу? Хэн нэгэнд Моронайд тохиолдсонтой адил сорилт бэрхшээл тулгарсан бол итгэл алдарч, Христийг үгүйсгэж, аймшигт нөхцөл байдалдаа Тэнгэрлэг Эцэгийг буруутгахад уруу татагдах байсан биз. Гэвч Моронай тэгээгүй.

Харин ч Моронай эцсээ хүртэл тэсэж үлдсэн (Моронай 1:3-ыг үзнэ үү). Мөнхийн талаас харах чадвартай байсан нь сорилт бэрхшээлээ давж гарахад түүнд тусалсан. Тэр юу үнэн гэдгийг мөн Аврагчид болон Тэнгэрлэг Эцэгтээ итгэвэл юу ч тохиолдсон бай, амлагдсан бүх адислал нь хэзээ нэгэн өдөр биеллээ олж, Есүс Христийн хүчээр болон Түүний Цагаатгалын адислалуудаар аврагдахаа мэдэж байсан (Моронай 10-ыг үзнэ үү).

Энэ бол хүчирхэг гэрчлэл байв.

Үүнээс илүү дордоно гэж юу байхав гэж бодогдох үед бид мөнхийн талаас харах чадвартай байж, Моронайн адил итгэлээ хөгжүүлснээр тайтгарч чадна. Ийн хийж чадвал бид "[Христийн] хувьд зохистой болох аливаа зүйлийг хийж чадна" (Моронай 10:23) хэмээн бидэнд амласан. Тэнгэрлэг Эцэг бидэнтэй хамт байгааг бид мэдэх боломжтой. Түүний аз жаргалын төлөвлөгөө мөнх бус амьдралд тохиолдох эмгэнэлт явдал бүрийг даван туулах арга замыг бидэнд гаргаж өгнө гэдэгт бид итгэлтэй байж болно. Бид бас өөрсдийгөө гэрэл гэгээ, баяр баясгалан, Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний адислалуудаар хүрээлүүлж чадна.

Биднийг мөнхийн талаас харах үед *үргэлж* итгэж найдах учир шалтгаан бидэнд байх болно. Хэзээ нэгэн цагт "Үүнээс сайн зүйл гэж юу байх билээ?" гэж хэлэх өдөр ирнэ гэдэгт бид итгэлтэй байж болно. ■

Христээр төгөлдөржих

Ахлагч Гэррит В.Гонг
Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга

Шашны энгийн зан үйл биднийг Тэнгэрлэг Эцэг, Аврагч Есүс Христ хоёрт илүү ойртуулах үед сүнслэг гэрэл ба амьдрал ирдэг. Бид өдөр бүр дуулгавартай байж, сайн мэдээний дагуу тэвчээртэй, алсын хараатай, баяр хөөртэйгөөр өдөр тутмын бэрхшээл, боломжинд хандахад туслах хариулт, итгэл, хүчийг олдог.

Бид Бурханыг хайрлах мөн өөрсдөдөө болон бусдад Түүнтэй уулзахад нь туслах шинэлэг бөгөөд илүү ариун арга замыг эрэлхийлэхдээ төгс төгөлдөр байдал бидний эсвэл дэлхийн өндөр шаардлага дотор биш, харин Христ дотор байдгийг санадаг.

Есүс Христ бол "зам, үнэн, амь" (Иохан 14:6) тул Бурханы урилгууд хайр, боломжуудаар дүүрэн байдаг. Ачаагаа дийлэхгүй байгаа мэт санагдаж байгаа хүмүүст хандан Тэрээр "Над уруу ир" хэмээн урьдаг бөгөөд Өөр дээр нь ирсэн хүмүүст "Би та нарт амралтыг өгье" (Матай 11:28) хэмээн амладаг юм. "Христ рүү ирэгтүн, мөн Түүн дотор төгөлдөржигтүн, . . . Бурханыг өөрийн бүх хүч, оюун, хүчээрээ хайрла, тэгвэл Христийн дотор төгс болгох Түүний нигүүлсэл таньд хангалтай байх болно" (Моронай 10:32).

"Түүний нигүүлслээр та нар Христийн дотор төгс болгогдох болно" гэсэн энэ батламж нь, бүр аливаа зүйлс алдаа дутагдал гаргалгүй, хамгийн сайнаараа хичээн хийсэн ч мөн найдаж, хүсэн хүлээсний дагуу, зүй ёсоор болж бүтэхгүй байх үед ч Их Эзэнд итгэж найдан, урагш үргэлжлүүлэн явахад туслах тайтгарал, амар амгалан, амлалтыг бидэнд өгдөг юм.

Бид бүгд өөр өөр цаг үе, нөхцөл байдалд шаардлагад нийцэхгүй, эргэлзэж байгаагаа, магадгүй зохисгүй байгаагаа мэдэрдэг. Гэсэн ч бид Бурханаа хайрлан, хөршдөө тохинуулахаар итгэлийнхээ дагуу хүчин чармайлт гаргахдаа Түүний хайрыг мэдэрч, тэдний болон өөрсдийн амьдралд хэрэгтэй сүнсний өдөөлтийг хүлээн авах боломжтой.

Бидний Аврагч энэрэнгүй сэтгэлээр "бүх хүмүүнийг болон Бурханыг хайрлах хайраар, найдварын төгс гэрэлтэйгээр, Христ доторх тууштай байдлаар урагш тэмүүлж болно" (2 Нифай 31:20) хэмээн бидэнд амлаж, биднийг урамшуулдаг. Христийн сургаал, Аврагчийн маань Цагаатгал болон бүхий л бодгалиараа Түүний гэрээт замаар алхах нь бидэнд Түүний үнэнийг мэдэж авч, эрх чөлөөтэй байхад туслах болно (Иохан 8:32-ыг үзнэ үү).

Түүний гэрээт зам хайрт Тэнгэрлэг Эцэгийн маань хамгийн агуу бэлэг болох "Чи мөнх амьдралыг хүлээн авах болно" (2 Нифай 31:20) гэсэн амлалт руу хөтөлдөг гэдгийг би гэрчилж байна. ■

2018 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгээс авав.

Мормон, Моронай хоёр



Мормон Мормоны Номын ихэнх хэсгийг **хураангуйлж, эмхэтгэсэн** (Мормоны үгс 1:3–5-ыг үзнэ үү).



Тэр дөнгөж 15-тай байхдаа, **нифайчуудын армийн удирдагч** болсон (Мормон 2:1-ийг үзнэ үү).

Моронайн эцэг (Мормон 8:13-ыг үзнэ үү) ба Христийн шавь (3 Нифай 5:13-ыг үзнэ үү).

Моронай Мормонтой хамт **нифайчуудын армид** тулалдсан (Мормон 6:11–12-ыг үзнэ үү).

Ялтаснуудыг эмхэтгэж дуусган, **Кумора толгойд булсан** (Мормон 8:3–5, 14-ийг үзнэ үү).

Амилуулагдсан биеэрээ **Иосеф Смит дээр айлчилж ирсэн** (Иосеф Смит—Түүх 1:33-ыг үзнэ үү).

ХАЙЧИЛЖ БОЛОХ ЗУРГИЙГ ГЭЙЛ АРМСТРОНГ; ЗУРААСАН ЗУРГИЙГ КАТИ ДОКРИЛЛ

Дараа жилээс гарах Сүмийн 3 сэтгүүл! Сонирхолтой, чухал өөрчлөлтүүдийн талаар олж мэдэхийн тулд 6-р хуудсыг үзнэ үү.



6-р хуудсыг үзнэ үү.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙГ ЭЕРЭГ ОРОН ЗАЙ БОЛГОХ

42

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

МОРОНАЙГААС АВАХ АМЬДРАЛЫН СУРГАМЖУУД

60

ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛАВ

ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДОЛООН ЭНГИЙН САНАА

Н15

ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

MONGOLIAN

4 02167 27363 9

Найз

2020 оны 12-р сар

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэн гаргадаг *Лиахона* сэтгүүлийн хүүхдэд зориулсан хэсэг

Христийн мэндэлсний баяр бол бүх талаараа **ЕСҮСИЙН** тухай юм

ТЭРГҮҮН ЗӨВЛӨЛӨӨС

Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг
Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх

Есүсийг хайрлах хайрын бэлэг

Тэнгэрлэг Эцэг Өөрийн Хүү Есүс Христийг бидэнд өгсөн. Есүс бидэнд Бурхантай дахин хамт амьдрах боломж олгохын тулд бидний төлөө Өөрийн амийг өгсөн билээ. Энэ бол бүх бэлгээс хамгийн агуу нь юм. Есүс энэ бэлгийг бидэнд үнэгүй өгсөн.

Та нар бас Есүст ямар нэгэн бэлэг өгөхийг хүсэж байж болох юм. Та Түүнд ямар бэлэг өгч чадах вэ?

Үүнээс гадна өөр олон зүйлийг та Түүнд өгч чадна. Эргэн тойронд тань таны үзүүлж чадах тусламж хэрэгтэй Түүний хайртай хүмүүс бий.

Бид Есүсийн нэгэн адил харамгүй өгөх болтугай хэмээн би залбирч байна. ●

1980 оны 12-р сард Бригам Янгийн Их Сургуулийн онцгой цугларалт дээр хэлсэн "Gifts of Love" үгээс авав.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ЭММА ЖИЛЛЭТТ

Үйлчлэлийн цасан ширхэг

Бид бусдад үйлчилснээр Есүст бэлэг өгч чадна. Хэнд үйлчлэхийг тань санууллах үйлчлэлийн цасан ширхэг хийгээрэй.

1. **Дугуй хэлбэр гарган хайчил.**
2. **Дугуй хэлбэртэй цаасыг шугамын дагуу дундуур нь нугал. Дахин дундуур нь нугалаад, дараа нь дахин дундуур нь нугал.**
3. **Хүний дүрсийг хүрээлсэн тасархай зураасын дагуу хайчил. Хөл, гартай хэсгүүдийг нь хайчлахгүй.**
4. **Цаасыг дэлгээд, хүний дүрс болгон дээр өөрийн үйлчлэх хүний нэрийг бич.**



ЦАСАН ШИРХГИЙН ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ТОМАС ЧАЙЛД

Төгс мод

Сиднэй Сквайрс
Сүмийн сэтгүүлүүд
(Бодит түүхээс сэдэвлэв)

"Jesus, once of humble birth, now in glory comes to earth" (Есүс даруухан төрсөн ч дэлхийд алдар суутайгаар залран ирнэ) (Hymns, *no. 196*).

"Ээж ээ, үүнийг хар даа!" гэж Жошуа Христийн мэндэлсний баярын сүлд мод руу заав. Энэ нь төгс ногоон мөчиртэй, өндөр, нарийхан мод байлаа.

Ээж нь зогтусан, үнийнх нь шошгыг хараад, толгойгоо сэгсрэв. "Үгүй дээ, авч чадахгүй гэж бодож байна."

Жошуа санаа алдан цааш алхлаа. Зах бүхэлдээ хүнсний лангуу, Христийн мэндэлсний баярын сүлд модоор дүүрсэн байв. Сүлд модоо засах, *bûche de Noël* зэрэг амттангаа хийхэд орох зүйлсээ худалдаж авч буй гэр бүлүүдийн хөл хөдөлгөөнд зах дарагдсан байлаа. Ээж нь хоол хүнсээ цуглуулахаар Жошуаг дагуулан гарсан боловч тэр Христийн мэндэлсний баярын сүлд модноос нүд салгасангүй. Зарим мод нь өндөр, нарийхан байхад зарим нь намхан, пагдгар байв. Тэр байтугай өөртэй нь чацуу модыг хүртэл Жошуа харлаа.

Ээж нь энэ жил мөнгө муутай байгаа гэж хэлжээ. Тэд сүлд мод ч худалдаж авч чадахгүй байх.

Жошуа үүнд бага зэрэг сэтгэлээр унав. Тэр ээжтэйгээ хамт зах явах болгонд Христийн мэндэлсний баярын төгс сүлд модыг хайсаар байв. Юмыг яаж мэдэх вэ, тэдэнд гэртээ авч харих мод олдох ч юм бил үү.

Жошуа ээжийнхээ гараас хөтлөлцөн, дараагийн эгнээний моднууд руу алхав. Жошуа уулга алдлаа. Тэрхүү төгс мод яг тэнд байж байх нь тэр!

Тэр түрүүлэн гүйж очоод, модыг барьж үзэв. Тэр мод тийм ч ногоон байсангүй. Сэгсгэр мөчир ч алга. Бас тийм ч өндөр биш байв. Үнэндээ энэ мод таяг тулсан өвгөн шиг бөхийсөн байлаа.

“Ээж ээ, энэ төгс юм байна! Жошуа ийн хэлэв. “Бид үүнийг гэртээ авч болох уу?” Тэгье л дээ?” гэж тэр гуйлаа.

Ээж нь үнийнх нь шошгыг хараад, “За, яах вэ, энэ тийм ч үнэтэй биш юм байна. Манай машинд ч багтах юм байна” гэлээ.

Жошуа тэсэн ядан хүлээж байв. Тэр ээжийгээ модны үнийг төлөхийг хүлээх зуур хүрмийнхээ ханцуйг оролдож байлаа. Удалгүй нэг сайн ах модыг нь машинд оруулахад туслав. Тэднийг гэртээ ирэхэд хойд ах Маттиу, аав хоёр нь модыг машинаас гаргахад тусаллаа. Тэд модыг дотогш оруулж, урд өрөөнийхөө буланд байрлуулав.

“Эхлээд бид гэрлээ зүүх хэрэгтэй” гэж Маттиу хэлэв.

Мод их далий байснаас гэрэл зүүхэд тийм ч амар байсангүй. Маттиу гэрлүүдээ модны дээд хэсгээр, харин Жошуа доод хэсгээр нь зүүлээ. Дараа нь тэд чимэглэлээ өлгөж, эцэст нь аав нь модны орой дээр од тавихад Жошуад туслав.

Аав гэрлийг нь асаагаад, ээжийг мөрөөр нь тэврэлээ. Жошуа мод руугаа харан инээмсэглэв. Модны гэрэл өрөөг бүхэлд нь дулаацуулж, тав тухтай болгож байлаа. Тэр модныхоо доор суун, тод энгийн чимэглэлүүдээ харав.

Мод нь одоо бөхийсөн, өрөвдөлтэй харагдахгүй байлаа. Маш үзэсгэлэнтэй, төгс харагдаж байв!

“Энэ бол Есүсийн төгс мод” гэж Жошуаг хэлэхэд

“Наадах чинь юу гэсэн үг вэ?” гэж ээж нь асуув.

“Манай мод яг Есүстэй адилхан. Тэр хямдхан, тоосонд дарагдсан тэвшинд төрсөн шүү дээ. Манай мод ч бас зах дотор хямдхан, өрөвдөлтэй мод байсан. Гэхдээ одоо мод маань Есүс хэрхэн сүр жавхлант хаан болсонтой адил үзэсгэлэнтэй, сүрлэг харагдаж байна” гэж Жошуаг хэлэхэд,

“Манай төгс Есүсийн мод. Надад энэ үг таалагдаж байна шүү!” гэж аав нь хэллээ.

Жошуа инээмсэглэв. Энэ үнэхээр Христийн мэндэлсний онцгой баяр болохоор байлаа. ●

Энэ түүх Францад болсон юм. Энэ улсын талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл Н6 хуудсыг үзнэ үү.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ МАРК ЖАРМАН

Сайн байна уу? Францаас мэндчилж байна!



Францад Сүмийн 40 000 орчим гишүүн бий.
Францын Парис ариун сүмийг 2017 оны 5-р сард барьж дууссан.



Энэ бол франц хэл дээрх Мормоны Ном.

Франц улс талх, бяслагаараа алдартай. Олон хүн *boulangeries* (талх нарийн боовны газраас) шинэхэн багет худалдаж авдаг.

Францын өмнөд хэсэгт амьдардаг хүмүүс “crèche” буюу Христийн төрөлтийн үйл явдлыг харуулсан узүүлэн хийж, Христийн мэндэлсний баярт бэлтгэдэг. Энэ үзүүлэн Есүс Христийн төрөлтийг хүлээж буй хүмүүсээр дүүрэн байдаг. Тэд Христийн мэндэлсний баярын өмнөх орой crèche-д нялх Есүсийн баримлыг тавьдаг.

Франц дахь бидний зарим найзтай танилцана уу!

Би дуунууд, багш нар, үйл ажиллагаа болон Есүс Христийн талаар сурч мэдсэн зүйлс гээд Хүүхдийн хэсгийн ангийн бүхий л зүйлд дуртай. Ялангуяа хүүхдүүд бусдадаа төрсөн өдрийн мэнд хүргэхэд би дуртай. Би Хүүхдийн хэсгээ долоо хоног бүр тэсэн ядан хүлээдэг.

Жулиэн Б. 10 настай, Франц, Хауте-Гаронне

Миний Мормоны Номын хамгийн дуртай түүх бол Нифай ах нараа уучилж, хайрладаг хэсэг юм. Нифайн үлгэр жишээний ачаар судрын энэ хэсэг намайг ах нартайгаа маргалдах үед тэднээс амархан уучлал гуйж бас уучлахад үнэхээр тус болдог.

Эвэлин Н., 6 настай, Франц, Иль-де-Франс

Парисын Лувр бол дэлхий дээрх хамгийн том урлагийн музей юм. Тэнд 380 000 гаруй урлагийн бүтээл бий.

Франц хүүхдүүд “escargot” гэдэг тоглоом тоглох дуртай ба үүнийг тоглохдоо тэд пүрштэй мэт үсэрч, нөгөө талд нь хүрдэг.

Та Францаас ирсэн үү? Бидэнд захидал бичээрэй! Бид таны хариуг хүлээж байна.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КЭЙТИ МАКДИЙ

Христийн мэндэлсний баярын гэнэтийн бэлэг

Жэйн Макбрайд
(Бодит түүхээс сэдэвлэв)

"Христийн мэндэлсний баярыг гэр бүлээрээ сайхан тэмдэглээрэй! . . . Жилийн туршид зүрх сэтгэлдээ хайраар бялхаарай" (Children's Songbook, *51*).

Анна өрөөнд ороод, Христийн мэндэлсний баярын сүлд модоо харан, сэтгэл нь шимшрэв. Байшингийнх нь ус халаагч буудаж, шалаар нэг ус болсон байв. Аав нь норсон зүйлсийг цэвэрлэх гэж хичээж байлаа. Модон доорх хэдэн бэлэг усанд бүрэн норсон байв.

Анна, дүү нартайгаа алчуур шүүрч аван, бэлгүүдийг хатаах гэж оролдлоо. Гэсэн ч ямар ч үр дүн өгсөнгүй. Бэлгүүд шалба норсон байв.

Аннагийн гэр бүлд хүндхэн үе тохиолдоод байлаа. Аав нь яг одоо ажилгүй байв. Ээж нь удахгүй төрөх гэж байгаа бөгөөд үе үе өвддөг байжээ. Тэд одоо бүр Христийн мэндэлсний баярын бэлэг ч үгүй болов.

Тэр орой Анна орондоо орохоор бэлтгэхдээ, гал тогоонд аав, ээж хоёрынхоо ярилцахыг сонслоо.

“Одоо яах вэ?” гэж ээж нь асуув. Ээж нь уйлж байх шиг байв. “Байрны төлбөрөө хийх хангалттай мөнгө ч байхгүй байхад одоо бүр хүүхдүүддээ өгөх бэлэг ч үгүй боллоо.” Аннагийн дотор нэг тийм хоосон, базлах мэдрэмж төрөв.

Аав нь “Учир нь олдоно доо” гэлээ.

Анна гал тогоонд орж ирэв. Ээж нь охиноо гараа дэлгэн, тэврэлээ. Анна ээжийнхээ гэдсийг тойруулан тэврэхдээ хүүхэд хөдлөхийг мэдрэв. Ээж нь инээмсэглэв. “Удахгүй шинэ хүүхэд төрнө. Та хүүхэд бол гайхамшиг гэж дандаа хэлдэг шүү дээ” гэж тэр хэллээ.

Ээж нь хариуд нь инээмсэглэлэв. “Тийм шүү. Бидэнд талархах зүйл олон бий.

Бүгдээрээ амьд сэрүүн байна шүү дээ” гэж хэлээд, аав нь Аннагийн зулай дээрээс үнсэв. Тэр “Бүх зүйл сайхан болно” гэж хэллээ.

Анна өрөөндөө очих замдаа эрэгтэй дүү нарынхаа уйлалдахыг сонсов. Түүнийг Дэвидийн орон дээр суухад

“Хүн болгон гунигтай байна” гэж Дэвид аяархан хэллээ.

“Бид одоо бэлэггүй боллоо” гэж Робби хамраа шуухитнуулсаар хэлэв.

“Бүх зүйл сайхан болно. Харж л байгаарай” гэж Анна дахин хэллээ.

Анна орондоо орохынхоо өмнө өвдөг сөгдөж, гэрийнхнийхээ төлөө юу хийхээ Тэнгэрлэг Эцэгээс асуув. Түүнд бэлэг авах мөнгө байхгүй ч зүрх сэтгэлд нь халуун дулаан, амар тайван мэдрэмж төрлөө.

Маргааш нь тэр сургуульдаа явахаар бэлтгэж эхлэхийнхээ өмнө хэсэг зуур юм бодон, орон дээрээ хэвтэв. Түүнд нэг санаа орж ирэх нь тэр! Үдээс хойш тэр гэртээ шалавхан ирээд, гэрийн ажил, даалгавраа хийв. Дараа нь тэр цаас, утас, хэдэн маркер болон төрсөн өдрөөрөө авсан наадаг цааснуудаа олж авлаа. Тэр энэ бүхнийг өрөөндөө авч орон, хаалгаа хаав.

Гэрийнхэн нь ямар их баярлах бол гэж бодоод, Анна тэсэж чадахгүй инээмсэглэлээ. Тэр эхлээд цаасыг нугалж, дөрвөн ширхэг бяцхан ном хийхийн тулд утаснуудаар бэхлэн тогтоов. Тэр ээжийнхээ номон дээр од, аавынхаа номон дээр гараг ертөнц наалаа.

Харин Дэвидийн номон дээр нохой, Роббигийн номон дээр пуужин наав.

Дараа нь Анна зурж эхлэв. Тэр ээжийнхээ ном дээр өөрийгөө шалаа шүүрдэж байгаагаар зурлаа. Харин аавынх дээрээ оройн хоол хамт хийж байгаагаар, Дэвидийнх дээр хамт бөмбөг тоглож байгаагаар мөн Роббигийнх дээр ном уншиж өгч байгаагаар өөрийгөө зурав. Бяцхан ном болгоныг зургаар дүүргэхэд хэдэн өдөр зарцуулаа.

Эцэст нь Христийн мэндэлсний баярын өмнөх өдөр ч болж, Анна бяцхан номуудаа модны доор тавив.

Маргааш нь тэр гэрийнхээ бүх хүнд бяцхан номоо өгсөн юм. “Надад зургууд нь таалагдаж байна. Би бөмбөг тоглох дуртай” гэж Дэвид хэлэв.

“Наадах чинь зүгээр нэг зураг биш, эрхийн бичиг юм шүү! Зураг бүр миний та нарт хийж өгөх зүйлсийг харуулж байгаа юм” хэмээн Аннагийн нүд нь гэрэлтсээр хэлэв.

Ээж нь түүний бяцхан номын хуудсыг эргүүлэнгээ, “Энэ чиний бидэнд өгч болох хамгийн сайхан бэлэг байлаа” гэв. Тэнгэрлэг Эцэг өөрт нь Христийн мэндэлсний баярын эрхийн бичиг хийх санаа өгч тусалсанд Анна талархаж байлаа. Шинэ хүүхэд мэндэлнэ. Мөн Тэнгэрлэг Эцэгийн тусламжтайгаар бүх зүйл сайн сайхан болно. ●

Зохиогч нь АНУ-ын Колорадод амьдардаг.



ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КРИС ДАНХЭР

Нөхөрлөлийн бэлэг

Люси Стивэнсон
Сүмийн сэтгүүлүүд
(Бодит түүхээс сэдэвлэв)

Энэ түүх дэлхийн II дайн дууссаны дараахан Англи улсад болсон юм.

Хэрманн Мосснэр ариун ёслолын танхимд ороходоо түгшиж байлаа. Тэр өөрөө бас найзууд нь бүгд “P.O.W.” гэсэн бичигтэй дүрэмт хувцсаа өмссөн хэвээрээ байв. Хүн болгон энэ бичгийг “дайны хоригдол” гэсэн утгатайг мэддэг байлаа. Салбарын гишүүд юу гэж бодох бол? Тэд түүнийг дайснаа гэж үзэх болов уу?

Цуглааны байр Английн Лийдсийн ойролцоо байсан. Хэрманн Английнх биш байв. Харин тэр Герман улсын иргэн байв. Дэлхийн II дайнд дайчлагдсаныхаа дараа Хэрманн английн цэргүүдэд олзлогдож, Англид шоронд орсон байлаа. Тэр удаан хугацааны дараа анх удаа сүмдээ ирсэн нь энэ байв.

Хэрманн нэг сандал дээр суугаад, гүнзгий амьсгаа авлаа. Тэрээр урд сууж буй салбарын ерөнхийлөгч Жорж Каммыг харж байв. Ерөнхийлөгч Камм Хэрманны найз байлаа. Өөр рүү нь хараад инээмсэглэхэд түүнд сайхан мэдрэмж төрөв.

Хэдэн сарын өмнө ерөнхийлөгч Камм Хэрманныг тэнд байгаа цорын ганц Сүмийн гишүүн гэдгийг сонсоод, хуаранд түүнийг зорьж очсон юм. Эхэндээ Хэрманн бага зэрэг санаа зовж байв. Ерөнхийлөгч Камм түүнийг үзэн ядах болов уу? Эцсийн эцэст тэдгээр улс орон дайтахдаа бие биенийхээ эсрэг тулалдаж байсан шүү дээ.

Гэхдээ Хэрманн, ерөнхийлөгч Камм хоёр уулзахдаа хоорондоо инээмсэглэж, гар барилцав. Дараа нь тэд хамтдаа залбирчээ. Тэд дуу дуулж, сайн мэдээний талаар ярилцав. Тэр ч байтугай тэд ариун ёслолоос хамтдаа хүртсэн юм.

Ерөнхийлөгч Каммыг явах болоход Хэрманн “Ах





аа, би танд хайртай” гэж хэлэв. Ерөнхийлөгч Каммд баяртай гэж гараараа даллах үед нүдэнд нь нулимс цийлгэнэхийг тэр харлаа.

Түүнээс хойш ерөнхийлөгч Камм бямба гараг бүр Хэрманн дээр ирдэг байв. Долоо хоногийн бусад өдөр Хэрманн сайн мэдээний дагуу амьдрахыг чадлаараа хичээдэг байлаа. Тэр бусад хоригдолтой хамт талбайд ажиллахдаа тэдэнтэй гэрчлэлээ хуваалцаж байв. Тэр өдөржин ажилласны дараа модоор сийлбэр хийж байхдаа тэдний асуултад хариулдаг байв. Заримдаа тэр тэдэнтэй хамт залбирч байсан.

Нэгэн орой “Хэрманн, би бямба гарагт ноён Камм та хоёртой нэгдэж болох уу? гэж хоригдлуудын нэг нь асуув.

Хэрманн сийлж байсан модноосоо өнгийв. Тэр инээмсэглэлээ. Тэгээд “Мэдээж!” гэв.

“Би ч гэсэн явж болох уу?” гэж өөр нэг хоригдол асуулаа.

Хэрманн, ерөнхийлөгч Камм хоёр олон хоригдолд заах гэж байгаадаа баяртай байв. Удалгүй тэдний зарим нь бүр баптисм хүртэхийг хүссэн гээч!

Одоо Хэрманн сүмийн үйл ажиллагаа эхлэхийг хүлээж байгаа гэр бүлүүдийг тойруулан хараад, амар амгаланг мэдрэв. Зарим гишүүн эхэндээ Хэрманнаас дөлж байсан ч удалгүй хүн бүр түүнд итгэдэг болсон юм. Сайн мэдээний талаар суралцахыг хүссэн бусад хоригдол ч гэсэн Хэрманнтай цуг ням гарагт хуарангаа орхин сүм рүү явах зөвшөөрөл авав. Хожим нь Хэрманн салбарын Ням гаргийн ангийн ерөнхийлөгчөөр хүртэл дуудагджээ.

Цаг хугацаа ч өнгөрч, Христийн мэндэлсний баяр дөхөж байв. Хэрманн өөрт нь сайхан хандаж байсан гишүүдэд талархлаа илэрхийлэх ямар нэгэн зүйл хийхийг хүсжээ. Түүнд нэгэн санаа төрөв. Салбарын Христийн мэндэлсний баярын үдэшлэг болох дөхсөн байлаа. Хэрманн олон дөрвөлжин мод нэмж цуглуулаад, сийлбэр хийж эхлэв. Тэр шоо моднуудаа ээлж дараалан жижиг машин, заан, онгоц, галт тэрэг, морьд болгон хувиргаж байлаа.

Эцэст нь үдэшлэг болох өдөр ч ирэв. Хүн бүр хоол идэж, Христийн мэндэлсний баярын дууллыг хамтдаа дууллаа. Хэрманн хуарангийн найзуудтайгаа хамт Христийн мэндэлсний баярын дууг герман хэл дээр дуулав.

Үүний дараа Хэрманн том цүнх гаргаж ирлээ. Дотор нь 40 ширхэг модон тоглоом байв! Хэрманн Хүүхдийн хэсгийн хүүхэд бүрд нэгийг өгөв. Энэ бол тэдний хувьд хэзээ ч мартагдашгүй Христийн мэндэлсний баяр болсон юм. ●

Хуаранд гурван жил болсны эцэст Хэрманн Герман дахь гэр бүл рүүгээ буцжээ. Олон жилийн дараа Хэрманн дайны хоригдол байхдаа очдог байсан салбартаа эргэж очсон юм. Тэндхийн насанд хүрсэн зарим хүн хүүхэд байхад нь сийлж өгсөн модон тоглоом одоо ч гэсэн байгааг түүнд хэлжээ.





ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ МЭЛИССА МЭНВИЛЛ

Мормоны Номын **уран зургийн үзэсгэлэн!**

ХҮҮХДҮҮДИЙН БОЛОН ЖААЗНЫ ЗУРГИЙГ ГАРИ ЛАКОСТ

Жилийн туршид Мормоны Номын уран бүтээлээсээ хуваалцаж байгаад тань баярлалаа!



8.

11.

14.

15.

12.

16.

9.

10.

13.

1. Фэлипэ Л., 8 настай, Бразил, Сао Пауло
2. Хлоэ Д., 8 настай, Австрали, Куинслэнд
3. Фэрнанда А., 10 настай, Мексик, Чихуахуа
4. Слэйд А., 9 настай, АНУ, Айдахо
5. Лэззи П., 8 настай, АНУ, Пеннсилвани
6. Чарлотт Б., 7 настай, АНУ, Теннессий
7. Эмма С., 8 настай, Венесуэл, Анзоэтэгуй
8. Жэкоб А., 10 насьай, Канад, Алберта
9. Лоурин С., 9 настай, АНУ, Вашингтон
10. Анахи Ф., 8 настай, Уругвай, Кэнэлонэс
11. Мартин С., 5 настай, Аргентин, Жужуи
12. Вилл Б., 8 настай, АНУ, Юта
13. Жоханнэс Х., 10 настай, АНУ, Флорид
14. Андий С., 7 настай, АНУ, Невада
15. Инас С., 9 настай, Португал, Висиу
16. Куала С., 9 настай, АНУ, Калифорни

Максын төлөө залбирсан нь

Ахлагч В.Марк Бассэтт
Далын

Намайг зургаатай байхад манай тойргийн нэгэн ахмад хос өөрсдийн нохой Максад сайн эзэн олж өгөхийг хүсжээ. Манай гэр бүл Максыг хайрлана гэдгийг тэд мэдэж байлаа. Тиймээс бид түүнийг үрчилж авав!

Хэдэн долоо хоногийн дараа найзууд маань манайд хэд хонохоор ирсэн юм. Манай гэрээр дүүрэн хүүхдүүд энд тэндгүй гүйлдэж, тоглож байлаа.

Макс сайхан, анир чимээгүй гэрт дассан тул хүүхдийн чимээ шуугиан ихтэй гэрт байх нь түүнийг маш ихээр тавгүйтүүлж байв. Нэг өдөр бид инээлдэж, тоглож байгаад гэнэт Максыг алга болсныг мэдсэн юм.

Бид Максыг хаа сайгүй хайв. Ээж биднийг аван, ойр хавиар машинтайгаа явж хайх үед нүдэнд минь нулимс хурж байв. Бид Максын хуучин эзэд дээр хүртэл очсон. Гэвч түүнийг хаанаас ч олсонгүй.

Гэртээ буцаж иртэл хэн нэг нь "Максын төлөө залбирцгаая" гэлээ. Бид тойрог болон өвдөг сөгдөн суугаад, энгийн залбирал хэлэв. Бид Тэнгэрлэг Эцэгээс Максыг хаанаас хайх талаар асуулаа.

Биднийг яг "амен" гэж хэлмэгц хувцасны өрөөн дотроос хуцах дуу гарав! Энэ дуу Максынх байлаа!

Тэнгэрлэг Эцэг бидний хүн нэг бүрийг мэддэг бөгөөд хайрладаг. Бидний залбирлын хариулт үргэлж тэр даруй ирэхгүй байж болно. Тэнгэрлэг Эцэг үргэлж бидний хүссэнээр хариулахгүй ч байж болно. Гэхдээ ийм арга замаар бид итгэл, тэвчээрээ хөгжүүлдэг.

Хэрэв танд ямар нэгэн асуудал байвал эсвэл зүгээр л ярилцахыг хүсэж байгаа бол Тэнгэрлэг Эцэг таныг үргэлж сонсох болно! ●



ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АДАМ КОФОРД



Дэлхийг гэрэлтүүлцгээе

Есүс бүх дэлхий ертөнцөд гэрэл, хайрыг авчирсан. Түүний гэрлийг мэдэрч, бусадтай хуваалцахад тань туслах зарим үйл ажиллагааг энд оруулав. Үйл ажиллагаа бүрийг хийж дуусгасныхаа дараа дугаарласан хэсгүүдийг будаарай.

1. Лук 1:26–31-ийг уншаад, "Мариагийн бүүвэйн дуу" (*Хүүхдийн дууны ном*, 28) дууг дуулна уу.
2. Хэн нэгэнд Христийн мэндэлсний баярын карт хийж өгч, "Тэжээлийн тэвшинд" (*Хүүхдийн дууны ном*, 26) дууллыг дуулна уу.
3. Лук 2:4–7-г уншаад, "Иосеф Бетлехем рүү явахдаа" (*Хүүхдийн дууны ном*, 22) дууг дуулна уу.
4. Хэн нэгэнд сайн үйл хийж, "Тэр Хүүгээ илгээсэн" (*Хүүхдийн дууны ном*, 20) дууг дуулна уу.
5. Лук 2:8–18-ыг уншаад, "Hark! the Herald Angels Sing" (*Hymns*, no. 209) дууллыг дуулна уу.
6. Матай 2:1–11-ийг уншаад, "With Wondering Awe" (*Hymns*, no. 210) дууллыг дуулна уу.
7. Есүс Христийн мэндэлсэн талаарх бодол санаагаа ярилцаад, "Амгалан шөнө" (*Сүмийн дуулал болон хүүхдийн дуу*, 53) дууллыг дуулна уу.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БЭТАНИ СТАНКЛИФФ

Хөршийнхний үзүүлсэн Христийн мэндэлсний үзүүлбэр

Лоррэйн Старкс
(Бодит түүхээс сэдэвлэв)

"Хүүхэд бидний тул төрсөн" (2 Нифай 19:6).

Роза өлмий дээрээ өндийсөөр цонхоор шагайв. Найзууд нь тун удахгүй ирнэ!

Жил бүр Христийн мэндэлсний баяраар Роза гэр бүлийнхэнтэйгээ Христийн мэндэлснийг жүжигчлэн үзүүлдэг уламжлал тогтсон байлаа. Тэд хүмүүсийг ирж, нэгдэхэд байнга урьдаг байв. Энэ удаа тэд хөршүүдээ номлогчдын хамт урьсан байлаа. Хөршийнх нь нялх хүүхэд нялх Есүс болох гэж байгаад Роза баярлаж байв.

Бүх зүйл бараг бэлэн болсон байлаа. Ээж нь шарах шүүгээнээс амттангаа гаргаж байв. Розагийн дүү нар бүх тоглоомоо хурааж байлаа. Эллэн өмсгөлүүдийг бэлдэж байв. Тэр ч бүү хэл Роза том, шар од нааж ханаа чимэглэсэн байв.

Ээж нь "Роза" гэж гал тогооноос дуудан, "Чи Эллэнд өмсгөлүүдийг бэлдэхэд нь туслаач?" гэлээ.

"Тэгье ээ, ээж ээ!" Роза баахан бүтээлэг тэврэч явсан эгчдээ туслав.

"Бидэнд бүтээлэг, алчуур, хувцасны шүүгээнээс авсан сольж өмсөх хувцас байна. Бид энэ сагсыг хүртэл тэвш болгон ашиглаж болно шүү дээ" гээд тэр Розад том сагсыг бариулав. Роза нялх хүүхдэд зориулан сагсан дотор зөөлөн хөнжил хийгээд,

"Гайхалтай боллоо" гэв.

Розагийн дүү Жак толгой дээр саарал хөнжил бүтээгээд, нүүрээ инээдтэй болгож байлаа. "Би илжиг болж болох уу?" гэхэд нь

Роза инээгээд, "Үгүй дээ, чи нээрээ инээдтэй шүү! Чи Мэргэн хүн болно гэж байснаа мартчихсан уу?" гэлээ.

"Нээрээ тийм шүү дээ?" гэж Жак хэлээд, тоглоомон титмээ авч, толгойдоо өмсөв.

Төдөлгүй хэн нэгэн хаалга тогшив.

"Тэд ирчихлээ!" Роза ийн хэлээд, "Би хаалга нээе" гэж хэлэв.

Удалгүй байшин баяр хөөртэй хүмүүсээр дүүрлээ. Роза хүн бүрд хувцсаа өмсөхөд нь туслав. Номлогч эгч нар хоньчид болж, түүний ах нар болон эгч нь мэргэн хүмүүс болов. Эгдүүтэй бяцхан хүү нялх Есүс болж, түүний эцэг эх Мари, Иосеф боллоо.

Роза зөөлөн, цагаан малгай өмсжээ. Тэр хонь болсон байв.

Эцэст нь хүн бүр хувцсаа өмсөн, эхлэхэд бэлэн боллоо. Тойргийнх нь номлогч хос болох ахлагч Янси, Янси эгч хоёр Шинэ Гэрээний Төрөлтийн түүхийг гаргав. Тэд шүлгүүдийг чангаар уншлаа. Хүн бүр өөрсдийн хэсгийг жүжиглэн тоглов.

Түүхийн төгсгөлд хүн бүр "Амгалан шөнө" дууг дуулахад, Розад халуун дулаан мэдрэмж төрсөн ба тэр баяртай байлаа. Тэр Ариун Сүнсийг мэдэрч байгаагаа мэдэж байв. Есүс зүрх сэтгэлд нь ойр байгаа мэт түүнд санагдаж байлаа.

Дууны дараа ээж нь "Самуел ба од" видео бичлэгийг үзүүлэв. Эллэнийг залбирал хэлсний дараа тэд амттангаа авчирлаа. Хүн бүр зочилж ирсэндээ баяртай байв.

"За, чамд аль хэсэг нь илүү таалагдсан бэ?" гэж Янси эгчийг асуухад,

"Дуу дуулж, бяцхан Есүстэй тоглох нь надад таалагдсан" гэж Эллэн хариулдаа. Эллэн хүүг өвөр дээрээ авав. Тэр дуулж дууссанаас хойш түүнтэй тоглож байв.

"Надад Есүст бэлэг авчрах хэсэг таалагдсан" гэж Жак хэллээ. Тэр тоглоомон титмээ тайлаагүй хэвээр байв.

"Роза, харин чиний хувьд?" гэж асуухад нь

Роза гараа дэлгээд, "Надад бүх зүйл таалагдсан. Гэхдээ хүн бүр энд Есүсийн мэндэлсний баярыг тэмдэглэхээр цугласан нь хамгийн их таалагдсан. Үүнд л Христийн мэндэлсний баярын утга учир оршиж байгаа юм" гэж чангаар хэлэв. ●

Зохиогч нь АНУ-ын Техаст амьдардаг.

Та энэ жил Есүсийн мэндэлснийг тэмдэглэхдээ хэнийг урьж болох вэ?

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ЖЭЙК ПАРКЭР

Самуел, од хоёр

Эрт урьдын цагт тэнгис далайн цаана Самуел гэгч Бурханы нэгэн эр бошигложээ.

Тэрээр Аврагчийн маань төрөлтийн талаар олон зүйлийг хүмүүст хэлэв. Тэрээр тэдэнд Есүс Христийн талаар мөн Тэр хэрхэн дэлхийд ирэх тухай ярьсан байв.

Хүмүүс түүнийг сонсоогүй. Тэдний зүрх сэтгэл эргэлзээгээр дүүрэн байв. Тиймээс тэд Самуелыг хотын хаалган дээр аваачин, хотоос хөөн гаргав.



Харин Самуел бууж өгсөнгүй. Түүнд тэдэнд хэлэх зүйл байлаа. Тэрээр хотын ханан дээр авиран гарч, тэднийг дээрээс дуудан.

"Ердөө таван жилийн дараа Их Эзэн од түгсэн шөнөөр хүн төрөлхтнийг бүх гэм нүглээс нь аварч, Өөрийн гэрлийг дэлхийд түгээхээр залран ирнэ.

Хэдийгээр энэ нь таван жилийн дараа, цаг нь болох болоогүй мэт санагдавч нар жаргаж, шөнө болсон ч өдөр мэт гэрэлтэнэ” хэмээв.



Хүмүүс ихэд уурлаж, хөлөө дэвсэлж байлаа. Тэд ямар ч Христ ирэхгүй гэцгээв. Мөн чулуу шидэцгээж байв. Тэд сумаар түүнийг харважээ. Гэвч нэг нь ч түүнийг оносонгүй.

Итгэгчид алтнаас илүү үнэт зүйлсийг буюу од, гэрэл зэргийг мөн амлалтууд биелэхийг харна гэсэн найдвар тээн, амьсгаа даран хүлээж байв.

Таван жилийн дараа Христ Бетлехемд, малын тэвшин дотор хэвтэж байлаа. Тэд гэрлийг харж, Аврагчийг, бүхний Эзэн Түүний ирснийг мэдсэн.

Үргэлж улиран тохиодогчлон, бошиглогчдыг ийн зоригтой байх үед Их Эзэн эрт дээр үед Самуелын өгсөн амлалтыг биелүүлсэн шиг Өөрийн амлалтуудыг бас биелүүлдэг. ●

Та энэ видео бичлэгийг bit.ly/3cz7F2j хаягаар орж үзэж болно. Эсвэл энэ түүхийг Хиламан 13–15; 3 Нифай 1:13–15, 21-ээс уншиж болно.

Моронай бидэнд зориулан судруудыг хадгалсан

Бошиглогч Мормон Есүсийн тухай нэгэн номыг эмхэтгэсэн юм. Тэр үүнийг алтан ялтаснууд дээр бичжээ. Мормон нас барахынхаа өмнө өөрийн хүү Моронайгаас уг номыг харж хамгаалахыг хүсэв.

Моронай аавынхаа хүссэнээр үйлдэж, ялтаснуудыг аюулгүй газарт хадгалав. Заримдаа тэр ёс бус хүмүүсээс нуугдах шаардлага гарч байлаа. Тэр заримдаа ганцаарддаг байсан. Гэвч уг ном маш чухал гэдгийг мэдэж байв.



Есүс Моронай дээр айлчлан иржээ! Тэрээр уг ном та бидэн шиг олон хүнд хэрхэн туслахыг Моронайд харуулав. Моронай ялтаснууд дээр өөрийн гэрчлэлийг нэмсэн юм. Тэр бидэнтэй хамт байгаа мэт бидэнд хандан бичсэн.

Бурхан Моронайд ялтаснуудыг аюулаас хол хадгалахын тулд газарт бул хэмээн хэлжээ. Олон жилийн дараа Иосеф Смит ялтаснуудыг орчуулав. Одоо эдгээр нь Мормоны Ном болон хэвлэгдсэн.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АПРИЛ СТОТТ

Мормоны Номыг надад зориулан бичсэн юм! Энэ ном миний ямар ч асуудалд тусалж чадна. Энэ бол Бурханаас өгсөн бэлэг билээ. ●

Энэ тухай Мормон 8-аас болон Мормоны Номын оршил хэсгээс олж уншаарай.

Мормоны Номыг надад зориулсан!

Чи энэ жил Мормоны Номоос юу сурч мэдсэн бэ?

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АПРИЛ СТОТТ

ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

Эрхэм хүндэт эцэг эхчүүд ээ,

Энэ сарын сэтгүүл бүхэлдээ бэлгийн талаар юм. Танай гэр бүлд барихаар ажиллаж буй олон бэлгийн маань нэг нь танай хэл дээр гарах бүрэн хэмжээний *Найз* сэтгүүл юм.

2021 онд *Найз* сэтгүүлээс хүсэн хүлээж болох хэд хэдэн зүйлийг дурдвал:

- Дэлхий даяарх хүүхдүүдийн хамтдаа үйлдэж, Есүсийг дагах сар тутмын уриалга
- Олон улс орны анхдагчдын түүх
- Сүмийн түүхийн карт
- Дэлхийн өнцөг булан бүрд байх хүүхдүүдийн түүх байх болно.

*Лиахонаг*ийн шинэ хувилбарт *Найз* сэтгүүл багтаагүй учир та *Найз* сэтгүүлийг store.ChurchofJesusChrist.org хаягаар орж, эсвэл орон нутгийн Сүмийн хангамжийн төв дээр очин захиалах боломжтой. Таны *Лиахонаг*ийн захиалах хугацаа хоцорсон байсан ч шинэ *Лиахона* руу автоматаар нэмэгдэж орох болно.

Хүндэтгэсэн,
Найз

Дотор нь нуусан Лиахонаг олоорой!

АГУУЛГА

H2 Тэргүүн Зөвлөлөөс: Есүсийг хайрлах хайрын бэлэг

H4 Төгс мод

H6 Сайн байна уу, Францаас мэндчилж байна!

H8 Христийн мэндэлсний баярын гэнэтийн бэлэг

H10 Эр зоригийн үлгэр жишээ: Нөхөрлөлийн бэлэг

H12 Мормоны Номын уран зургийн үзэсгэлэн!

H14 Найзаас найзад: Максын төлөө залбирсан нь

H15 Зугаатай ажил: Дэлхийг гэрэлтүүлцгээе

H16 Хөршийнхний үзүүлсэн Христийн мэндэлсний үзүүлбэр

H18 Самуел, од хоёр

H20 Судрын түүх: Моронай бидэнд зориулан судруудыг хадгалсан

H23 Будах хуудас: Мормоны Номыг надад зориулсан!

***НАЙЗ* СЭТГҮҮЛИЙН ХАВТСАН ДЭЭР**
Зураг чимэглэлийг Катлин Питэрсон

© 2020 BY INTELLECTUAL RESERVE, INC. БҮХ ЭРХ ХАМГААЛАГДСАН

MONGOLIAN
4 02167 27363 9